



**МОНГОЛБАНКНЫ
ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Утас 31-04-07, Факс: (976-11) 31-14-71

2023. 03. 22 № 4

танай _____-ны № _____-т

**УИХ-ЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА Ц.ЦЭРЭНПУНЦАГ
ТАНАА**

Монголбанкны Хяналтын зөвлөлийн 2022 оны үйл ажиллагааны тайланг холбогдох санал, дүгнэлт, мэдээллийн хамт хүргүүлж байна.

Хүлээн авч танилцана уу.

Хавсралт: ...60.... хуудас

Хүндэтгэсэн,

ДАРГА  Д.ДАВААСАМБУУ

ТУС1062

МОНГОЛБАНКНЫ
ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН
2022 ОНЫ ТАЙЛАН

2023 ОН

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛИЙН 2022 ОНЫ АЖЛЫН ТАЙЛАН

2023 оны ... сарын ...-ний өдөр

Улаанбаатар хот

НЭГ. Ерөнхий зүйл.

Монголбанкны Хяналтын Зөвлөл (цаашид МБХЗ гэж товчилно)-ийн 2022 оны үйл ажиллагаа нь Монголбанкны тухай хууль болон Хяналтын зөвлөлийн ажиллах журам, Зөвлөлийн дотоод дүрэм, ажлын төлөвлөгөөний дагуу явагдлаа. МБХЗ нь Монголбанкны удирдлага, бүтцийн нэгжүүд, тэдний ажилтнууд, үүний удирдлагуудын дэмжлэгийг тухай бүрдээ авч 2022 онд тавьсан зорилтоо амжилттай хэрэгжүүлээ.

Монголбанкны санхүүгийн тайлан, орлого, зарлагын байдал, хөрөнгийн хүрэлцээ, алдагдлын шалтгаан нөхцөл, авлага, зээлийн хүү, ханшийн зөрүүний асуудал, мөнгөний бодлогын үр дүн, банкны актив дахь дотоод, гадаад хөрөнгө оруулалтын багц, дотоод аудит, хөндлөнгийн аудит, эрсдэлийн удирдлага, Монголбанкны өөрийнх нь төсөв, түүний зарцуулалт зэрэг өргөн цар хүрээтэй асуудлуудыг авч үзэж, санал дүгнэлт гаргаж ажилласан.

МБХЗ нь 2022 онд 6 удаа хуралдаж Дэлхий дахиныг хамарсан Ковид-19 цар тахлын сөрөг нөлөөллийг саармагжуулах, улс орныхоо мөнгө санхүүгийн тогтвортой байдлыг хангах, гарч болох аливаа эрсдэлээс сэргийлж хамгаалах, төгрөгийн тогтвортой байдлыг хангах гол үндэс болсон гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалт, мөнгөн хөрөнгийн өгөөжийг нэмэгдүүлэх, гадаад өрийн дарамтыг хөнгөвчлөх, улсын зээлжих зэрэглэлийг сайжруулах, мөнгө угаах, хууль бус санхүүгийн гүйлгээнээс сэргийлэх, аудит, дотоод хяналт, засаглал Монголбанкн дахь арилжааны банкуудын болон тэдний өөрсдийн хөрөнгийн зээлжилтийг нэмэгдүүлэхэд төрөөс дэмжлэг үзүүлэх, мэргэжлийнх нь чадварыг ашиглах замаар улсын эдийн засгийг сэргээх зэрэг асуудлуудад илүүтэй анхаарал тавьж, эдгээр асуудлаар санал солилцон, хамтран ажиллаа.

Засгийн газраас бонд гаргах нь зөвхөн төсвийн алдагдлыг нөхөх гэдэг утгаар нь бус, экспортыг дэмждэг, эдийн засгийн суурь нөхцлийг бүрдүүлэх цахилгаан, дулаан, төмөр зам зэрэг үйлдвэрлэлийн дэд бүтэц, үйлдвэржүүлэлтийн томоохон төслүүдийг урагшлуулах чиглэлээр хэрэгжүүлбэл зохих нэн чухал арга хэмжээ болохыг Засгийн газарт ойлгуулж хамтран ажиллахыг, мөн түүнчлэн хувийн хэвшлийн бонд, өрийн хэрэгслийг авч үзэж, тэдгээрийн үнэлгээ, үр ашгийг нэмэгдүүлэх чадавхийг сайжруулах үндсэн дээр мөнгө нийлүүлэх тухай асуудал чухал гэдгийг Монголбанкны мэргэжилтнүүдэд Хяналтын зөвлөлөөс тэмдэглэн зөвлөлөө.

Санхүүгийн тогтвортой байдлыг хангах үүднээс гадаад дотоодын мөнгөн хөрөнгийн нөөцийг бүрдүүлэхэд Монголбанк санаачлагатай ажиллаж, цар тахлын болон түүний дараах үеийн эдийн засгийн сэргээхэд шаардагдах хөрөнгийг банкны систем үндсэндээ хангаж байгааг нааштай үнэлсэн. Улсын хэмжээнд зээлийн хүү нийтдээ нэлээдгүй буурч, Монголбанкн д төвлөрсөн арилжааны банкуудын хөрөнгийн зарим хэсгийг мөнгөний бодлогын хэрэгжилтийг хангах дунд урт хугацааны хэрэгслээр дамжуулан эдийн засагт оруулж буйг улам ахиулж, үр өгөөжтэй болгохыг зөвлөж ирсэн. Үүний зэрэгцээ Монголбанк өөрийн захиран зарцуулж буй актив, пассивын хөрөнгийн хүүгийн зөрүүгээр алдагдал гаргахгүй байх, бодлогын хүүнээс доогуур зээл олгох нь хүүний нэгдсэн бодлогын агуулга, зарчмыг алдагдуулж, санхүү эдийн засагт гажиг тогтолцоо гарах, улмаар зээлийн үйл ажиллагаанд бүх төрлийн авилга үүсэх нөхцөл бүрдэж, банкны төлбөрийн чадварт сөрөг нөлөөтэй болохыг удаа дараа анхааруулсан. Монголбанкны засаглалд татвар төлөгчдийн эрх ашгийг хамгаалах механизм, эрх зүйн орчин байхгүй, өөрийнх

нь хөндлөнгийн хяналт сул, мөн арилжааны банкуудыг залж удирдахдаа хөндлөнгийн хяналт үнэлгээг хязгаарлаж байгаа нь эцсийн дүндээ удирдлагын үндсэн горим алдагдаж, улс хохирч, Монголбанкны алдагдал улам өсөх, улстөрчдийн нөлөөнд орох магадлал өндөр байгаад сэтгэл зовниж буйгаа илэрхийлж, тухай бүрд нь анхааруулж ирсэн. Аливаа орны төв банкны үндсэн үүрэг бол арилжааны банкуудын санхүүгийн чадварыг бэхжүүлж, дэмжихэд оршдог. Үүнийг Төв банкууд Сангийн яамтайгаа хамтран хийдэг дэлхийн жишиг Монгол улсад төдийлэн хэвшил болж чадахгүй байгааг анхаарч цаашид энэ тогтолцоог халах, сууриа эрх зүйн хүрээнд баталгаажуулах зайлшгүй шаардлага бидэнд байна.

- МБХЗ-ийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа 2023 онд дуусаж байгаатай холбогдуулан 2017 оноос 2022 оны 3 дугаар улирал хүртэлх хугацаанд Хяналтын Зөвлөлөөс гаргасан зөвлөмж, шийдвэрүүдийн хэрэгжилтийг тайлант онд авч үзэж хэлэлцлээ. (МБХЗ-ийн шийдвэрийн биелэлтийн тухай Хавсралт 1). Нийт санал зөвлөмжийн хэрэгжилтийг нэгтгэн үзэхэд 50 санал, зөвлөмжөөс 42 нь 100 хувийн биелэлттэй, 8 санал зөвлөмж 30-аас 90 хувийн хэрэгжилттэй гэсэн дүн мэдээ гарсан. Хавсралтаас үзэхэд Монголбанк санхүүгийн тайлан тэнцлийг үндэсний болон олон улсын стандартын дагуу гаргах, хөрөнгө оруулалтын багц дахь валютын нөөцийн удирдлагыг сайжруулах, Монголбанк болон арилжааны банкуудын хөрөнгө, нөөц бүрдүүлэх, мөнгөний бодлогын хэрэгжилтийг шинэ арга хэрэгслээр хангах, төлбөрийн тэнцэл, экспортын үйлдвэрлэл, валютын ханшийн болон эдийн засаг, санхүүгийн талаарх нийтийн боловсрол, мэдээллийн баазыг өргөжүүлэх зэрэг асуудлуудаар МБХЗ-өөс өгсөн санал зөвлөмж амжилттай хэрэгжсэн нь харагдаж байна. Мөн дараах асуудлууд дутуу биелэлттэй байна. Үүнд: Монголбанк өөрийн үйл ажиллагаандаа эрсдэлийн, ялангуяа улс төрийн нөлөөллийн үнэлгээ хийж, эрх зүйн зөв тогтолцоо бүрдүүлэх, Монголбанкны дотоод аудитын хамрах хүрээ, эрх хэмжээ, хяналт шалгалтын үйл ажиллагааг төгөлдөржүүлэх, дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон банкинд ажиллаж буй Монголбанкны эрх хүлээн авагчдын ажлын үр дүн болоод цаашдын үйл ажиллагаанд эргэлт хийх, банкны эздийг, зээлдэгч нарыг хохирол барагдуулахад хэрхэн татан оролцуулах, зээлдэгчдийг дэмжин өр төлүүлэх арга механизмыг боловсронгуй болгох, олон улсын туршлага судлах талаар анхаарч ажиллахыг санал болгосон байна. Монголбанкны хэмжээнд биелсэн гэж тооцогдож байгаа 2018 онд Монголбанкны хуульд оруулах өөрчлөлтөөр Монголбанкны Зөвлөлийг олон улсын жишгийн дагуу удирдах зөвлөл болгох гэсэн санал шийдлээ олоогүйгээр барахгүй МБХЗ-ийн эрх хэмжээ тодорхой хэмжээгээр хумигдсан юм. Тухайн үед МБХЗ-өөс дараах санал өгч байсан юм.

Санал №1: Монголбанкныг бие даасан, улс төрөөс ангид, мэргэжлийн байгууллагын хүрээнд ажиллуулах гүйцэтгэх/удирдах/ зөвлөл, ялангуяа дээд удирдлагаас улс төрийн шинжтэй шийдвэрийг зогсоох эрх зүйн чадамж бүхий мэргэжлийн Гүйцэтгэх/Удирдах/ Зөвлөл байгуулах, ажиллах журмыг боловсруулан УИХ-аар батлуулахад онцгой анхаарах, ялангуяа хөндлөнгийн цөөн гишүүд, Монголбанкны гүйцэтгэх удирдлага оролцсон Зөвлөлтэй болж, мөнгө, зээл, банк, санхүүтэй холбоотой асуудлыг эцэслэн шийддэг, дээд удирдлагын зарим эргэлзээтэй санал зөвлөмжийг зогсоох чадвартай болох хэрэгтэй гэж үзлээ.

- 2022 оны хувьд Олон Улсын Валютын Сангийн “Аюулгүй байдлын үнэлгээ”-ний судлаачдын баг (Safeguards assessment mission) Монголбанк, түүний дотор МБХЗ-ийн өнөөгийн үйл ажиллагаа хийгээд 2017 онд энэ чиглэлээр өгсөн санал зөвлөмжийн хэрэгжилтэд ихээхэн ач холбогдол өгч, урьдчилан асуулга ирүүлж, тэдгээрийн хариу, бидний тайлан мэдээллийг урьдчилан авч, улмаар газар дээрх уулзалт ярилцлагыг хийж 2022 оны 8 дугаар сарын 22-оос 9 дүгээр сарын 1-ны хооронд ажилласан билээ. Тэдний тайлангийн гол агуулгыг танилцуулах зүйтэй гэж үзлээ. “Монголбанкны тухай хуульд

өөрсдөө засаглах удирдлага, засаглалын гол зарчим нь хуулийн өмнөх өөрчлөлтүүдээр шийдэгдэх чадаагүйн дээр Парламент, Засгийн газрын даалгавар-шийдвэрээр эдийн засгийн хөгжил дэх Монголбанкны төсвийн шинжтэй үүрэг нэмэгдсэний улмаас Монголбанк дахь санхүүгийн аюулгүй байдлын эрсдэл улам нэмэгдсэн байна. Үүний гол үр дагавар нь Монголбанкны өөрийн хөрөнгийн нэвэр алдагдал ихээхэн өссөнд оршиж байна. Засаглалын бүтцээр эрх хэмжээ Ерөнхийлөгчид илүүтэй төвлөрсөн нь бие даасан үр нөлөө бүхий удирдлагын хэрэг-зөвлөл хяналт тавьж, тэнцвэржүүлэх бодомжийг хязгаарлаж байна. Монголбанкны тухай хуулийг бэхжүүлэх реформ-шинэчлэл хийх, засаглалын зөв бүтэц бүрдүүлэх, төсвийн шинжтэй үйл ажиллагаа явуулахыг хариулах, Монгол банкыг дунд хугацаанд дахин хөрөнгөжүүлэх хэрэгтэй болжээ "гэж дүгнэжээ. ОУВС-ийн дээр дурдсан тайланд тусгагдсан зарим зөвлөмжийг сийрүүлбэл:

1. Монголбанкны эрх зүйн хүрээ, ялангуяа өөрсдөө засаглах удирдлага, засаглалтай холбоотой зүйл заалтуудыг бэхжүүлэх хэрэгтэй.

Хууль эрх зүйн техникийн туслалцааны хүрээнд Монголбанкны тухай хуульд 2018 онд өөрчлөлт орсон боловч Парламент, Засгийн газраас эргэж буцсаны улмаас бүх зөвлөмжүүд биелэлээ олоогүй бөгөөд томоохон зөрчил дутагдал байсаар байна. Тухайлбал, Монголбанкны тухай хуулиар давамгайлах практикуудын эсрэг хөгжлийн үүргийг ногдуулсаны зэрэгцээ ерөнхийлөгчийн өргөн хүрээтэй менежментийн болон бодлогын шийдвэрлэх эрхийг өргөжүүлсэн нь Монголбанкны ажилд бие даасан ажиглалт-хяналт хийх боломж олгоогүй байна. Үүний дээр Үндсэн хуулийн заалтаар Парламент санхүү, мөнгө, татвар, зээлийн бодлогыг тодорхойлно гэснээр Монголбанкны суурь үүргийг хамруулсан, бас төсвийн шинжтэй үйл ажиллагааг явуулахыг үүрэгжүүлсэн шинжтэй мөнгөний бодлогын чиглэлийг парламентаас баталдаг. Бас нэг зүйл бол Банкны тухай хуульд саяхны оруулсан өөрчлөлтөөр татан буугдсаны банкны эцсийн эрсдэлийг Монголбанк хариуцахыг баталгаажуулжээ. ОУВС-ын өмнөх зөвлөмжийн (Хавсралт 2)-ач холбогдол хэвээр байгаа бөгөөд Монголбанкны хувьд хийх дараагийн алхам бол ОУВС-тай зөвлөлдөж, хуулийн өөрчлөлтийг эцэслэн боловсруулж, Засгийн газар-кабинетэд оруулах явдал болно. Нэмж хийх бас нэг зүйл бол арилжааны банкны санхүүгийн найдвартай ажиллагааг хангах чиглэлээр Сангийн яамтай хамтарч Банкны тухай хуулийг дахин авч үзэх хэрэгтэй гэжээ.

2. Хяналтын Зөвлөлийн бүрэн эрх буюу мандат нь хязгаарлагдмал бөгөөд бусад төв банкуудын дэргэдэх жишмэл бие даасан хяналтаас хоцрогдсон байна.

Нягтлан бодох бүртгэл, хууль эрх, эдийн засгийн суурь боловсролтой 7 гишүүнээс бүрдсэн Хяналтын зөвлөл хяналт явуулж байна. Гэвч Хяналтын зөвлөлийн хяналтыг хязгаарлагдмал хэмжээнд тодорхойлсон, Зөвлөлийн гишүүд бүгдээрээ Парламентаас томилогддог, Монголбанк, Хяналтын зөвлөл хоёулаа адилхан Парламентын бүтцийн байгууллагад ажлаа тайлагнадаг болохоор Монголбанкны итгэлийг хүлээх хэмжээний үүрэгтэй байх нь учир дутагдалтай болно. Түүнээс гадна Хяналтын зөвлөлийн хуулиар тогтоосон ажлын хүрээ нь бусад төв банкуудад жишмэл байдлаар хэрэгждэг үйл ажиллагааны хяналт, эрсдэлийн удирдлага, дотоодын хяналт шалгалтын тогтолцоо зэргийг хамруулаагүй байна. Иймээс төв банкны итгэлийг хүлээх бие даасан хяналтын байгууллагад нийцэх хуулийн шинэчлэл хэрэгтэй болжээ. Ийм байгууллага байхгүй учраас Хяналтын зөвлөл эхний ээлжинд эрсдэлийн менежмент, дотоодын хяналт явуулах, гадны аудиторыг

томилоход оролцохгүй байх зэрэг зарим ажиллагааг оролцуулсан бие даасан хяналтыг чангатгах нь зүйтэй болно.

3. Ижил тэнцүү эрхтэйгээр шийдвэр гаргадаг ажил хоцрогдож байгаа нь засаглалын бас нэг сул тал болно. Монголбанкны дэргэдэх засаглалын гол бүрэлдэхүүн гэвэл Ерөнхийлөгч, түүний тэргүүн болон дэд ерөнхийлөгчид, газар хэлтсийн дарга нараас бүрдсэн удирдах зөвлөл болон Хяналтын зөвлөл байна. Мөнгөний бодлогын хороо өөрсдөө шийвэр гаргах эрхтэйгээр байгуулагдсан нь зөв чиглэлд хийгдсэн алхам болжээ. Менежментийн өргөн хүрээний эрх, зээлийн хүү, засгийн газарт болон банкуудад баталгаа гаргах, хөрөнгө оруулалтын стратеги, санхүүгийн тайлан балансыг батлах зэрэг эрх Ерөнхийлөгчид төвлөрсөн хэвээр байна. Нийт шийдвэр гаргалт, Ерөнхийлөгч болон засаглалын гол бүрэлдэхүүний өөрсдөө бие даасан байдлаар шийдвэр гаргах эрх хэмжээг тусгасан эрх зүйн шинэчлэл хэрэгтэй болно.

4. Цар тахлын эсрэг хууль болон Парламент, Засгийн газрын шийдвэр чиглэлийн дагуу төсвийн шинжтэй бөгөөд татаастай үйл ажиллагаа явуулах нь Монголбанкны хөрөнгийн байдлыг ихээхэн сулруулж, санхүүгийн чадавхийг бууруулж байна. Эдгээр ажиллагаанд (i) Үнэ тогтворжуулах хөтөлбөр, түүний дагуу арилжааны банкуудад олгодог нийтийн зориулалттай татаас бүхий зээл, (ii) өндөр насны тэтгэврийн зээл тэглэх зориулалттай сан, (iii) уурхайгаас түүхий алт худалдан авах (iv) Төв банк дараа нь алт худалдан авахаар компаниудад зээл олгох зэрэг багтаж байна. Судлаачдын баг дунд хугацаанд төсвийн шинжтэй ажиллагаа явуулахыг зогсоох болон дахин хөрөнгөжүүлэх төлөвлөгөөг Засгийн газартай тохирохыг зөвлөмж болгож байна.

ОУВС-аас анхааруулж буй дээрх асуудлуудыг 2017 оноос Монголбанкинд тавьж ирсэн бөгөөд банкны удирдлагуудын эрх хэмжээний асуудал хөндөгддөг, мэргэжлийн түвшинд сайтар шүүн тунгааж хэлэлцэгдэхгүй өнгөрөөд байна гэсэн ойлголттой байгаа. Монголбанкны хуулийн шинэчлэлийн хүрээнд МБХЗ-ийн бүрэн эрх зайлшгүй хөндөгдөн яригдсаар ирсэн билээ. МБХЗ-ийн анхаарал татсан, зайлшгүй хэлэлцэх шаардлагатай зарим асуудал байсан ч УИХ-аас 2003 онд баталсан “Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ын заалт нь Төв банкны тухай хуулийн заалттай нийцэхгүйн улмаас олон улсын байгууллага, экспертүүдийн санал зөвлөмж, дэлхий нийтийн сайн жишгийн хэмжээнд хүртэл ажиллах боломж хязгаарлагдмал байна. Хяналтын зөвлөлийн гишүүдийн зүгээс санаачлага гарган сүүлийн 3 жилийн хугацаанд Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцэхгүй байгаа Хяналтын зөвлөлийн ажиллах журамд өөрчлөлт оруулж Монголбанкны эрх зүйн орчин ялангуяа Хяналтын зөвлөлийн чиг үүргийг боловсронгуй болгох, Олон Улсын Валютын сангийн зөвлөмжид нийцүүлэн дэлхий нийтийн төв банкны жишгийг дагах, үүний тулд олон улсын туршлага судалж, судалгаа хийж, Хяналтын зөвлөлийн статус эрх мэдлийг нэмэгдүүлэх зайлшгүй шаардлагатай гэсэн дүнэлтэд хүрч, саналаа МБХЗ-ийн тайлангийн хамтаар Байнгын хороонд хүргүүлсэн. (Дахин хүргэв. Хавсралт 3)

Хуулийн үзэл баримтлалын зарим санааг доор сийрүүлье.

Өнөөгийн хууль тогтоомжоор зарим зүйл зохицуулагдаагүй байгаа юм. Монголбанк өөрөө арилжааны банкуудтай хэрхэн ажиллаж тэнд хийгдэж буй ажил нь орчин цагийн шаардлага, зохих журмын дагуу явагдаж буй эсэх хийгээд Монголбанкны дэргэд шинээр байгуулагдсан Хяналт шалгалтын хорооны үйл ажиллагааны үр дүнг авч хэлэлцэх зэрэг эрх хэмжээ Хяналтын Зөвлөлд өгөгдөөгүй байгаа юм. Монголын Улсын санхүүгийн тогтолцооны үндсэн цөм, хадгаламж эзэмшигчид, аж ахуй эрхлэгчдийн итгэл найдвар болсон арилжааны банкуудыг Монголбанк зөв удирдах нь нийгмийн шаардлага, хүлээлт билээ. Тиймээс

Хяналтын зөвлөл нь Монголбанкны үйл ажиллагаа, түүний дотор арилжааны банкуудыг удирдах чадварт хөндлөнгийн дүгнэлт өгч байх нь чухал юм.

- Монголбанкны хуульд Хяналтын зөвлөл нь Монголбанкны захирлуудын зөвлөлийн үйл ажиллагааны ажлын үр дүнд санал дүгнэлт өгнө гэж байгаа боловч түүгээр дамжуулан Хяналт шалгалтын хорооны ажил хэр зэрэг явагдаж байна гэдэгт дүгнэлт өгөх боломжгүй нь Хяналтын Зөвлөлийн ажлын явцаас харагдаж байна. Учир нь хууль зүйн талаасаа уг асуудал шийдэгдээгүй байна. Монголбанкны хараанд байдаг Хяналтын хороо нь Монголбанкны зүгээс зөвшөөрөл авч ажилладаг арилжааны банк болон бусад санхүүгийн системд дүгнэлт өгдөг нь тодорхой хэмжээний болгоомжлол төрүүлж байдаг байна. Иймээс зохих эрхийг Хяналтын зөвлөлд хуулиар олгох нь зүйтэй гэж үзэж, Монголбанкны тухай хуульд “Зөвлөлийн ажиллагааны үр дүнд хяналт хийж, үнэлгээ өгнө” гэдгийг Хяналт шалгалтын Хороонд хамруулах хуулийн заалт нэмэхээр хуулийн төсөлд тусгав
- Мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх асуудалд Хяналтын зөвлөл оролцдоггүй, үүнийг олон улсын практик, манай хууль баталж байгаа. Гагцхүү мөнгөний бодлогын хэрэгжилтийг хангадаг хэрэгслүүдийн ашиглалт, түүний үр дүнг зохих ёсоор авч үзэх ёстой. Өдгөө бид Монголбанкны удирдлага, зохих газар хэлтсүүдтэй тохиролцсоны дагуу мөнгөний бодлогыг голчлон хэрэгжүүлж байгаа газар хэлтсүүдийн үйл ажиллагааны үр дүнд дүгнэлт өгч байгаа. Тодруулбал, хуулиар олгогдсон хөрөнгө оруулалтын багцийг хянах эрхийн хүрээнд Монголбанкны нийт хөрөнгө, нөөц, эх үүсвэрийн ашиглалт, удирдлагын талаар мэдээлэл сонсгол авч, зөвлөмж чиглэл өгч ажиллаж байгаа. Гэхдээ үүнийг эрх зүйн хувьд нь шийдэх шаардлагатай. Ийм учраас зөвхөн Хяналт шалгалтын хороо гэлтгүй Мөнгөний бодлогын хорооны үйл ажиллагааны үр дүн, шийдвэрийн хэрэгжилтийн байдалд санал дүгнэлт өгч байх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Мөн Хяналтын Зөвлөлийн эрхлэх ажлын хүрээнд Монголбанкны хөрөнгийн удирдлага, ашиглалтад хяналт тавих гэдгийг хуульчлахаар санал боловсруулав.
- Хяналтын зөвлөлийн эрх хэмжээнд хуулиар олгогдоогүй, гэхдээ нийгэм, олон нийтээс, УИХ зэрэг удирдах байгууллагын хүрээнд асуугдаж яригддаг зүйл бол мөнгө угаах, терроризмтой тэмцэх талаар хийж буй ажилд хөндлөнгийн хяналт, дүн шинжилгээ өгөх явдал байгаа юм. Энэ ажиллагааны үр дүнг авч үзэх гэж бид хэд хэдэн удаа оролдсон боловч эрх хэмжээ хүрэлцэхгүй байгаа учраас үүнийг цаашид яах вэ гэдэг асуудал тулгараад байгаа юм. Тэгэхээр нэгэнт Монголбанкны дэргэд Санхүүгийн мэдээллийн алба ажиллаж байгаа учраас энэ албаны ажлын үр дүнг ямар байгаад санал дүгнэлт өгдөг, тэдний мэдээллийг сонсдог болох нь зүйтэй байгаа юм. Ийм чиглэлээр хуулийн төсөлд санал оруулж байгаа.
- Олон улсын байгууллагууд, ОУВС болон бусад гадаадын байгууллага, судлаачдын өгсөн санал зөвлөмжийн дагуу зарим зүйлд онцгойлон анхаарах шаардлагатай гэж үзэж байгаа. Монголбанкны Хяналтын Зөвлөлийн дарга, гишүүдтэй ОУВС-ын холбогдох ажлын хэсэг, олон улсын зөвлөх судлаачид уулзаж, зөвлөгөө өгдөг. Эдгээрээс үзэхэд төв банкны засаглал, эрх үүргийн нэгдлийг хэрхэн хангах, хяналт шалгалт, дотоод аудит, эрсдэл, хуулийн нийцэл, Хяналтын Зөвлөлийн эрх хэмжээ, түүний шийдвэрийг хэрэгжүүлэх арга зам, ямар асуудлаар Хяналтын зөвлөл давуу эрхтэй байх зэрэг олон асуудлуудыг харж болно. Тэгэхдээ Монголынхоо нөхцөлд тохирсон цөөхөн асуудлыг шийдэх санал оруулж байгаа болно.
- Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагааг илүүтэй Хяналтын зөвлөлийн эрхлэх ажиллагааны хүрээтэй хамтад нь хийх. Тухайлбал Хяналтын зөвлөл нь Дотоод аудитын газрын захирлыг нь томилж бас халах эрхтэй. Ерөнхийлөгч бол санал оруулах эрхтэй. Мөн дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, хийх ажлын жагсаалтыг

Хяналтын зөвлөл гаргаж байх ёстой. Өөрөөр хэлбэл Дотоод аудит нь Хяналтын зөвлөлийн шууд удирдлагад ажиллах, гэхдээ орон тоо цалин, бусад асуудлыг Монголбанкны хүрээнд шийдвэрлэж явдаг байх. Төв банкны хууль, Хяналтын зөвлөлийн ажиллах журамд дээр дурдсан санааг тусган, ХЗ-ийн эрх хэмжээг сайжруулах боломж бий гэж үзэж байна.

- Хяналтын зөвлөлөөс хийх шалгалт, Дотоод аудитын газраар дамжуулж хийх шалгалтын нэр төрлийг урьдчилан баталж гаргаж байвал ийм шалгалт хийгдэх нь байна гэдэг зүйлийг Монголбанкны дээд удирдлага, газар хэлтсүүд мэдэж байх нь хөндлөнгийн хяналтын нэгэн хэлбэр юм. Тийм учраас хийх ажлын жагсаалтыг зайлшгүй гаргаж байх нь зүйтэй юм.
- Өөр нэг яригддаг зүйл бол Монголбанкны гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, шийдвэрт хөндлөнгийн хяналт тавих, Монголбанкны нийт ажиллагааг бүх төрлийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх ажлын байдалд бие даасан дүгнэлт гаргах явдал байгаа юм. Үүнийг Монголбанкны дотоод хяналтын нэгжийн бие даасан байдлыг хангах, чадавхийг бэхжүүлэх замаар шийдэж болох гэсэн үндэслэлээр Монголбанкны тухай хууль, УИХ-аас баталсан Хяналтын зөвлөлийн ажиллах журамд зарим санааг оруулсан.
- Хууль, журмыг өөрчлөн шинэчлэх хуулийн төслийн гол үзэл баримтлал бол Монголбанкны бүх үйл ажиллагаа нийтдээ нэг цогц бөгөөд түүнд тавих хөндлөнгийн хяналт зайлшгүй шаардлагатай нөхцөлд эрсдэлд орж болох аливаа зүйлээс сэргийлэхэд туслах ёстой гэж үзэж байна. Үүний цаана Монголбанкны захирлуудын зөвлөл, гүйцэтгэх удирдлага нь Хяналт шалгалтын хороо зэрэг хамтын удирдлагын бие даасан нэгж байгуулагдсан гэдгээр аливаа хариуцлагыг сулруулж болохгүй гэдгийг тэмдэглэж байна. Мөн аливаа улс орны төв банкны гүйцэтгэх удирдлага зарим асуудлаар мэргэжлийн түвшинд бие даасан шийдвэрийг түргэн шуурхай гаргаж байх ёстой.
- Монголбанкны Ерөнхийлөгч болон гүйцэтгэх удирдлагаас улс орны санхүү, эдийн засаг, Монголбанкны өөрийнх нь үйл ажиллагаанд нөлөө үзүүлж болох аливаа шийдвэр, түүний дотор нууцлалтай шийдвэрийг Монголбанкны Хяналтын Зөвлөл, түүний даргад ажлын өдөрт нь багтаан хүргүүлж байна гэсэн санааг УИХ-аас баталдаг ХЗ-ийн ажиллах журамд тодотгон оруулж болох юм.

ХОЁР: Дотоод ажил

Тайлант хугацаанд Хяналтын зөвлөл нь 6 удаа хуралдаж, 20 гаруй асуудал хэлэлцсэн бөгөөд мөн Монголбанкны санхүүгийн тайланд аудит хийж буй компанийн аудитуудтай 2 удаа, Монголбанкны Дотоод аудитын газарт төслийн шугамаар зөвлөн ажиллаж буй гадаадын зөвлөхтэй 1 удаа, ОУВС-ийн шинжээч нартай зэрэг уулзалтуудыг зохион байгуулж ажилласан болно. 2022 онд МБХЗ хурлаараа хэлэлцсэн асуудлаас товч тоймлон дурдвал:

1. Монголбанкны Захирлуудын зөвлөлийн үйл ажиллагаа, 2021 онд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүн;
2. Монголбанкнаас Улсын Их Хурал, олон нийтэд мэдээлсэн санхүүгийн тайлан, мэдээлэлтэй танилцаж, дүгнэлт өгөх
3. Гадаадын зарим орны Төв банкны үйл ажиллагаа, хяналтын тогтолцоотой танилцаж дүнг хуралд танилцуулах
4. Монголбанкны 2021 оны байдлаарх хуримтлагдсан ашиг алдагдалд шинжилгээ хийж, санал дүгнэлт гаргах
5. Монголбанкны орон нутаг дахь хэлтэс, салбарын ажилтай танилцсан тухай мэдээлэл хийх

6. Монголбанкны тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн Хяналтын зөвлөлд хамаарах хэсэгт өөрчлөлт оруулах талаар санал солилцох
7. Гадаад валютын улсын нөөцийн удирдлага, байршил, урт, богино хугацаатай хөрөнгө оруулалтын багцын 2022 оны эхний хагас жилийн байдалтай танилцах
8. Төгрөг юаний своп дансны үлдэгдлийг оновчтой ашиглах, шийдэх арга замын талаар Монголбанкны НУСЗЗГ-тай хамтран судалгаа хийж, санал боловсруулж танилцуулах
9. Монголбанкны ЭУА-ны тайлан, эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, асуудал, шийдэл
10. Монголбанкны дунд, урт хугацааны зээллэгийн үр дүнгийн байдалд хяналт хийж, санал дүгнэлт гаргах
11. ОУВС-тай хийсэн уулзалтын дүнг танилцуулах
12. Монголбанкны 2021 оны санхүүгийн аудитлагдсан тайланд Монголбанкны Хяналтын зөвлөлийн өгсөн дүгнэлтийн талаар ярилцах
13. ДАГ-ын үйл ажиллагааг боловсронгуй болгох талаар хэрэгжиж буй төслийн эцсийн үр дүнтэй танилцаж, хэрэгжилтийг хангаж ажиллуулахад дэмжлэг үзүүлэх /Гадаад зөвлөхийн тайлан/
14. Дотоод аудитын газрын “Чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах 2020-2023 оны дунд хугацааны төлөвлөгөө”-ний хэрэгжилтийн явцтай танилцаж, сонсгол хэлэлцэх
15. ХЗ-ийн санал зөвлөмж, шийдвэр, хэвлэлийн мэдээ түүний үр дүнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, үр дүнгийн талаар сонсох /2017-2021 он/
16. Мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх талаар Монгол улсад өгсөн олон улсын холбогдох байгууллагуудын зөвлөмжийн хэрэгжилтийн байдалтай танилцах
17. Мөнгө угаах терроризмтэй тэмцэх талаар банкуудад хийж буй хяналт шалгалтын талаар
18. Монголбанкны активын байдалд судалгаа хийж, санал дүгнэлтээ танилцуулах... зэрэг болно.

МБХЗ нь дээрх асуудлыг Монголбанкны холбогдох газар, хэлтсийн удирдлагууд болон холбогдох мэргэжилтнүүдтэй хамтран хэлэлцэж, УИХ-аас олгосон бүрэн эрхийнхээ хүрээнд санал зөвлөмж өгч ажилласан. МБХЗ-ийн хурлаас гарсан дүгнэлт, зөвлөмжийн талаарх мэдээллийг Монголбанкны сайт дээр болон өдөр тутмын сонинд гаргаж, олон нийтийн хүртээл болгож ажиллав. /Хэвлэлийн мэдээ Хавсралт 4/

Хэлэлцсэн асуудлын талаар хурлын тэмдэглэл хөтөлж нийт 357 хуудас материалаар архивын 2 нэгж бэлтгэн Монголбанкны архивт хүлээлгэн өгөв.

ГУРАВ: Хэлэлцсэн зарим гол асуудлын талаар товчхон:

Монголбанкны Дотоод аудитын газрын үйл ажиллагаа, үр дүн: Дотоод аудитын газар Монголбанкны Ерөнхийлөгчийн баталсан төлөвлөгөөний дагуу үйл ажиллагаагаа хэвийн явуулж, аудитыг хийж, гүйцэтгэсэн байна. Мөн 2021, 2022 онуудад гадаадын зөвлөхийн зөвлөмжийн хүрээнд боловсруулсан “Чанарын баталгаажуулалт ба сайжруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах 2020-2023 оны дунд хугацааны төлөвлөгөө”-т ажлаа хийж, 2022 онд “Дотоод аудитын дүрэм”-ийг олон улсын стандартад нийцүүлэн боловсруулж Монголбанкны Ерөнхийлөгчөөр батлуулжээ. Тус дүрэмдээ хэд хэдэн гол өөрчлөлтүүдийг оруулсан нь аудитын нэгжийн эрхэм зорилгыг тодорхойлж, Монголбанкны эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоо, засаглалын бүтцэд аудит хийх, зөвлөх үйлчилгээ, цахим өгөгдлийг ямар нэгэн хязгаарлалтгүйгээр олж авах шалгах зохицуулалт(өмнө нь биет өгөгдлийг хязгаарлалтгүйгээр

олж авах зохицуулалт байсан бол одоо цахим өгөгдлийг тусгаж өгсөн) хийж, дотоод аудитын чанарын баталгаажуулалт, аудитын тайлангийнхаа загварыг шинэчлэн CCCE (Criteria, Condition, Cause and Effect) ашиглах, аудитаар илэрсэн асуудал тус бүрээр эрсдэл, нөлөөллийн шинжилгээ хийж зөрчлийнхөө утгыг тусгаад зөрчлийн шалтгаан, зөрчлийн эрсдэл тохиолдлууд нөлөөлөл зэргийг нь тогтоох боломжтой болсон байна. Мөн гадаадын зөвлөхөөс ирүүлсэн 23 үндсэн баримт, мэдээллийг орчуулж нягтлан үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж байна. Дотоод аудитын институцийн стандарт 2024 оны сүүлээр бүрэн шинэчлэгдэж дуусахаар байгаа нь илүү стратеги рүү чиглэсэн болж шинэчлэгдэж байгаагаар онцлогтой. Цаашид аудитын ажлын үр дүнг илүү оновчтой тооцох, дотоод аудитын чанарыг сайжруулах зорилготой аудит хийгдсэн нэгжийн удирдлага, ажилтнаас санал авч, холбогдох арга хэмжээ авч хэрэгжүүлдэг тогтолцоог нэвтрүүлж эхлээд байна.

Монголбанкны Дотоод аудитын газар бол Монголбанкны Хяналтын зөвлөл үйл ажиллагаагаа илүү идэвхитэй, чанартай явуулах үндсэн түшиц баг төдийгүй цаашид хамтран ажиллах гол субъект гэж дүгнэн, илүү чадварлаг, чанартай баг бүрдүүлэхэд хамтран ажиллах, дэмжлэг үзүүлэхээ илэрхийллээ.

Монголбанкны Захирлуудын зөвлөл нь: 9 хүний бүрэлдэхүүнтэйгээр нийт 7 удаа хуралдаж 19 асуудал хэлэлцжээ. Үүнд 2023 онд Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэл, Ковид-19-ийн үед авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн, цаашид хэрэгжүүлэх бодлогын чиглэл, Гадаад валютын улсын нөөцийн удирдлага бүтэц, байршуулахад баримтлах лимит, нэр бүхий банкуудын жагсаалт, Монголбанкны авлага барагдуулалтын тухай, Зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай, Аудитын байгууллагаас санхүүгийн тайланг баталгаажуулах хүрээнд өгсөн удирдлагын захидалд дурдсан зөвлөмжийн хэрэгжилт, Монголбанкны ажилтныг шилжүүлэх, сэлгэн ажиллах журмыг шинэчлэн батлах тухай, Монголбанкны санхүүгийн тайланг баталгаажуулах аудитын компаниар PWC Mongolia сонгон шалгаруулсан тухай зэрэг асуудлыг хэлэлцсэн байна. Ерөнхийлөгчөөс өгөгдсөн үүрэг чиглэлийн дагуу арга хэмжээ авч, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал шийдвэрийн дагуу тухай бүрд нь хэрэгжилт тооцон ажиллажээ. Цаашид тайлан болон танилцуулгад үр дүнг тодорхой тусгаж байхыг Хяналтын зөвлөлийн гишүүдээс анхааруулав.

Монголбанкнаас Улсын Их Хурал, олон нийтэд мэдээлж буй мэдээлэлтэй танилсан. 1990 оноос өмнө Төв банкны тайлан, мэдээллийг олон нийтэд хийдэггүй таамаглахад хэцүү хаалттай институци байсан бол сүүлийн 30-аад жил ерөнхийдөө олон улсад ил тод олон нийтэд нээлттэй мэдээллээ түгээдэг ийм институц болж хувирсан. Энэ тухайд Төв банкны тухай хуульд Монголбанк мэдээллийг УИХ, олон нийтэд тайлан, статистик байдлаар хүргэх гэдгийг хуульчилж өгсөн. Сүүлийн хэдэн жилд Монголбанк (Төв банк) олон нийттэй харилцах сувгуудыг хөгжүүлэх, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулж Монголбанкны бодлого шийдвэрийг олон нийтэд түгээх, олон нийттэй харилцах харилцаа, ил тод байдалтай холбоотой Transparency буюу ил тод байдал, Communication буюу харилцаа, Education буюу боловсрол гэсэн 3 чухал зүйл дээр түлхүү анхаарч нэгжийн зохион байгуулалт, бүтцийг бий болгон Монголбанкны Хэвлэл мэдээллийн алба болон Олон нийтийн санхүүгийн боловсролын төв тус тусын үйл ажиллагааг явуулж ирсэн. Монголбанк санхүүгийн тайлангаа аудитын санал, дүгнэлт болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийн хамт жил бүр Улсын Их Хуралд танилцуулна гэж заасан байдаг бөгөөд үүний дагуу Монголбанкнаас УИХ-д 10 гаруй тайланг сар, улирал, жилийн давтамжтай хүргүүлж байна. *Монголбанкны Хяналтын зөвлөлийн зүгээс мэдээлэлтэй танилцаад цаашид мэдээллийн чанарт түлхүү анхаарч, тактик баримтлах, мэдээллийн тогтсон нэг өдөртэй болохыг санал болголоо.*

Монголбанкны хуримтлагдсан ашиг алдагдал нь: 2021 оны жилийн эцсийн байдлаар 1 их наяд 44 тэрбум төгрөг, бодит бус алдагдал нь 260 орчим тэрбум төгрөг байсан бол 2022 оны мөн үед хуримтлагдсан ашиг алдагдал 1 их наяд 416 тэрбум төгрөг, бодит бус алдагдал нь 938 тэрбум төгрөгт хүрсэн байна. 2022 онд жилийн эцсийн байдлаарх бодит бус ашиг алдагдлын 669 тэрбум төгрөгийн алдагдал нь гадаад валютын ханшийн тэгшитгэлээс, 414 тэрбум төгрөг нь санхүүгийн үүсмэл хэрэгслийн дахин үнэлгээний бодит бус алдагдал буюу своп арилжааны хүрээнд хийгдэж байгаа дахин үнэлгээгээр хүлээсэн. Харин үнэт металын ханшын тэгшитгэлээс 145 тэрбум төгрөгийн бодит бус ашигтай байна. Бусад нь бодит алдагдал буюу хамгийн өндөр алдагдал бол төв банкны үнэт цаасны хүүгийн зардал 461 тэрбум төгрөг гарсан байна. Хүүгийн орлого, зардлын хувьд 2022 оны байдлаар хүүгийн орлого нь 363 тэрбум төгрөг, хүүгийн зардал нь 930 тэрбум төгрөгийн зардалтай бөгөөд 930 тэрбум төгрөгийн хүүгийн зардал дотор нь ХАБ-д төлсөн хүү, төв банкны үнэт цаасны хүүд төлсөн хүү ихэнхийг нь эзэлж байна. Мөн 2010 оноос өнөөдрийг хүртэл нийт хүүгийн орлого бол 2.8 их наяд төгрөг, хүүгийн зардал бол 6.4 их наяд төгрөг байгаа. Монголбанк 2010 оноос хойш алдагдалтай гарч эхэлсэн ба Төв банкны хуулийн дагуу ийм дутагдалтай үед Засгийн газрын бонд буюу Засгийн газрын үнэт цаас гаргах замаар хаах хуулийн зохицуулалттай хэдий ч шийдвэрлэгдэхгүй явсаар өнөөг хүрч өнөөдрийн байдлаар 6.9 их наяд хуримтлагдсан алдагдал болоод өөрийн хөрөнгийн алдагдал 5 тэрбум болсон байна.

Асуудлыг Монголбанкны Хяналтын зөвлөл ээлжит хурлаараа удаа дараа хэлэлцэж байгаа бөгөөд, саналаа тайландаа тусган жил бүр УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороонд хүргүүлдэг.

Мөнгө угаах үйл ажиллагаатай тэмцэх, олон улсын байгууллагуудын зөвлөмжийн хэрэгжилт болон мөнгө угаах терроризмтой тэмцэх талаар банкуудад хийж буй хяналт шалгалтын талаар: 2022 онд Хяналтын зөвлөл ээлжит хурлаараа хэлэлцсэн. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тогтолцоо нь дотоод, гадаад хамтын ажиллагаан дээр суурилдаг учраас хамтын ажиллагааг илүү өргөж, ач холбогдол өгч ажиллах нь чухал байдаг. Энэ утгаараа Монгол Улсын Засгийн газар, Үндэсний зөвлөл, Хамтын ажиллагааны зөвлөл, Санхүүгийн мэдээллийн алба, Банкууд, холбогдох яам, агентлагууд, Цагдаа, Тагнуул, Шүүх, Прокурор гээд хууль хүчний байгууллага, Мэргэжлийн холбоод, Төрийн бус байгууллагууд хамтран ажиллаж байж, хамтын хүчээр ФАТФ-ийн өмнө хүлээсэн үүргээ бүрэн хамгаалж, олон улсад нэр хүндтэй улс байх болно. Манай улс ФАТФ-ийн өгсөн 40 зөвлөмжөөс 39 зөвлөмжийг биелүүлж ажилласан ба үүнд зөвлөмж 15-ийн үнэлгээ гол нөлөө үзүүлсэн ба Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийг сүүлийн 2 жил гаруй хугацаанд ТББ-тай хамтран хэлэлцэж батлуулсан байна. Мөн хуулиа дагаад 8 журам батлуулж, эрсдэлийн үнэлгээ хийлгэсэн, сургалт хийж холбогдох арга хэмжээг авсан, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх бодлоготой, бодлогын баримт бичигтэй болсон явдал Монгол Улсын хувьд маш чухал үзүүлэлт болсон байна. Үлдсэн 1 зөвлөмж буюу 8 дугаар зөвлөмжийн биелэлтийг хангуулах, энэ нь ашгийн бус байгууллагатай холбоотой бөгөөд маш чухал байсанг үндэслэн ХЗДХЯ-аас санаачлан Холбооны эрх зүйн байдлын тухай хууль, Сангийн эрх зүйн байдлын тухай хуулийг боловсруулан, батлуулахаар УИХ-д өргөн барьсан байна. Түүнтэй холбоотойгоор иргэдийн дунд соён гэгээрүүлэх ажиллагаа тасралтгүй үргэлжлэх шаардлагатай тул 2021-2022 онд давхардсан тоогоор 11000 орчим иргэдийг сургалтанд хамруулж, 71 сургалтыг зохион байгуулж ажиллажээ. Тус зөвлөмжийн хүрээнд болон Монгол Улсын хувьд гол ажил нь хяналт шалгалтын тогтолцоо бүрдэх, хууль эрх зүйн тогтолцоо бүрдэх асуудал чухалд тавигдаж байгаа.

Мөнгө угаах терроризмтой тэмцэх нэг нэгж бол Монголбанкны Хяналт шалгалтын газрын харьяа Мөнгө угаахтай тэмцэх хэлтэс юм. Тус хэлтсийн хувьд арилжааны банкуудтай нягт хамтран ажиллаж банкуудад “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуульд болон “Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай” хуулийн хэрэгжилтийг хангуулахад нь хяналт тавьж зайнаас хяналт тавих, газар дээр нь хяналт шалгалт

хийх, банкуудаас тоон мэдээлэл, дата цуглуулах, эрсдэлийн үнэлгээ хийх зэргээр ажилладаг. Мөн сэжигтэй гүйлгээг хянах, шаардлагатай бол Хамтын ажиллагааны зөвлөлд, Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэл хүргэх, цаашлаад хүчний байгууллагад хандах зэргээр ажилладаг байна. 2022 оны хувьд улиралд дунджаар 500 орчим сэжигтэй гүйлгээ хийгдсэн байна.

Монголбанкны Хяналтын зөвлөл дээрх асуудлыг жил бүр хэлэлцэж ирсэн бөгөөд цаашид хамтран ажиллаж буй байгууллагуудын чадавхийг сайжруулах, дутуу байгаа хууль эрх зүйн зохицуулалтыг хийхэд анхаарахыг санал болгов.

Монголбанкны ЭУА-ны тайлан, эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, асуудал, шийдэл: Алба нь 2022 онд гадаад захын эрсдэл, мөнгөний бодлогын үйл ажиллагаа буюу гадаад захын үйл ажиллагааны эрсдэл, гарч буй асуудал ба шийдэл гэсэн үндсэн 3 хэсэгт чиглүүлэн үйл ажиллагаагаа явуулжээ. ГВУН-ийн баримтлах бодлогын хүрээнд стратегийн хөрөнгө оруулалтын бүтцийн саналыг боловсруулж Захирлуудын зөвлөлөөр хэлэлцүүлэн стратегийн хөрөнгө оруулалтын бүтцийн нөөцөө баталж улсынхаа нөөцийг валютаар буюу ам.доллар, юань, евро, иень, алт гэсэн валютаар байршуулж ирсэн. Мөн импортын бүтцээ харж гадаад өр, банкуудын гадаад төлбөр тооцоо, дотоодын валютын зах зэргийг судалж, макро үзүүлэлтүүдийг харж загвараар үнэлгээ хийн ГВУН-ийг байршуулах хөрөнгийн төрлийг тодорхойлж харилцах, хадгаламж, үнэт цаас гэсэн 3 активд байршуулсан байна. Аль банкинд(Хятадын, Английн банкинд...гм) хэдийг тогтоох уу гэдгийг тодорхойлохдоо Дэлхийн банк, ЕТБ-ны аргачлалд үндэслэн банкны өөрийн хөрөнгийн хэмжээ, зээлжих зэрэглэл дээр үндэслэсэн дотроо өөрсдийн дүрмийг боловсруулаад түүнийхээ дагуу хөрөнгийн хэмжээг тодорхойлж явж байна. Улирал тутам банкуудын зээлжих зэрэглэл, төлбөрийнх нь мэдээллийг авч, тухайн банк байршиж буй улсын эдийн засаг, санхүү, геополитикийн нөхцөл байдлын талаар улирал тутам шинэчилж танилцуулах үүрэгтэй ажиллаж байна. Монголбанкны Эрсдэлийн удирдлагын алба бүтэц, лимитийг тогтоогоод Нөөцийн удирдлага, санхүүгийн зах зээлийн газарт хүргүүлснээр нөөцийг удирдаж байна. ГВУН-ийн стратегийн хөрөнгө оруулалтын бүтцийн тооцоололд алдааны шинжилгээ (Backtest) хийх судалгааг 2022 оны 6 дугаар сард хийж, үр дүнд нь багцын оновчлолыг сайн тодорхойлсон боловч эрсдэлийг зарим тохиолдолд хэт өндрөөр үнэлж, харин үр өгөөжийг хэт багаар үнэлсэн нь тогтоогдсон тул цаашид нөөцийн бүтэц, эрсдэл, үр өгөөжийн үзүүлэлтийг оновчтой тодорхойлоход судалгааны үр дүнг ашиглахаар болжээ. Энэ онд шинээр эхэлсэн ажил бол банкуудын активын бүтэц, өөрчлөлтийг улирал тутам судлан, танилцуулга боловсруулан удирдлагуудад хүргэж, шаардлагатай үед банкуудад ямар барьцаа, барьцаан дотроо ямар хөрөнгүүд байна, ямар үнэт цаас байна гэдгийг харах боломжтой болсон.

Урт хугацаат своп хэлцэл буюу гадаад валютын орох урсгалыг дэмжиж, нөөцийг нэмэгдүүлэх, гадаад валютын ханшийн эрсдэлээс хамгаалах тогтолцоог бүрдүүлэх, зээлийн долларжилтыг бууруулах, системийн тогтвортой байдлыг хангах гэсэн зорилготой своп хэлцэл хийх шаардлага Монголбанкинд байгаа эсэхийг ингэснээр хамгийн гол нь хугацааны эцэст ханшийн зөрүүг нь Монголбанк өгөх учраас төгрөгийн хани сулраад байх тусам Монголбанкинд алдагдал нэмэгдээд явах учраас алдагдал хүлээж буйг Хяналтын зөвлөл анхааралдаа авч удаа дараа хурлаараа сануулж буйг дахин анхаарууллаа.

2022 онд ГВУН-ийн удирдлагатай холбоотой үйл ажиллагаанд эрсдэлийн үнэлгээ хийсэн бөгөөд 16 эрсдэл тодорхойлсноос өндөр эрсдэл байхгүй, 5 эрсдэл дунд, бусад нь бага эрсдэлтэй гэж үнэлэгдсэн байна. Монголбанкны үйл ажиллагааны тасралтгүй байдал буюу чиг үүрэг нь Эрсдэлийн удирдлагын алба дээр хийгддэг тул “Монголбанкны үйл ажиллагааны тасралтгүй байдлын удирдлагын бодлогын баримт бичиг”-ийг МБЕ-ийн 2022 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн А-177 дугаар тушаалаар, “Монголбанкны үйл ажиллагааны тасралтгүй байдлын ерөнхий төлөвлөгөө”-г Н-12 дугаар тушаалаар тус тус батлуулж ажилласан байна. Цаашид Монголбанкны үйл ажиллагааны тасралтгүй байдал (business continuity)-ыг хангах чиг үүргийг

олон улсын стандартын түвшинд хэрэгжүүлэх, үйл ажиллагаануудын тасралтгүй байдлыг хангах төлөвлөгөөг хариуцсан газар нэгжүүдтэй хамтран боловсруулах ажил байгааг онцлон дурьдсанг Хяналтын зөвлөл анхааралдаа авахаар тохирлоо.

Нөөцийн удирдлага, хөрөнгө оруулалтын багц, зээллэг, своп дансны талаар: *Нөөцийн удирдлага, хөрөнгө оруулалтын багц, зээллэг, своп дансны талаар:* Олон улсын санхүүгийн зах зээлийн орчинд нүүрлээд буй тодорхой бус байдал нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад тулгамдсан асуудал хэвээр байв. 2021 оны сүүлийн хагасаас эхлэн өсөн нэмэгдэж буй инфляцын дарамт 2022 оны туршид хадгалагдаж, дэлхийн голлох эдийн засгуудад хүндрэл учруулсаар байна. Тайлант оны эцэст Их Британи улсын инфляц 2022 оны 10 дугаар сард жилийн дүнгээр 11.1 хувь буюу сүүлийн 40 гаруй жилийн хамгийн өндөр түвшиндээ хүрсэн бөгөөд оны эцэст 10.5 хувьд хүрч бага зэрэг буурсан бол АНУ-ын инфляц 6.5 хувь, Евро бүсийн инфляц 9.2 хувьд тус тус хүрлээ.

2022 оны эцэст ГВУН оны эхнээс 22.1 хувиар буурч 3.4 тэрбум ам.долларт хүрсэн хэдий ч 2022 оны 3 дугаар улирлын эцэстэй харьцуулбал 605.0 сая ам.доллараар нэмэгдсэн байна. Үүнд гадаад худалдааны нөхцөл сайжран, уул уурхайн түүхий эдийн экспортын орлого нэмэгдэж улмаар төлбөрийн тэнцлийн алдагдал буурсан явдал голчлон нөлөөллөө.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт гадаад активын дүн 3.4 тэрбум ам.доллар байсан бол нийт пассивын дүн 2.0 тэрбум, цэвэр нөөцийн хэмжээ 1.4 тэрбум ам.доллар байлаа. ГВУН-ийн активын задаргааг дэлгэрэнгүй авч үзвэл нийт активын 13.5 хувь буюу 457.7 сая ам.доллар харилцах дансанд, 16.9 хувь буюу 577.3 сая ам.доллар хадгаламж, 53.1 хувь буюу 1,807 сая ам.доллар гадаад валютаар илэрхийлэгдэх үнэт цаас, 11.2 хувь буюу 380.9 тэрбум төгрөг мөнгөжсөн алт, 3.6 хувь буюу 121.1 сая ам.доллар зээлжих тусгай эрх, 3.6 хувь нь бэлэн валют хэлбэрээр байршиж байна.

Санхүүжилт: Монголбанкнаас банкуудад олгосон хөнгөлөлттэй хүүтэй ипотекийн зээлийн эх үүсвэрийн үлдэгдэл 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 898.0 тэрбум төгрөг байна. Ипотекийн зээлийн эх үүсвэр нь Монголын ипотекийн корпорацийн гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бондоор эргэн төлөгддөг Монголбанкны эзэмшиж байгаа ипотекийн зээлээр баталгаажсан бондын үлдэгдэл 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 3.4 их наяд төгрөг байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийг авч үзвэл 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 7.8 мянган зээлдэгчид 732.3 тэрбум төгрөгийн зээлийг зээлдэгчдэд олгосон. Нийт олгож байгаа зээлийн 80 хувийг нь Монголбанкны эх үүсвэрээр 20 хувийг нь банкны эх үүсвэрээр бүрдүүлж байна. 2020 оноос ЗГ-аас хэрэгжүүлсэн 10 их наядын төлөвлөгөөний хүрээнд нийтдээ 2024 он хүртэл 2 их наяд төгрөгийн зээл олгохоор төлөвлөгөөнд тусгагдсан бөгөөд 2021, 2022 онуудад нийт 1.7 их наяд төгрөгийн зээлийг 21 мянга орчим өрхөд олгосон.

Монголбанкнаас газрын тосны бүтээгдэхүүн импортлогчдод шатахууны нөөц бүрдүүлэлтэд шаардлагатай эргэлтийн хөрөнгийн санхүүжилтийг 2021 оны 4 дүгээр улирлаас банкуудаар дамжуулан олгож эхэлсэн. Мөн 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрөөс АИ-92 шатахууны санхүүжилтэд урьдчилгаа төлбөрийн санхүүжилтийг олгож эхэлсэн бөгөөд Монголбанкнаас олгосон шатахууны санхүүжилтийн нийт үлдэгдэл 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар 430.0 тэрбум төгрөг байна.

Монголын ипотекийн корпорацийн гаргасан ипотекийн зээлээр баталгаажсан бондын үлдэгдэл 3.4 их наяд төгрөг, УИХ-аас баталсан тэтгэврийн зээлийг тэглэх хүрээнд олгосон Эрдэнэс бондын үлдэгдэл 827.6 тэрбум төгрөг, Эрдэнэс таван толгой бондын үлдэгдэл 311 тэрбум төгрөг байна. Эдгээр бонд, зээллэгийн эргэн төлөлтийг хангуулах, энэхүү авлагуудад тооцдог эрсдэлийн сан байгуулалтаар болон хүүний зөрүүгээс зардал өсөж, Монголбанкны хуримтлагдсан алдагдлыг өсгөсөөр байна. Мөн зарим арилжааны банк, орон сууцны корпорац болон зарим алт олборлогч болон компаниудтай холбогдож үүссэн өр авлагыг зохицуулах шийдвэрлэх тухай хөндлөнгийн

аудиторын санал зөвлөмжийг хэрэгжүүлэх ажил хойшлуулшгүй зорилт болсон. Хяналтын зөвлөл нь жил бүр Монголбанкны санхүүгийн аудитлагдсан тайлантай танилцаж хурлаараа хэлэлцэн Хяналтын зөвлөлийн санал дүгнэлтийг өгч Монголбанкны удирдлагад болон УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороонд хүргэж ирсэн. Эдгээр санал дүгнэлтийн хэрэгжилтийг Монголбанкны Дотоод Аудитын газраас нэгтгэн ирүүлснийг Хавсралт №5-аас дэлгэрүүлэн үзэх боломжтой.

Гадаадын зарим орны Төв банкны үйл ажиллагаа, хяналтын тогтолцоотой танилцсан талаар: Монголбанкны Хяналтын зөвлөл 2022 онд Унгарын төв банкны үйл ажиллагаатай танилцаж, санхүүгийн боловсролыг дэмжих үйл ажиллагаа, дижитал санхүүгийн оролцоо, макро эдийн засгийн төсөөлөл, төсвөө өргөн барих үйл ажиллагаа, төлбөрийн мораториум, Төв банкны хараат бус байдлын эрх зүйн үндэс, санхүүгийн зах зээлд зөвшөөрөл олгох үйл явц дотоод аудитын үйл ажиллагаа, гадаад валютын нөөцийн удирдлага, санхүүгийн хэрэглэгчдийг хамгаалах хэрэгслүүд зэрэг талаар мэдээлэл сонсов. Унгар улс нь одоогоор дижитал санхүүгийн оролцооны хувьд 60 хувийн гүйцэтгэлтэй, үндсэний мөнгөн тэмдэгт форинтоо өнөөг хүртэл авч явж байгаа, төлбөрийн урсгал тэнцэл ашигтай, ханш нь тогтвортой болсон байна. Төв банкны үүрэг Инфляцийн түвшинг хадгалах, Банкны болон банкны бус бүх зуучлагчдын тогтвортой байдлыг хангана гэсэн байна. Харин манайд Монголбанк зөвхөн арилжааны банкуудыг хариуцдаг бол Унгарт бүх арилжааны банкуудыг дээр нь ББСБ-ыг хариуцаж явдаг онцлогтой. Мөн гадаад валютын нөөцдөө Унгар нь дэлхийн нийтийн валютуудаас гадна хөрш орны Польшийн золота, Чехийн коронаг оруулсан нь хөрш орнуудтайгаа өдөр тутмын харилцаатай, доллараар болон еврогоор мөнгө шилжүүлэхээр маш их ханшийн эрсдэл гардаг учраас хөрш орнуудын валютыг чөлөөтэй сольдог механизмтай болсон байна. Мөн Төв банкныхаа хуульд иргэдийн санхүүгийн боловсролыг дээшлүүлэх, соён гэгээрүүлэх ажлыг төв банкны үүрэг гэж заалтыг оруулж өгч иргэдийнхээ санхүүгийн мэдлэгийг дээшлүүлэхэд чиглүүлж ингэснээр Коллежийн хэмжээнд эдийн засаг, санхүүгийн хичээлийг зайлшгүй орох ёстой хичээлийн хуваарьт оруулсан, 5 дугаар ангиас эхлээд 6, 7 дугаар ангиудад математикийн хичээлийн нэг бүлгийг төв банкных нь хараа хяналт дор хичээлийг нь оруулдаг нь шинэлэг туршлага иймд цаашид анхааралдаа авах, Хяналтын зөвлөлийн зүгээс хамтран ажиллахад бэлэн гэдгээ Монголбанкны зарим удирдлага, оролцсон зочидод санал болголоо.

Хяналтын зөвлөл 2017 онд Монголбанкинд өгсөн зөвлөмжөөрөө Сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн суурь мэдлэг, боловсрол олгох, төрийн болон төрийн бус байгууллагуудтай (Засгийн газар, БСШУЯ, арилжааны банк...гм) хамтарч ажиллахад дэмжлэг үзүүлэх, БСШУЯ-ны боловсролын хөтөлбөрт “Бизнес судлал” хичээлийг ЕБС-ийн ахлах X, XI, XII ангиудад заавал судлах хичээл болгон оруулах боломжийг судалж, хэрэгжүүлэх, Монголбанкны зүгээс санаачлан хууль, шүүх, прокурорын байгууллагууд, Сангийн яам, арилжааны банкуудтай хамтарч Монголбанк, банкны тухай хуулиуд, зээл, мөнгө, санхүү, татвар, төсөв зэрэгтэй холбогдсон хууль, тогтоомжийн мэдлэгийг гүнзгийрүүлэх, сурталчлах, хуулиудын мөрдөлт, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар тодорхой хөтөлбөр боловсруулан сургалт зохион байгуулж ажиллахыг зөвлөсөн.

Тус зөвлөмжийн хүрээнд 2018 онд Дэлхийн хуримтлалын өдрөөр олон талт арга хэмжээнүүдийг арилжааны 10 банк болон Монголын банкны холбоо, Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран 10 дугаар сарын турш зохион байгуулсан нь өдгөө хэвшил болж, ЕБС-ийн хүүхдүүдэд сургалт, уулзалтуудыг хийж, хуримтлалын ач холбогдлыг таниулж, сурталчилсан ажил хэрэг болсон. Мөн БСШУЯ-ны сайдын 2019 онд “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалаар Ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд Бизнес судлал хичээлийг сонгон судлахаар оруулсан байна. Санхүүгийн мэдлэгийг түгээх зорилготой БШУСЯ, банкууд, ЖДҮҮЭ-дийн нийт 2984 сургагч багшийг амжилттай бэлтгэж, Монголын банкны холбоо, Банк санхүүгийн академи, Шпаркассэ банкны сантай хамтран 9 банкны 7 элсэлтийг зохион байгуулж нийт 147

ажилтанг онол практик хосолсон 11 модуль сургалтад хамруулан сургажээ. Мөн Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхчид, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын 105 албан хаагч нарт санхүүгийн анхан шатны суурь мэдлэг олгох сургалтыг 2018, 2022 онд тус тус зохион байгуулсан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, иргэдэд хувийн мэдээлэл алдагдвал үүсэх эрсдэл, учрах хохирлыг таниулах, цахим орчинд мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах, залилах болон цахим гэмт хэрэгт өртөж болзошгүй иргэдэд анхааруулах зорилгоор 2019 онд “Ятгах тусам нягтал”, 2020 онд “Нягтлах тусам аюулгүй”, “Ятгах тусам нягтал-2” 2021 онд “Ятгах тусам нягтал-2021” аяныг Цагдаагийн Ерөнхий газар, Монголбанк, болон арилжааны банкууд хамтран зохион байгуулсан байна. Түүнчлэн 2022 онд Цахим хөгжил, харилцаа холбооны яам, Монголбанк, Цагдаагийн ерөнхий газар, Монголын банкны холбоо хамтран цахим орчинд үйлдэгдэх санхүүгийн залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор “Unsend-Бүү шилжүүл” 5 дахь удаагийн аяныг тус тус зохион байгуулж цахим орчинд давхардсан тоогоор 6 сая, хамтрагч байгууллагуудын хамт 2300 орчим иргэнд мэдээ мэдээллийг хүргэж ажилласан амжилт үр дүнг үзүүлээд байна.

Хяналтын зөвлөлийн санал, дүгнэлт

Монголбанкны Хяналтын зөвлөл нь УИХ-аас баталсан “Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журам”, Төв банк(Монголбанк)-ны тухай хуулийн 27¹-д заасан эрх хэмжээний хүрээнд үйл ажиллагаагаа явууллаа. МБХЗ Монголбанкны удирдлага, бүтцийн нэгжүүдтэй хамтран ажиллаж, өөрийн бүрэн эрхийн хэмжээнд банкны гол үйл ажиллагаатай холбоотой асуудлаар мэдээлэл, танилцуулга бэлтгүүлэн санал дүгнэлтийг нь сонсож, нээлттэйгээр санал солилцож, ажил хэрэгч хэлэлцүүлэг хийж холбогдох асуудлуудаар өөрсдийн байр суурийг илэрхийлэн, санал зөвлөмжөө өгч, өдөр тутмын хэвлэлд, Монголбанкны сайтад мэдээ мэдээллээ байршуулж нээлттэй ажилласан. МБХЗ нь цаашид хэд хэдэн зүйл дээр анхаарах зайлшгүй шаардлага байгааг онцолж байна. Үүнд:

1. Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 27¹ -ын Хяналтын зөвлөлтэй холбоотой заалтад нэмэлт өөрчлөлт оруулах замаар, УИХ-аас 2003 онд батлагдан өнөөг хүртэл хэрэгжиж буй “Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-ийг шинэчлэх;
2. Төв банкны бие даасан, хараат бус байдлыг Үндсэн хуульд тусгуулан, үүргийг нь тодорхой болгож, статусыг нь хуульчлах;
3. Төв банкны алдагдлыг бууруулах арга хэмжээг төрөөс оновчтой зохион байгуулах, дахин алдагдал үүсэх нөхцлийг хуулиар хааж өгөх;
4. Төв банкнаас гарах мэдээллийн урсгалыг чанаржуулан нийгэмд мэдээллийн сувгийн хүлээлт бий болгох нөхцлийг бүрдүүлж ажиллах;
5. Монголбанкны Хяналтын Зөвлөлийн үйл ажиллагааны талаарх ОУВС-ийн зөвлөмжийг хэрэгжүүлж, эрх хэмжээ, үйл ажиллагааг нь олон улсын жишигт хүргэх.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

ⁱ Манайхан эцсийн зээлдэгч гэж орчуулдаг. Утгаар нь орчууллаа. Өөрөөр хэлбэл барагдуулж чадаагүй авлагыг хариуцах эрсдэлийг Монголбанк хүлээнэ гэсэн гэж ойлговол зохино.

Монголбанкны Хяналтын зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмж түүний хэрэгжилт /2017-2022.IX/

№	Хэлэлцсэн асуудал	Шийдвэрийн дугаар, огноо	Дугаар	Тогтлол, тэмдэглэлийн заалт	Хариуцах газар хэлтэс, алба	Зөвлөмжийн хэрэгжилт	ДАТ-ын тайлбар, дүгнэлт
1.	Монголбанкны аудит ба эрсдэл, гадаад валютын улсын нөөцийн тухай	2017.04.12 №1	1.	Монголбанк өөрийн үйл ажиллагаандаа удирдлагын эрсдэлийн үнэлгээг хийж ажиллахыг зөвлөсүгэй	ЭУА	Монголбанкны бодлогын шийдвэртэй холбогдон гарах эрсдэл буюу бодлогын эрсдэлийг тодорхойлон үнэлэх чиглэлд өргөжүүлж, бодлогын болон санхүүгийн, үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг төвлөрүүлэн, эрсдэлийн үнэлгээний бие даасан байдлыг хангасан тогтолцоог бий болгох, мөн Эрсдэлийн хороо байгуулах боломжийг судлан ажиллаж байна. Бодлогын эрсдэлийг тодорхойлох, үнэлэх, удирдахад одоогоор Монголбанкны засаглал, бүтэц болон хүний нөөцийн чадавхийн хувьд хязгаарлагдмал байна. ЭУА нь хэлтсийн статустай, жижиг бүтэцтэйгээр зөвхөн санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа бөгөөд чиг үүрэгт бодлогын эрсдэлийн удирдлага байхгүй байна. Бүтцийг өөрчлөх, чиг үүргийг өргөжүүлэх талаар саналаа удирдлагад хүргүүлсэн бөгөөд түр харзнах чиглэлийг өгсөн болно.	Биелэлт-70% ЭУА-ны зүгээс эрсдэлийн үнэлгээний бие даасан байдлыг хангасан тогтолцоог бий болгох, Эрсдэлийн хороо байгуулах боломжийг судалж, албаны бүтцээ өөрчлөх, чиг үүргээ өргөжүүлэх талаар саналаа удирдлагад танилцуулсан байна.
			2.	Монголбанкны үйл ажиллагаа, удирдлагад хамаарах гадаад зээллэгийн хүүгийн хэмжээг Олон Улсын Валютын сантай ойлголцсон хэмжээнд хүртэл буулгах, богино хугацаат гадаад өрийг яаралтай барагдуулах чиглэлээр ажиллахыг санал болгосугай.	НУСЗЗГ	Гадаад өрийн статистикт Монголбанкны ХАБ-тай байгуулсан своп хэлцлийн өр төлбөрийг богино хугацаат өр төлбөрт бүртгэдэг байсан бол ерөнхий гэрээний хугацаа 3 жилээр хийгддэгтэй холбогдуулан 2020 оны 2 дугаар улирлаас эхлэн урт хугацаат (1-ээс дээш жил) өр төлбөрөөр бүртгэх болсон. НУСЗЗГ-ын зүгээс своп хэлцлээс үүссэн өр төлбөрийг тодорхой хувилбаруудаар алтны экспортын орлогоос төлж эхлэх саналыг боловсруулан 2017 оны 12 дугаар сарын 27-ны өдөр удирдлагад танилцуулсан. Улмаар тус асуудлыг Хөрөнгө оруулалтын хорооны хурал, Захирлуудын зөвлөлийн хурлаар тус тус хэлэлцүүлэн алтны	Биелэлт-70% Своп хэлцлээс үүссэн өр төлбөрийг тодорхой хувилбаруудаар алтны экспортын орлогоос төлж эхлэх саналыг боловсруулан удирдлагад танилцуулж, тусгай данс нээн экспортын орлогыг хуримтлуулан ажиллажээ. Монголбанкны үйл ажиллагаа, удирдлагад хамаарах гадаад

			тусгай дансыг нээж экспортын орлогыг хуримтлуулан ажилласан. ГВУН-ийн хэмжээ нэмэгдсэн, цар тахлын үеийн эдийн засгийн тодорхой бус байдал буурсантай холбогдуулан 2021 оны 11 дүгээр сард танилцуулгыг Төлбөрийн тэнцлийн төсөөлөлтэй уялдуулан дахин шинэчилж удирдлагад танилцуулсан боловч 2022 оны 1 дүгээр улирлаас эхлэн гадаад секторын тодорхой бус байдал нэмэгдэж, Төлбөрийн тэнцлийн дарамт огцом өссөн.	зээллэгийн хүүгийн хэмжээг Олон Улсын Валютын сантай ойлголцсон хэмжээнд хүртэд буулгах талаар хийсэн ажил тайлагнаагүй байна.
3.	Монгол улсын гадаад зээлийн үйлчилгээтэй холбогдсон гүйлгээнд аудит хийлгэж, холбогдох хууль мөрдүүлэх, өрийн дарамтыг хөнгөвчлөх арга хэмжээ боловсруулж ажиллахыг зөвлөсүгэй.	НУСЗЗГ ХЭЗГ ДАГ	ЭУА болон НУСЗЗГ-ын зүгээс ГВУН-ийн бүтэц, лимитийн гүйцэтгэлийн тайланг өдөр тутам боловсруулан үйл ажиллагаандаа ашигладаг. Тус тайланг бэлтгэхдээ ССГ-аас гадаад өрийн эргэн төлөлтийн хуваарийг авч ашигладаг бөгөөд ойрын хугацаанд хүлээгдэж буй гадаад зээлийн хүү ба үндсэн төлбөрийн эргэн төлөлтийг анхааралтай ажиглаж, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангаж ажилладаг. Монгол улсын гадаад зээлийн үйлчилгээтэй холбогдсон гүйлгээнд Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу төрийн аудитын байгууллагаас аудит хийх зохицуулалттай. Үндэсний аудитын газраас 2013-2016 оны Монгол улсын нийт гадаад өрийн хэмжээг тодорхойлох чиглэлээр 2017 оны 2 дугаар сарын 01-нээс 6 дугаар сарын 5-ны өдрүүдэд аудит хийж дүгнэлтийг гаргасан.	Биелэлт-100% Үндэсний аудитын газраас 2013-2016 оны Монгол улсын нийт гадаад өрийн хэмжээг тодорхойлох чиглэлээр аудит хийж дүгнэлт гаргасан байна. Монгол улсын гадаад зээлийн үйлчилгээтэй холбогдсон гүйлгээнд Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу төрийн аудитын байгууллагаас аудит хийх зохицуулалттай байна.
4.	Монголбанкны санхүүгийн тайлан, актив, пассив, дотоод гадаад, хөрөнгө оруулалтын багцийн мэдээг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, стандарттай нийцүүлж, ил тод байдлыг хангаж ажиллах.	НУСЗЗГ СБГ ДАГ	Монголбанкны гадаад актив, пассивын мэдээллийг ил тод болгох зорилгоор ГВУН-ийн ерөнхий бүтэц болон дэлгэрэнгүй мэдээллийг ОУВС-гийн Мэдээлэл тархаах тусгай стандарт (SDDS)-д нийцүүлэн Монголбанкны цахим хуудсаар дамжуулан мэдээлж байгаа болно. Монголбанкны санхүүгийн тайланг СТОУС-д нийцүүлэн улирал тутам бэлтгэж, жилийн эцсийн санхүүгийн тайланг хөндлөнгийн аудитын байгууллагаар баталгаажуулж байгаа ба “Төв банк /Монголбанк/-ны тухай” хуулийн дагуу жил бүр УИХ-д хүргүүлж байна. Түүнчлэн “Шилэн дансны тухай” хуулийн дагуу Монголбанкны цахим хуудас	Биелэлт-100% Монголбанкны албаны нууцад хамаарахаас бусад мэдээллийг Монгол улсын холбогдох хууль тогтоомж, олон улсын гэрээ, стандарттай нийцүүлж ил тод байдлыг ханган олон нийтэд нээлттэй мэдээлсэн байна.

						болон ЗГ-ын Шилэн дансны веб хуудсанд холбогдох тайлан мэдээг байршуулан ажиллаж байна. Харин Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022/03/16-ны өдрийн А-66 дугаар тушаалаар ГВУН-ийн бүтэц, ГВУН-ийг байршуулах гадаадын банк, санхүүгийн байгууллагууд зэрэг дэлгэрэнгүй мэдээлэл нь Монголбанкны албаны нууцад хамаарсан тул тус мэдээллийг олон нийтэд нээлттэй, ил тод мэдээлдэггүй.	
2.	Хяналтын Зөвлөлийн болон Монголбанкны зарим ажилтнуудын сонсгол, мэдээллийн мөрөөр авах арга хэмжээний тухай	2017.06.23 №3	5.	Монголбанкны санхүүгийн байдал, хөрөнгийн удирдлага, өр авлага, актив, пассивын өөрчлөлт, нягтлан бодох бүртгэл, аудит зэрэгтэй холбоотой зарчмын шинжтэй асуудлаар улирал тутам Зөвлөлөөс гарсан шийдвэрийг ХЗ-д мэдээлж байх	ТГ	Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын талаарх мэдээллийг улирлаар тухай бүр албан тоот болон имэйлээр хүргүүлж байсан. Түүнчлэн хэсэг хугацаанд Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг хурал эхлэхээс 1-2 хоногийн өмнө хүргүүлж ажилласан.	Бнелэлт-100% Монголбанкны Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын талаарх мэдээллийг хүргүүлжээ.
			6.	Монголбанкны алдагдлыг багасгах, санхүүгийн байдлыг сайжруулах асуудлыг Захирлуудын зөвлөлөөр тусгайлан авч хэлэлцэж, дүнг нь мэдээлэх	СБГ ДАГ	Захирлуудын зөвлөлийн 2017 оны 4 дүгээр сарын 27-ны өдрийн хурлаар Монголбанкны алдагдлын талаар хэлэлцсэн. Мөн Монголбанкны санхүүгийн тайлангийн үзүүлэлтэд шинжилгээ хийж, хуримтлагдсан алдагдал, түүний шалтгаан, хүчин зүйлсийн талаар Захирлуудын зөвлөлийн 2018 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн хуралд, Монголбанкны 2018 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн үр дүн, удирдлагын захидлын талаар Захирлуудын зөвлөлийн 2019 оны 7 дугаар сарын 4-ний өдрийн хуралд тус тус танилцуулсан болно. Монголбанкны 2019 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн үр дүнг Захирлуудын зөвлөлийн 2019 оны 8 дугаар сарын 5-ны өдрийн хуралд танилцуулсан.	Бнелэлт-100% Монголбанкны алдагдлын талаар Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн байна.

3.	ТТ-т албан Бичгээр хүргүүлсэн	2017.09.27- ний өдрийн хурлын тэмдэглэл	7.	Монгол улсын эдийн засгийн хямралд гадаад валютын ханшийн өсөлт гол нөлөө үзүүлж байна. Ханшийн энэ өсөлтөд бодитой болон зохиомол хүчин зүйл нөлөөлж байгаа нь тодорхой байгаа. Иймд энэ асуудлыг Монголбанкнаас зориуд хөрөнгө гаргаж судалгааны баг ажиллуулж дүгнэлт гаргуулах нь зүйтэй.	ССГ	Монголбанкнаас Эн Ар Си Си судалгааны байгууллагатай хамтран валютын ханшид нөлөөлөгч хүчин зүйлсийг судалж, удирдлагуудад танилцуулсан бөгөөд "Эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын чиг хандлага" сэдэвт эрдэм шинжилгээний хуралд тус судалгааны ажлыг танилцуулж, хэвлэмэл хувилбарыг холбогдох байгууллагуудад хүргүүлсэн болно.	Биеэлт-100% Эн Ар Си Си судалгааны байгууллагатай хамтран валютын ханшид нөлөөлөгч хүчин зүйлсийг судалж, үр дүнг удирдлагуудад танилцуулжээ.
			8.	2013 онд Чингэс бондын 1.5 тэрбум долларыг тухайн үеийн ханшаар төгрөгт хөрвүүлж Хөгжлийн банкинд өгсөн гэдэг. Үүнээс болж Хөгжлийн банк асар их хэмжээний алдагдал хүлээсээр байгаа. Энэ их хэмжээний валют орж ирснээр валютын ханшийн өсөлтийг сааруулах боломжтой байсан ч 2013-2016 онуудад гадаад валютын ханш зогсолтгүй өссөөр байлаа. Үүнээс уламжлан тухайн их хэмжээний валютын зүй зохистой ашиглалтын талаар буруу зөрүү ойлголт хэвлэл мэдээллийн мөрөглөөр гардаг байна. Энэ асуудлыг шалгаж бодит байдлыг тогтоож олон түмэнд мэдээлэл өгөхийг МБЕ-д зөвлөж байна.	ОНСБТ	2013 онд төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханш 15.5 хувиар, бодит ханш 7.2 хувиар суларсан нь дэлхийн зах дээрх манай экспортын гол нэрийн бүтээгдэхүүний үнэ унаж, гадаад худалдааны нөхцөл муудсан, гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс буурсан төдийгүй 7-р сарын сүүлчээр валютын захад үүссэн огцом цочрол, сөрөг хүлээлтийн үр дагавар байв. Түүнчлэн, урсгал тэнцлийн алдагдал 2013 онд 3.2 тэрбум доллар буюу ДНБ-ий -26%-тай тэнцэх хэмжээнд хүрэхэд мөчлөг дагасан төсвийн огцом тэлэлт, хэрэглээний импортын огцом өсөлт, уул уурхайн үйлдвэрлэлтэй холбоотой шатахууны импортын өсөлт, нхэвчлэн төсвийн шинж чанартай хөрөнгө оруулалтаар санхүүжигдэх тоног төхөөрөмж, машин механизмын импортын өсөлтүүд нөлөөлсөн. Төлбөрийн тэнцлийн алдагдал 2013-2016 онуудад огцом буурахад дэлхийн зах зээл дээр түүхий эдийн үнэ буурсантай холбоотой боловч доорх шалтгаанууд хавсран нөлөөлжээ. Үүнд: • 2012 онд дэлхийн зах зээл дээр арилжаалсан бондуудын хүүгийн төлбөрийн өсөлт нь орлогын дансны алдагдлыг нэмэгдүүлсэн. • Түүхий эдийн үнийн бууралтаас шалтгаалан аж, ахуй нэгжүүд /ялангуяа гадаадын хөрөнгө оруулалтын уул, уурхайн аж ахуйн нэгжүүд/-ийн ашиг буурсантай холбогдон ГШХО татарсан. • Олон улсын санхүүгийн байгууллагуудын бодлогын зөвлөгөөг үл харгалзан богино хугацааг харсмы, тогтвортой байх боломжгүй бодлого хэрэгжүүлснээр гадаадын хөрөнгө оруулагчдын итгэлийг алдсан.	Биеэлт-100% ОНСБТ-өөс цахим хуудсуудад ярилцлага өгөх хэлбэрээр танилцуулахаас гадна хэвлэлийн бага хурлаар мөнгөний бодлогын шийдвэр гарах бүрт мэдээлэл өгч ажилласан байна.

					• Дэлхийн зах дээрх түүхий эдийн үнэ 2013-2016 онд бодлого боловсруулагчдын хүссэн шиг сэргээгүй нь улам муудсаар байсан нь төлбөрийн тэнцлийн алдагдал буурах боломжийг хязгаарлаж, манай эдийн засагт орж ирэх валютын урсгалд сөргөөр нөлөөлж байв. Төлбөрийн тэнцэл ирж буй сөрөг шокнийг Монголбанк зөөлрүүлэхийн тулд тогтмол интервенци хийж ханшийн сулралтыг хязгаарлаж байсан боловч энэ гадаад валютын албан нөөцийн хүрэлцээгүй нөхцөлд хүргэсэн. Монголбанк 2016 оны сүүлийн хагасаас ханшийн хэт үнэлэгдсэн түвшинд хадгалсан байдлыг залруулах, нөөцийг зохистой түвшинд хүргэх бодлого баримталж байгаа бөгөөд яагаад ийнхүү бодлогын чигийг өөрчилсөн талаар олон нийтэд тогтмол мэдээлэл өгч ажиллаж байна. Энэ талаар цахим хуудсуудад ярилцлага өгөх хэлбэрээр танилцуулахаас гадна хэвлэлийн бага хурлаар мөнгөний бодлогын шийдвэр гарах бүрт мэдээлэл өгөн ажиллаж байна. Цаашид олон нийттэй харилцах харилцаагаа дээшлүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлийг баримтлан ажиллаж байгаа болно.		
			9.	Банкны 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон санхүүгийн тайлант жилийн алдагдал 1,647,585 сая төгрөг, нийт хуримтлагдсан алдагдал 3,019,323 сая төгрөг (сөрөг 3 их наяд 19 тэрбум 323 сая төгрөг)-т хүрээд байна. Төв банкны тухай хуулийн 38 дугаар зүйлд заасан шаардлагыг хангаж ажиллах үүрэгтэй ба холбогдох асуудлыг Улсын Их Хуралд танилцуулж шийдвэрлүүлэхэд онцгойлон анхаарч ажиллах шаардлагатай байна.	СБГ	УИХ-д “Төв банк /Монголбанк/-ны тухай” хуулийн 38 дугаар заалтын дагуу Монголбанкны хуримтлагдсан алдагдлыг Засгийн газрын үнэт цаас гаргах замаар нөхөх талаарх санал, Монголбанкны 2012-2016 оны алдагдлын талаарх танилцуулга, Монголбанкны 2016 оны аудитлагдсан санхүүгийн тайланг 2017 оны 5 дугаар сарын 15-ны өдрийн А-1/518 тоот албан бичгээр, УИХ-ын Төсвийн байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо, УИХ дахь МАН-ын бүлэг, УИХ-ын нэр бүхий гишүүдэд Монголбанкны 2012-2016 оны хуримтлагдсан алдагдлын талаарх танилцуулгыг 2018 оны 1 дүгээр сарын 04-ний өдрийн А-1/12 тоот албан бичгээр, УИХ-д Монголбанкны 2018 оны аудитлагдсан санхүүгийн тайланг 2019 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн А-1/315 тоот албан бичгээр, УИХ-д Монголбанкны 2019 оны аудитлагдсан санхүүгийн тайланг 2020 оны 6 дугаар сарын 15-ны А-1/704 тоот албан бичгээр, УИХ-д Монголбанкны 2020 оны аудитлагдсан санхүүгийн тайланг 2021 оны 6 дугаар	Биелэлт-100% УИХ-д хуримтлагдсан алдагдлыг нөхөх талаарх санал, жил бүрийн аудитлагдсан санхүүгийн тайлангаа хүргүүлж ажиллажээ.

						сарын 29-ний өдрийн А-1/726 тоот албан бичгээр тус тус хүргүүлсэн болно. Түүнчлэн “Төв банк /Монголбанк/-ны тухай” хуулийн дагуу УИХ-ын Эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд Монгол Улсын эдийн засгийн төлөв байдал, инфляци, ханш, Монголбанкны санхүүгийн байдлын талаар жил бүр танилцуулга хийсэн болно.	
			10.	Монголбанкны бэлтгэсэн 2016/12/31-нээр гаргасан санхүүгийн тайлангийн зарим үзүүлэлтүүд тухайлбал хөрөнгө, өмч, орлого, захиргааны зардал, ханшийн зөрүүгийн алдагдал, мөнгөн гүйлгээний дүн зэрэг нь хараат бус аудитаар баталгаажсан санхүүгийн тайлан дахь дүнгээс зөрүүтэй тайлагнагдсан байна. Банкны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналтай холбоотой алдаа, түүнийг хэрхэн залруулах талаар аудиторын зөвлөмжид тодорхой тусгагджээ. Өмнөх онд ч мөн энэ алдаа дутагдал гарч байсан байна. Энэ нь нягтлан бодох бүртгэлийг хөтлөхдөө санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг нэг мөр мөрдөөгүй, бэлтгэсэн тайланд хяналт тавих ажилтан хяналт тавиагүй, хариуцлагагүй байна гэж дүгнэхээр байна. Иймд эдгээр чиглэлээр холбогдох арга хэмжээ авч ажиллахыг Төлбөр тооцоо, бүртгэлийн газарт, хэрэгжилтэнд хяналт	СБГ ДАГ	Хөндлөнгийн аудитын PWC компаниас өгсөн 5 залруулгын гүйлгээ нь хөрөнгийн анхны зөвшөөрөлтийн алдагдалтай холбоотой зөвлөмж байсан бөгөөд энэхүү алдагдлыг хэрхэн тооцож, бүртгэх талаар МБЕ-ийн 2016 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн тушаалаар батлагдсан Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлтийг оруулсан. Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон санхүүгийн тайланг НББОУС, СТОУС-д нийцүүлэн бэлтгэж, холбогдох хяналтыг тавин ажиллаж байна.	Биелэлт-100% Зөвлөмжийн дагуу Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлтийг оруулж батлуулсан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.

			тавьж ажиллахыг Дотоод аудитын газарт зөвлөж байна.			
		11.	Монголбанкны 2016/12/31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн санхүүгийн тайлантай холбогдуулан хондлогчийн аудитын компаниас удирдлагад хүргүүлсэн захидлаас үзэхэд мэдээллийн технологийн удирдлагын хяналт болох системийн аюулгүй ажиллагааг сайжруулах чиглэлээр өмнөх жилд өгөгдсөн зөвлөмжүүдийг дахин өгсөн байна. Мэдээллийн технологийн ерөнхий хяналт, мониторингийн системийг сайжруулах асуудлыг зөвлөмжийн хүрээнд хэрэгжүүлэхэд Мэдээллийн технологийн газрын оролцоо дангаараа хангалтгүй байгаа тул энэ чиглэлд банкны удирдлага холбогдох алба, газруудын оролцоо, дэмжлэгийг уялдуулан ажиллахад анхаарлаа хандуулах нь зүйтэй. Иймд энэ чиглэлд авах арга хэмжээг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн удирдлагаар хангаж ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөж байна.	МТГ ДАГ	Дотоод аудитын газраас Мэдээллийн технологийн газрын үйл ажиллагаанд аудит хийж холбогдох үүрэг, даалгавар өгч ажилласан. 2017 онд тус газрын үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар хэрэглэгчийн хандалтад хяналт тавих, хязгаарлах үйл ажиллагааг журамлах, давуу эрхтэй хэрэглэгчдэд тавих хяналт, нийт хэрэглэгчдэд тавих хяналтын талаар зохицуулсан журам боловсруулж батлуулах үүрэг даалгавруудыг өгсөн. Мөн мэдээллийн технологийн чиглэлээр мэргэшсэн ажилтныг ДАГ-ын хянан шалгагчаар томилуулсан болно. Мэдээллийн технологийн газрын үйл ажиллагаанд хийсэн аудитын тайланг зөвлөхтэй хамтран боловсруулж, удирдлагад танилцуулж, “Монголбанкны мэдээллийн технологийн аудит хийх ерөнхий заавар” боловсруулахаар ажиллаж байна.	Бнелэлт-100% Дотоод аудитын газраас Мэдээллийн технологийн газрын үйл ажиллагаанд аудит хийж, аудитын тайланг зөвлөхтэй хамтран боловсруулж, удирдлагад танилцуулсан. Цаашид мэдээллийн технологийн хяналтыг сайжруулах, үр дүнтэй хяналт шалгалтыг хийх зорилгоор олон улсын стандарт, арга аргачлалыг судлан “Монголбанкны мэдээллийн технологийн аудит хийх ерөнхий заавар”-ын төсөл боловсруулж байна. Мэдээллийн аюулгүй байдлын албыг УТГ-ын АА-ын бүтцэд шинээр байгуулж, мэдээллийн технологийн үйл ажиллагааны хяналтыг сайжруулсан.

			12.	Монголбанкны санхүүгийн үйл ажиллагаанд аудитын байгууллагыг сонгохдоо Монгол банкны Ерөнхийлөгч, түүний томилсон гүйцэтгэх удирдлагаас бүрдсэн ажлын хэсэг шийдвэрлэж байгаа нь учир дутагдалтай. Иймд Монголбанкны Хяналтын зөвлөл нь ажлын хэсгийн судалж бүрдүүлсэн материалыг үндэслэн аудитын байгууллагыг сонгох шийдвэр гаргадаг байх. Аудитын байгууллагыг сольж байгаа тохиолдолд оны эхэнд буюу нэгдүгээр улиралд багтаан сонгон шалгаруулдаг байх. Монголбанкны Хяналтын зөвлөл, хөндлөнгийн аудитын байгууллага хамтран уялдаатай ажиллах бололцоог бүрдүүлэх. Хяналтын зөвлөл аудитын явцын мэдээлэл сонсох боломжтой байх зэрэг асуудлыг хуулийн өөрчлөлтөд оруулах, журамлаж ажиллахыг Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөж байна.	ДАГ	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А-242 дугаар тушаалаар “Монголбанкны санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах журам”-ыг батлуулж, мөрдөн ажиллаж байна. Монголбанкны санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт Хяналтын зөвлөлийн төлөөллийг оролцуулж байгаа болно.	Биелэлт-100% Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А-242 дугаар тушаалаар “Монголбанкны санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах журам”-ыг батлуулж, мөрдөн ажиллаж байна. Монголбанкны санхүүгийн тайланд аудит хийх хуулийн этгээдийг сонгон шалгаруулах ажлын хэсэгт Хяналтын зөвлөлийн төлөөллийг оролцуулж байна.
Эдийн засгийн хүү, зээлээр дэмжих бодомжийн тухай	2018.01.15 №1	13.	“Хувийн хэвшил, бизнесийн үйл ажиллагааг хөрөнгийн эх үүсвэр, зээлийн хүүгээр дэмжих болон Монгол улсын бизнесийн орчны талаар” Хяналтын зөвлөлийн гишүүн Л.Лхагважавын илтгэлд дурдсан мэдээлэл,	МБГ НУСЗЗГ	Монголбанкны Мөнгөний бодлогын хорооны 2020 оны 5 дугаар тогтоолоор урт хугацаат репо арилжааг нэвтрүүлсэн. Нийт 8 удаагийн хурлаар 1,430 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор баталснаас 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн байдлаар 1,379.2 төгрөгийн санхүүжилтийг банкуудад олгоод байна. Банкууд нийт 1,510.9 тэрбум төгрөгийн зээлийг дахин санхүүжүүлэх болон шинээр зээл олгохоор	Биелэлт-100% Тус зөвлөмжийг бодлогын шийдвэртээ тусган анхаарч ажиллажээ.	

				судалгааны дүн, санал, Хяналтын зөвлөлийн дүгнэлтийг анхааралд авч, ажил хэрэгтээ тусган ажиллах, ялангуяа экспортын үйлдвэрлэл, үйлчилгээг зээл, хүүгийн бодлогоор дэмжих замаар хувийн хэвшлийг ханшийн эрсдэлээс хамгаалж, улмаар төгрөгийн тогтвортой байдлыг хангах суурь асуудалд онцгой анхаарах;		судалсан байна. Үүнээс 66,617 ажилтантай 3,639 зээлдэгчийн 1,248.8 тэрбум төгрөгийн дүн бүхий гэрээг байгуулаад байна. МБЕ-ийн даалгаврын дагуу "Экспортыг нэмэгдүүлэх, импортыг орлох бүтээгдэхүүн үйлдвэрлэгч дотоодын компаниудыг дэмжихэд зориулсан санхүүжилтийн схем", "Ноолуурын үйлдвэрлэл, экспортыг дэмжих санхүүжилтийн схем" зэрэг судалгааны ажлуудыг хийж удирдлагуудад танилцуулан холбогдох газруудад хүргүүлсэн. Түүнчлэн, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар Монголбанк, ХХААХҮЯ, Сангийн яам, Монголын тогтвортой санхүүжилтийн холбоо зэрэг байгууллагуудын төлөөллөөс бүрдсэн Уул уурхайн бус экспортод тулгамдаж буй санхүүжилтийн асуудлыг шийдвэрлэх, санал зөвлөмж боловсруулах ажлын хэсгийг 2021 онд байгуулж ажиллав. Энэ хүрээнд Монголбанкнаас ноолуурын салбарын аж ахуй нэгжүүдэд 70 орчим тэрбум төгрөгийн урт хугацаат репо санхүүжилтийн эх үүсвэр авах боломжийг нээж өгсөн бөгөөд түүнээс 20 орчим тэрбум төгрөгийг аж ахуй нэгжүүд авсан байна.	
	14.	Үнэ, ханшийн түвшин зохих хэмжээнд, тодорхой хугацааны турш тогтвортой хадгалагдсан нөхцөлд арилжааны банкуудын үйлдэл эс үйлдэлд ажиглалт явуулж, тэд санхүүгийн зах зээл дэх давуу байдлаа ашиглаж, зээлийн хүүг хэт өндөр тогтоож буй эсэх талаар судалгаа, дүгнэлт хийж, хүүгийн бодлогын асуудлаар арилжааны банкуудтай яриа хэлэлцээ хийдэг болох;	ССГ ХШГ	Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн дугаар А-167/139/399/37 хамтарсан тушаалаар "Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023"-ийг баталж, хэрэгжүүлсэн. 2019 онд "Монголын эдийн засаг дахь тэнцвэрт хүүний түвшинг үнэлэх нь" сэдэвт судалгааны ажлыг олон улсын "International Economics" сэтгүүлд хэвлүүлсэн. Монголбанкны Ерөнхийлөгчийн А-241 дугаар тушаалаар "Зээлийн хүүг бууруулах стратегийн баримт бичгийн төсөл" боловсруулах ажлын хэсэг байгуулагдсан. Зээлдэгчдийн дийлэнх нь өмнө нь авсан өндөр хүүтэй зээлээ шинэ аргачлалын хүрээнд бага хүүтэй зээлээр солих буюу дахин санхүүжилт хийж байна.	Биелэлт-100% Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2018 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн дугаар А-167/139/399/37 хамтарсан тушаалаар "Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023"-ийг баталж, хэрэгжүүлэн банкуудтай хамтран		

				Монголбанк бодлогын хүүг 2019 онд 2 хувиар бууруулсан. Ингэснээр зээлийн хүү буурч эхэлсэн. Зээлийн хүүгийн 60 хувийг эх үүсвэрийн хүү эзэлж байгаа нь харагдсан. Эх үүсвэрийн хүү буураад эхэлж байгаа нь зээлийн хүүг бууруулах нөлөөг үзүүлсэн. Зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд зээлийн хүү буурах макро эдийн засгийн орчинг бүрдүүлэх, бодлогын үр нөлөөг нэмэгдүүлэх (бодлогын хүүний шилжих сувгийг хүчтэй болгох), банкуудын эрсдэл даах чадвар, үр ашиг болон засаглалыг сайжруулахад анхаарлаа хандуулж ажилласны үр дүнд зээлийн дундаж хүү 2017 онд 19.0 хувь, 2018 онд 16.9 хувь, 2020 онд 14.8 хувь, 2021 онд 14.3 хувь, 2022 оны 08 дугаар сарын байдлаар 14.7 хувьд тус тус хүрээд байна.	ажиллаж зээлийн хүүг тодорхой түвшинд бууруулж чаджээ.
15.	Үнэ, ханшийн эрсдэлийг багасгах үүднээс зарим орнуудын төр засгийн тэргүүн, санхүү, банкны удирдах ажилтнууд үнэ, ханшийн талаар олон нийтэд сэдэл өгөх аливаа үйлдлийг олон нийтийн хэвлэл, мэдээллээр хийхгүй байх тухай олон улсын шилдэг туршлагыг судалж нэвтрүүлэх	ОНСБТ	Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын Төв банкны олон нийттэй харилцах стратегийг судлан Монголбанкны олон нийттэй харилцах стратегийг боловсруулан удирдлагаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллаж эхэлсэн. Тус стратеги нь үндсэн 4 зорилтын хүрээнд хэрэгжиж байгаа ба ханшийн харилцааг онцлон оруулж өгсөн болно. Үүний хүрээнд тогтмол сургалт, уулзалтуудыг хийж, хэвлэл мэдээллийн байгууллагуудыг мэдээллээр хангаж, мэдээллийн тэгш бус байдлыг арилган, спекуляци шинжтэй ханшийн өөрчлөлтийг бууруулахад анхаарч байна. Ингэхдээ валютын ханшийн хүрээнд мессежүүд өгөхдөө болгоомжтой хандаж, огцом савлагаа үүсгэхгүй байх тал дээр анхаарч, урьдчилан сэргийлж ажиллаж байгаа болно. Мөн хэвлэлийн мониторингийг хийж, ханштай холбоотой худал ташаа мэдээллийг таслан зогсоох чиглэлийн мессежүүдийг бэлтгэн олон нийтэд сошиал хуудсаараа дамжуулан хүргэж байна. Стратегид заасанчлан шаардлагатай тохиолдолд Хэвлэлийн бодлогын зөвлөлийн хурлыг хуралдуулж мэдээлэл гаргадаг болно. Мөнгөний бодлогын хорооны мэдэгдэл гарах бүрд олон нийтэд тухай бүр мэдэгдэлтэй холбоотой үнэ, ханшийн эрсдэл гэх мэт сэдвүүдээр хөөрөгдөл үүсгэхгүй байхаар олон улсын туршлага,	Биедэлт-100% Хөгжингүй болон хөгжиж буй орнуудын Төв банкны олон нийттэй харилцах стратегийг судлан Монголбанкны олон нийттэй харилцах стратегийг боловсруулан удирдлагаар батлуулж, хэрэгжүүлэн ажиллажээ. Олон нийтэд хандсан бүх төрлийн мэдээлэл, хурал, ярилцлагын чанарт байнга хяналт тавьж анхааран ажилладаг.	

						Монголбанкны стратегийг баримтлан ажиллаж байна. 2018 оноос хойш Мөнгөний бодлогын мэдэгдэл нийт 22 удаа гарсан байна. “Эдийн засаг энгийнээр- Төв банкны мэдлэг” /Sharing Central bank knowledge/ стратегийг боловсруулах ажлыг эхлүүлэн олон улсын банкуудын сайн туршлагыг судалж мөн Монгол улсын иргэдийн эдийн засгийн мэдлэгийг тогтоох судалгааны ажил хийгдэж байгаа болно.	
	Гадаад валютын нөөц, түүний удирдлага, Монголбанкны эрсдэлийн менежментийн тухай	2018.01.15 №2	16.	Монголбанкны хувьд своп хэлцлийн хүрээнд үүссэн өр, зээлийн үлдэгдэлд төлж буй хүү, дотоодын банкуудтай байгуулсан валютын форвард хэлцлийн ханш, хүүгийн алдагдал зэрэг нь Монголбанкны алдагдлыг бууруулах талаарх хүчин чармайлтыг үр дүнгүй болгох эрсдэлтэй байгааг анхааралдаа авч ажиллах;	НУСЗЗГ	Арилжааны банкуудын богино хугацааны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад дэмжлэг үзүүлэх, валютын ханшийн эрсдэлээс хамгаалах зорилгоор Монголбанк төгрөг, ам.долларын своп, форвард хэлцлийг байгуулдаг. “Гол нэр төрлийн зарим бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт, хомсдлоос сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах тухай хууль”-ийн 5.1.3-т заасны дагуу 2022/09/30-ны өдрийн байдлаар АИ-92 шатахууны 2022 он дуусталх шатахууны импортын төлбөрт зориулж 132.6 сая ам.долларын форвард хэлцлийг банкуудтай байгуулаад байна. ХАБ-тай байгуулсан своп хэлцлийн гэрээний хүрээнд 2016 оноос хойш нэмэлт ашиглалт хийгээгүй бөгөөд үндсэн төлбөрийн хугацааг сунгаж, хүүний төлбөрийг жил бүр гүйцэтгэж байна.	Биелэлт-100% Анхааралдаа аван ажиллаж байна.

			17.	Гадаад валютын нөөцийн өсөлт, түүний баталгаа Монгол Улсын төлбөрийн тэнцвэс ихээхэн хамаарах тул түүнд гүнзгий судалгаа хийж, холбогдох арга хэмжээг авах;	НУСЗЗГ МБГ	МБГ-аас Төлбөрийн тэнцлийн төсөөллийг улирал тутам боловсруулан Мөнгөний Бодлогын Хорооны хурлаар танилцуулдаг. ГВУН-ийн удирдлагын хүрээнд Төлбөрийн тэнцлийн төсөөллийг тухай бүр МБГ-аас авч ГВУН-д ирж болзошгүй дарамт, гарах урсгалыг тодорхойлон ажилладаг. Төлбөрийн тэнцлийн судалгаа, тооцоололтой холбоотой доорх ажлуудыг МБГ-аас гүйцэтгэж байна. (i) Төлбөрийн тэнцлийн улирал тутмын гүйцэтгэлийн тоон мэдээнд дүн шинжилгээ хийж "Инфляцын тайлан"-д тусган олон нийтэд мэдээлж байна. (ii) Мөнгөний бодлогын шийдвэр болон бусад макро эдийн засгийн бодлогын шийдвэр гаргалтад орц бүтээгдэхүүн болгон ашиглахаар төлбөрийн тэнцлийн төсөөллийг МБГ-аас улирал тутамд боловсруулж байна. Мөн өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр (ӨСХ)-ийн улирлын үнэлгээг хийхээр ОУВС-гийн баг Монгол улсад ирж ажиллах бүрд (2018 оны 1,5,8,11-р саруудад) боловсруулан удирдлага, холбогдох мэргэжилтнүүдийг мэдээллээр ханган ажиллав. (iii) МУ-ын төлбөрийн тэнцэл дэх экспорт, импортын үнэ болон орлогоос хамаарах эрэлтийн мэдрэмжийг тооцсон эмпирик судалгааны ажлыг 2018 оны III улиралд хийж гүйцэтгэв. Уг судалгаа нь Монголын гадаад худалдааны орлого болон үнийн мэдрэмжийг тоон утгаар тодорхойлж, ханш сулрах (чангарах)-д гадаад худалдааны тэнцэл сайжирдаг (мууддаг) болохыг тогтоосон бөгөөд уг үр дүнг мөнгөний бодлогын тооцоо, шинжилгээнд ашиглах ач холбогдолтой юм.	Биелэлт-100% Зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган авч холбогдох судалгааг хийж, бодлогын шийдвэр гаргалтанд ашиглажээ.
			18.	Гадаад валютын нөөцийн мэдээлэл, тайланг олон улсын стандартад нийцүүлэх, Монгол улсын өрийн үйлчилгээ 2022 оныг дуустал жилээс жилд нэмэгдэх эрсдэлийг тооцож ажиллах;	НУСЗЗГ ЭУА	ССГ нь ОУВС-ын "Мэдээлэл түгээх тусгай стандарт" (SDDS)-ын дагуу Монгол Улсын гадаад валютын албан нөөцийн мэдээллийг бэлтгэж, холбогдох журамд нэмэлт өөрчлөлтийг оруулснаар, олон нийтэд мэдээлж эхэлсэн. Түүнчлэн Монгол Улсын нийт гадаад өрийн статистикийг нэгтгэж, улирал бүр олон нийтэд мэдээлдэг. ОУВС-аас Монгол улс "Мэдээлэл түгээх тусгай стандарт"-ын шаардлагыг хангасан талаар 2019 оны	Биелэлт-100% Зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган ажиллажээ.

					4 дүгээр сарын 2-ны өдөр мэдээлсэн. Энэ талаарх мэдээг Монголбанкны цахим хуудсаар дамжуулан олон нийтэд хүргэсэн. НУСЗЗГ нь гадаад өрийн эргэн төлөлтийн хуваарийг салбар, хугацаа, валют, өрийн хэрэгслийн төрлөөр дэлгэрэнгүй байдлаар ССГ-аас авч, гадаад валютын албан нөөцийн тооцоолол болон бусад холбогдох тооцоо судалгаанд тогтмол ашигладаг.Түүнчлэн ГВУН-ийн урсгал, хүрэлцээт байдлын тайланг сар бүр боловсруулан удирдлагад танилцуулдаг бөгөөд тооцоололд ирэх онуудад төлөгдөх ЗГ-ын өр төлбөр, Төлбөрийн тэншлийн төсөөлөл зэрэг мэдээллүүд ашиглагддаг. 1. Гадаад валютын нөөцийн мэдээлэл, тайланг олон улсын стандартад нийцүүлэх талаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: i. <u>2021-2022 он</u>: ГВУН-ийн тайлагналыг олон улсын стандартад нийцүүлэн сайжруулах ажлыг 2021 оны 1 дүгээр улирлын албаны дотоод ажлын төлөвлөгөөнд тусгасан. Уг ажлын хүрээнд Дэлхийн банк, Европын холбооны банкны туршлагыг судалж, ЭУА-аас боловсруулдаг тайлангуудад холбогдох өөрчлөлтүүдийг оруулав. Үүнд, өдөр тутмын болон долоо хоногийн тайланг албаны хүрээнд тайлагнах, өдрийн тайланг Удирдлагын мэдээллийн санд байршуулах, улирлын тайланд зах зээлийн хүчин зүйлсээс шалтгаалж үүссэн голлох нөлөөг харуулах зэрэг агуулгын өөрчлөлтийг тусгаж удирдлагад тайлагнаж ажиллаж байна. ii. <u>2020 он</u>: ГВУН-ийн эрсдэл үр өгөөжийн тооцоолол, гүйцэтгэлийн тайлагналыг сайжруулах зорилгоор судалгаа хийх ажлыг 2020 оны 1 болон 2 дугаар улирлын албаны дотоод ажлын төлөвлөгөөнд тусгаж Дэлхийн банк, CFA Institute зэрэг байгууллагын туршлагыг судалж холбогдох өөрчлөлтүүдийг	
--	--	--	--	--	--	--

				ГВУН-ийн өдөр тутмын тайлант нэвтрүүлсэн. Үүнд, үр өгөөжийн тооцоолол дахь мөнгөн урсгалын нөлөөллийг арилгах өөрчлөлтийг оруулан, багцын үр өгөөжийн тооцооллыг багцын үнэ цэнийн өөрчлөлтөөс хамааруулж тооцдог байхаар өөрчилж, ГВУН-ийн үр өгөөжийн тооцооллыг сайжруулсан. ГВУН-ийн богино болон урт хугацаат багцын эрсдэл үр өгөөжийн гүйцэтгэлийг зах зээлийн хүчин зүйлсээс хамааруулах, жишиг багцтай харьцуулж гүйцэтгэлийг тооцдог байхаар холбогдох өөрчлөлтүүдийг өдөр тутмын тайланд нэвтрүүлж тайлагналыг сайжруулсан. 2. Засгийн газар, банкууд, ААН-ийн гадаад бонд, өрийн үндсэн төлбөр, хүүний төлбөрийн жилийн хуваарьтай уялдуулж ГВУН-ийн хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд гадаад валютын хэрэгцээг урьдчилан тодорхойлж байна. Түүнчлэн богино хугацаат өрийн мэдээлэлтэй уялдуулж богино хугацаат багцын хэмжээг тодорхойлох замаар ГВУН-ийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангаж ажиллаж байна.	
19.	Ханшийн гэнэтийн өөрчлөлтөөс сэргийлэх үүднээс гадаад валютын арилжаа, валют солилцооны үйл ажиллагааг улсын хэмжээнд нийтэд нь банк хоорондын цахим талбар, интернетийн үйлчилгээ, клирингийн данс зэргээр дамжуулах, улмаар валютын нэгдсэн зах бий болгох техникийн боломж, эрх зүйн орчин бүрдүүлж ажиллах.	НУСЗЗГ ХЭЗГ	Төрөөс мөнгөний бодлогын талаар 2018 онд баримтлах үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 1.2.1-т Банк хоорондын валют арилжааны цахим талбар (БХВАЦТ)-т оролцогчдын тоог нэмэгдүүлэх, банк хоорондын валютын захыг идэвхижүүлэх талаар судалгааг хийж гүйцэтгэх, 1.2.2-т цахим талбарын програм хангамжийг дотоодын програм хангамжид суурилан бий болгож нэвтрүүлэхээр заасан. Тус ажлын хүрээнд цахим талбарт оролцогч банкуудаас асуулга авах, бусад орнуудын валютын захын бүтэц, арилжааны дэд бүтцийн туршлагын талаар судлах ажлуудыг гүйцэтгэсэн ба 2018 оны 12 дугаар сард Монголбанкны дотоодын програм хангамжид суурилсан цахим талбарыг албан ёсоор нэвтрүүлж, "Банк хоорондын цахим талбарт валют арилжаа хийх ерөнхий гэрээ"-нд шаардлагатай өөрчлөлтийг оруулан Монголбанкны	Биелэлт-100% Монголбанкны дотоодын програм хангамжид суурилсан цахим талбарыг албан ёсоор нэвтрүүлж, "Банк хоорондын цахим талбарт валют арилжаа хийх ерөнхий гэрээ"-нд шаардлагатай өөрчлөлтийг оруулан Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлуулжээ. Тус цахим талбараар дамжуулан 2019 онд	

					Ерөнхийлөгчийн тушаалаар батлуулсан. БХВАЦТ-н шинэ хувилбарыг нэвтрүүлснээр (i) Блүмберг терминалгүй банкууд нэгдэн орох боломжтой, (ii) Цахим талбартай холбоотой ямар нэгэн асуудал гарсан тохиолдолд хурдан шуурхай шийдвэрлэнэ, (iii) Мэдээллийн аюулгүй байдал сайжирсан, хийгдэж буй арилжааны бүх мэдээлэл Монголбанкны мэдээллийн санд үлдэнэ, (iv) Монголбанкны валютын захын оролцооны үр өгөөж нэмэгдэж байгаа, валютын дуудлага худалдааны програмыг цаашид нэгтгэнэ (v) Холбогдох сайжруулалт, өөрчлөлтүүдийг цаг алдалгүй хурдан шуурхай хийж гүйцэтгэх боломжтой зэрэг давуу талууд бий болж байна. Тус цахим талбараар дамжуулан 2019 онд 164.6 сая ам.доллар, 2020 онд 153.9 сая ам.доллар, 2021 онд 33.1 сая ам.доллар, 2022 оны эхнээс 9 сарын 30-ны өдрийн байдлаар 14.4 сая ам.долларын валют арилжаа банк хооронд хийгджээ. Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, түүнийг даган гарсан захиргааны хэм хэмжээний актын дагуу төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн гадаад валютын гүйлгээ Монголбанкны клиринг, төлбөр тооцооны системээр дамжиж байна. Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Валютын зохицуулалтын тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн А-341 дүгээр тушаалаар батлагдсан “Урс хугацаат своп хэлцлийн журам”, 2017 оны 4 дүгээр сарын 05-ны өдрийн А-110 дугаар тушаалаар батлагдсан “Банк хоорондын цахим талбарт валют арилжаа хийх ерөнхий гэрээ” болон Валютын своп, форвард хэлцлийн гэрээ, Валютын своп, форвард хэлцлийн зааврын дагуу валют арилжих, солилцох үйл ажиллагааг эрх бүхий этгээд гүйцэтгэж байна.	164.6 сая ам.доллар, 2020 онд 153.9 сая ам.доллар, 2021 онд 33.1 сая ам.доллар, 2022 оны эхнээс 9 сарын 30-ны өдрийн байдлаар 14.4 сая ам.долларын валют арилжаа банк хооронд хийгджээ.	
	Төв банкны мэдээллийг олон нийтэд хүргэх, санхүүгийн суурь боловсрол олгох ажлын явц, үр дүнгийн тухай	2018.06.20 №3	20.	Сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны хүүхдүүдэд санхүүгийн суурь мэдлэг, боловсрол олгох чиглэлээр, төрийн болон төрийн бус байгууллагуудтай (Засгийн	ОНСБТ	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 5 дугаар сарын 02-ны өдрийн А-1/534 дугаартай албан тоотоор Монголбанкны зүгээс улс орны нийгэм эдийн засгийн хөгжил, хүн амын амьдралын чанарыг дээшлүүлэхэд сурагчдад хувийн санхүү, бизнесийн мэдлэг, чадварыг багаас нь олгох нь туйлын ач холбогдолтой гэж үзэж буй "Олон	Бнелэлт-100% Зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган авч, сургуулийн өмнөх насны болон сургуулийн насны хүүхдүүдэд

			газар, БСШУЯ, арилжааны банк...гм) хамтарч ажиллахад дэмжлэг үзүүлэх;	нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэхтэй холбон хийж буй ажлыг бүх талаар дэмжин туслахад бэлэн байгаагаа илэрхийлсэн билээ. 2018 оны Дэлхийн хуримтлалын өдрийг сургуулийн насны хүүхдүүдэд зориулсан олон талт арга хэмжээнүүдийг арилжааны 10 банк болон Монголын банкны холбоо, Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран 10 сарын турш зохион байгуулав. Монголбанкнаас Хадгаламжийн Даатгалын Корпораци, ХБНГУ-ын Шпаркассэ банкны сан, Монголын Банкны Холбоотой хамтран “Дэлхийн хуримтлалын өдөр-2021” аяныг “Бүгдээрээ хуримтлуулъя” уриатайгаар Төв аймгийн Зуунмод хотод нээлтийн арга хэмжээг зохион байгуулав. Энэ жилийн хувьд тус аяны нээлтийн арга хэмжээ анх удаа орон нутагт болсноороо ихээхэн онцлогтой болсон юм. Нээлтийн арга хэмжээний үеэр арилжааны банкууд хүүхэд багачуудад зориулсан бүтээгдэхүүн, үйлчилгээгээ танилцуулж, газар дээр нь хуримтлалын данс нээж ажилласны дээр хуримтлалын ач холбогдол, ашиг тус, олон улсын туршлагыг таннулах нлттэлүүдийг оролцогчдын зүгээс танилцууллаа. Уг аяны хүрээнд хамтрагч байгууллагуудтай хамтран иргэдийн санхүүгийн боловсролыг дэмжих, хуримтлалыг дадал болгоход чиглэсэн хүүхэд залуучуудын дунд гар зургийн уралдаан, цахим орчин дахь уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулснаас гадна ЕБС-ийн 500 гаруй хүүхдүүдэд сургалт, уулзалтуудыг хийж, хуримтлалын ач холбогдлыг таниулж, сурталчилав. Банкны салбарын нийт хадгаламжийн хэмжээ 2021 оны 10-р сарын байдлаар 18.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 1.9 их наяд төгрөгөөр буюу 12 орчим хувиар өсөөд байна. Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх ажлын хүрээнд “Дэлхийн Мөнгөний Долоо Хоног-2022” аяныг “Мөнгөө ухаалгаар удирдаж, ирээдүйгээ өөрөө бүтээ” урлан дор 2022 оны 3 дугаар сарын 14-ний өдрөөс 27-ны өдрийн	санхүүгийн суурь мэдлэг, боловсрол олгох чиглэлээр ажлууд зохион байгуулж ажиллажээ.
--	--	--	---	---	--

					хооронд хүүхэд, залуучуудад санхүүгийн мэдлэг, мэдээлэл олгох, улмаар санхүүгийн салбарын үйл ажиллагааг олон нийтэд таниулах зорилгоор 20 байгууллага хамтран зохион байгуулж сошиал орчин болон сургалтуудаар дамжуулан 3 сая иргэнд хүрсэн болно.	
			21.	БСШУЯ-ны боловсролын хөтөлбөрт “Бизнес судлал” хичээлийг ЕБС-ийн ахлах X, XI, XII ангиудад заавал судлах хичээл болгон оруулах боломжийг судалж, хэрэгжүүлэх	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны 5 дугаар сарын 02-ний А-1/534 дугаартай албан тоотгоор Монголбанкны зүгээс санхүүгийн мэдлэг олгох сонгон судлах Бизнес судлал хичээлийг ЕБС-ийн ахлах ангид заавал судлахаар оруулах хүсэлтийг БСШУСЯ-д уламжилсан боловч санхүүгийн боловсролын талаарх мэдлэг, чадварыг сурагчид математик, газар зүй, технологи, нийгмийн ухаан, иргэний боловсрол болон амьдрах чадварт суралцах үйл ажиллагаагаар тус тус эзэмшдэг талаар хариу ирүүлэв. БСШУЯ-ны сайдын 2019 оны 08 сарын 01-ны өдрийн А/491 “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай тушаалаар Ахлах ангийн сургалтын төлөвлөгөөнд Бизнес судлал хичээлийг сонгон судлахаар оруулсан байна. 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн А/165 дугаартай БШУ-ны сайдын “Теле болон цахим хичээл зохион байгуулах тухай” тушаалаар Монголбанк, СЗХ, НСБҮТ-тэй хамтран 6 /зээл, ипотека, мөнгөн тэмдэгт, төлбөр тооцоо, даатгал, үнэт цаас/ төрлийн теле хичээл боловсруулан Стар телевизээр тухай бүр гаргасан болно. Боловсрол шинжлэх ухааны сайдын 2022.05.24-ны өдрийн 1а/2508 дугаартай “Хүсэлт хүргүүлэх тухай” албан тоотын дагуу БШУЯ, БМТТ-тэй хамтран ЕБС-ийн сургалтын хүрээнд цахим контентын сан бүрдүүлэх ажлыг гүйцэтгэж байгаа болно. Энэ нь хил хязгаар, цаг хугацаанаас үл хамааран хүн бүр суралцах сургалтын нээлттэй орон зайг бий болгож байгаа тул сургуулийн хүрээнээс хальж эх орон, дэлхийн өнцөг булан бүрд байгаа мянга мянган хүүхдэд өөрийн мэдлэг, арга зүй, сайн туршлагаа түгээх нээлттэй боломж болж байгаа юм. Иймд сонгон судлах, санхүүгийн мэдлэг олгох “Бизнес судлал” хичээлийн 10,11, 12 ангийн цахим контент	Биеэлт-100% БСШУЯ-ны сайдын 2019 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн А/491 “Сургалтын төлөвлөгөө шинэчлэн батлах тухай” тушаалаар ахлах ангийн сурагчдын сургалтын төлөвлөгөөнд Бизнес судлал хичээлийг сонгон судлахаар оруулжээ.

					боловсруулах ажлыг хийж байгаа бөгөөд www.medlee.mn хуудаснаас интернет харгалзахгүйгээр ахлах ангийн сурагчид тус хичээлийг сонгон судлах боломжтой болсон. Боловсролын Мэдээлэл Технологийн төвийн дэргэдэх цахим сургалтын нэгжээс 2022-2023 онд 10-р ангид суралцах 42,613 сурагчдаас авсан судалгаагаар 1418 сурагч “ Бизнес судлал” хичээлийг сонгох хүсэлт өгсөн байна.	
		22.	Монголбанкны зүгээс санаачлан хууль, шүүх, прокурорын байгууллагууд, Сангийн яам, арилжааны банкуудтай хамтарч Монголбанк болон Банкны тухай хуулиуд, эзэл, мөнгө, санхүү, татвар, төсөв зэрэгтэй холбогдсон хууль, тогтоомжийн мэдлэгийг гүнзгийрүүлэх, сурталчлах, хуулиудын мөрдөлт, эдийн засгийн гэмт хэрэгтэй тэмцэх талаар тодорхой хөтөлбөр боловсруулан сургалт зохион байгуулж ажиллахыг зөвлөсүгэй.	ХЭЗГ ОНСБТ	Төв банк (Монголбанк)-ны тухай хууль, Банкны тухай хууль болон бусад хуулийг хэрэгжүүлэх, олон нийтэд сурталчлах асуудлаар ОНБМТ-д арга зүйн туслалцаа үзүүлэн хамтран ажиллаж байна. Тухайлбал 2018 оны 8, 9, 10 дугаар саруудад зохион байгуулсан банкны салбарийн удирдах ажилтны бүсийн зөвлөгөөн, Банкны салбарын эрсдэлийн удирдлагын зөвлөгөөнд ХЭЗГ-аас оролцон шинээр батлагдсан болон шинэчлэгдэн батлагдан мөрдөгдөж буй хууль, журмуудын талаар нэгдсэн танилцуулга, сургалт хийж, уг сэдвийн хүрээнд оролцогчдын тавьсан асуултад хариулж ажилласан. Түүнчлэн Банк санхүүгийн хууль, эрх зүйн шинэтгэлийг үргэлжлүүлэх ажлын хүрээнд Валютын зохицуулалтын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг 2018 оны 6 дугаар сарын 27-ны өдөр, Актив удирдлагын тухай хуулийн төслийг 2018 оны 7 дугаар сарын 24-ны өдөр хууль санаачлагчид хуулийн төслийн танилцуулгын хамтаар хүргүүлсэн. 2018 оны 4 улирлын байдлаар Олон нийтийн дунд “Боловсрол гэж юу вэ? Боловсрол таны амьдралд болон улс орны хөгжилд хэр чухал вэ?” сэдвийн хүрээнд эссэ бичлэгийн уралдаан зарлаж, уралдаанд ирсэн нийт 43 эссэ бичлэгээс шагналт байрыг тодруулав. “Монголбанкны сургагч оюутан-багш” хөтөлбөрийг эхлүүлж, 20 гаруй сургуулийн 2,300 орчим оюутнуудад сургалт хийн, Төв банкны үндсэн зорилт, үйл ажиллагааг нийтдээ 17,000 орчимд оюутанд таниулаад байна. Мөн “Монголбанкны цаг” сургалтыг их дээд сургууль дээр зохион байгуулж, “Эдийн засгийн	Биелэлт-100% Зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган авч, сургалт, уулзалт, бусад арга хэмжээг зохион байгуулжээ.

					ерөнхий нөхцөл байдал”, “Хувь хүний санхүү”, “Валютын ханш”, “Инфляци”, “Хуримтлал” гэх зэрэг сэдвээр 5,000 гаруй оюутанд хүрээд байна. Хуульч, прокурор нарт санхүүгийн боловсрол олгох 1 удаагийн сургалтыг зохион байгуулж ажиллав. Мөн ЦЕГ-тай 2019 онд хамтран “Санхүүгийн луйвар, сүлжээний бизнес гэх мэт сэдвээр хамтран ажиллахаар болж төлөвлөгөөг хүргүүлсэн болно. Монгол Улсын Ерөнхий Прокурорын газрын Зөрчлийн хэрэг бүртгэх ажиллагаанд хяналт тавих хэлтэстэй хамтран 2021 оны 11 дүгээр сарын 04-ний өдөр Монголбанкны эрх бүхий албан тушаалтнууд болон удирдах албан тушаалтнууд болох Монголбанкны төв, орон нутаг дахь хэлтэс, салбарын нийт 120 улсын байцаагч, хянан шалгагч нарт Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэглээний талаарх мэдлэгийг гүнзгийрүүлэх сургалтыг зохин байгуулж ажилласан. Эдийн засгийн судалгаа, сургалтын хүрээлэнгээс арилжааны банкны ажилтнуудад мэдээлэл өгөх зорилготой “Банкны ажилтнуудын семинар”-ыг цахимаар зохион байгуулсан бөгөөд энэ хүрээнд 2021 оны 6 дугаар сарын 22-ны өдөр “Улсын Их Хурлаас 2021 онд баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль” сэдэвт семинарыг Zoom платфoрмoор зохион байгуулахаар төлөвлөж байсан боловч хойшилж 2021 оны 7 дугаар сарын 1-ний өдөр зохион байгуулагдсан. Тус цахим семинарт банкны 150 гаруй ажилтан, албан тушаалтнууд ороцож хуулийн талаар мэдээлэл, тодруулга авсан. 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдөр төрийн байгууллага, эрдэм шинжилгээний байгууллага болон банкуудын төлөөллийг хамарсан “Төв банкны бие даасан хараат бус байдал, түүний эрх зүйн зохицуулалт” сэдэвт эрдэм шинжилгээний хурлыг зохион байгуулсан. 2018 оны 4 улирлын байдлаар Олон нийтийн дунд “Боловсрол гэж юу вэ? Боловсрол таны амьдралд
--	--	--	--	--	---

					болон улс орны хөгжилд хэр чухал вэ?” сэдвийн хүрээнд эсээ бичлэгийн уралдаан зарлаж, уралдаанд ирсэн нийт 43 эсээ бичлэгээс шагналт байрыг тодруулав. “Монголбанкны сургагч оюутан-багш” хөтөлбөрийг эхлүүлж, 20 гаруй сургуулийн 2,300 орчим оюутнуудад сургалт хийн, Төв банкны үндсэн зорилт, үйл ажиллагааг нийтдээ 17,000 орчимд оюутанд таниулаад байна. Мөн “Монголбанкны цаг” сургалтыг их дээд сургууль дээр зохион байгуулж, “Эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал”, “Хувь хүний санхүү”, “Валютын ханш”, “Инфляци”, “Хуримтлал” гэх зэрэг сэдвээр 5,000 гаруй оюутанд хүрээд байна. Хуульч, прокурор нарт санхүүгийн боловсрол олгох 1 удаагийн сургалтыг зохион байгуулж ажиллав. Мөн ЦЕГ-тай 2019 онд хамтран “Санхүүгийн луйвар, сүлжээний бизнес гэх мэт сэдвээр хамтран ажиллахаар болж төлөвлөгөөг хүргүүлсэн болно. Мөн Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан “Шинэ сэргэлтийн бодлого”-ын Монгол Улсын Их Хуралд 2022 онд үе шаттайгаар өргөн мэдүүлж, хэлэлцүүлэх хуулийн төслийн жагсаалтад туссан Дампуурлын тухай хуулийн шинэчилсэн найруулга буюу Төлбөрийн чадваргүйдлийн тухай хуульд санал, дүгнэлтийг хүргүүлсэн. 2021 оны 4 улирлын байдлаар Олон нийтийн дунд “Санхүүгийн залилах гэмт хэргээс сэргийлье” сэдвийн хүрээнд эсээ бичлэгийн уралдаан зарлаж, уралдаанд ирсэн нийт 200 гаруй эсээ бичлэгээс шагналт байрыг тодруулав. Мэргэжлийн хяналтын ерөнхий газар, MNBC компани, Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний ерөнхий газар, ЦЕГ, Отгонтэнгэр их сургууль, ГБХЗГ, Хасбанк, Соёлын яамны дэргэдэх Урлаг Соёлын Зөвлөл зэрэг байгууллагуудтай хамтран нийт 800 гаруй ажилтан, албан хаагчдад санхүүгийн боловсрол олгох сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулав. Төрийн банктай хамтран Санхүүгийн боловсрол олгох 100 сургагч багш бэлтгэх ажлын хүрээнд сургагч багш нарыг бэлтгэв. Уг сургагч багш	
--	--	--	--	--	--	--

					бэлтгэх сургалтад эхний ээлжинд Төрийн банкны 25 ажилтан хамрагдсан бөгөөд сургалтын хаалтын арга хэмжээнд Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван, Төрийн банкны дэд захирал Д.Сугар нар оролцож, сургагч багш нарын сертификатыг олгов. Монголбанк, МУИС хамтран эдийн засаг, санхүүгийн чиглэлийн судалгаа, сургалтыг дэмжих “Тинк банк” хөтөлбөрийг 2 дахь жилдээ хэрэгжүүлж байна. Энэхүү хамтын ажиллагааны хүрээнд тус сургуулийн ШУС-ийн эдийн засгийн тэнхим, БС-ийн Санхүүгийн тэнхимтэй судалгаа, сургалтын санал солилцохоос гадна, гэрээнд тусгаснаар Тинк Банк хөтөлбөрт 2021 онд 6 судалгааны магистрантийг шалгаруулан хамтран ажиллаж байна. Мөн хөтөлбөрийн хүрээнд Монголбанкны удирдлагууд оюутнуудтай хийх уулзалтыг зохион байгуулав. Тухайлбал, Монголбанкны Дэд Ерөнхийлөгч Г.Энхтайван МУИС-ийн эдийн засаг, санхүүгийн чиглэлээр суралцдаг оюутнуудад Финтек ба Криптовалют сэдвээр танилцуулга хийж, сонирхсон асуултад хариулт өгөв. Монголбанк, Цагдаагийн Ерөнхий газар, Монголын банкны холбоо хамтран залилах болон цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх “Ятгах тусам нягтал-2021” дөрөв дэх удаагийн аяныг 2021 оны 07 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн улсын хэмжээнд зохион явуулж байна. Иргэдэд хувийн мэдээлэл алдагдвал үүсэх эрсдэл, учрах хохирлыг таниулах, цахим орчинд мэдээллийн аюулгүй байдлыг хэрхэн хангах, залилах болон цахим гэмт хэрэгт өртөж болзошгүй иргэдэд анхааруулах зорилгоор 2019 онд “Ятгах тусам нягтал”, 2020 онд “Нягтлах тусам аюулгүй”, “Ятгах тусах нягтал-2” аяныг Цагдаагийн Ерөнхий газар, Монголбанк, Монголын банкны холбоо, банкууд хамтран зохион байгуулсан бол үүний үргэлжлэл болгон “Ятгах тусам нягтал-2021” аяныг дээрх байгууллагуудын оролцоотойгоор 2021 оны 10-р сарын 31-ний өдрийг дуустал зохион байгуулахаар боллоо. Энэ удаагийн аян нь цар тахал дэгдэлтийн үед төлбөр тооцооны эрсдэл, криптовалютад хөрөнгө оруулснаас үүдэлтэй учирч	
--	--	--	--	--	---	--

					болох эрсдэлүүдээс урьдчилан сэргийлэхэд түлхүү анхаарч байгаагаараа онцлогтой юм. Аяны хүрээнд ЦЕГ-тай хамтран хэлэлцүүлэг зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт цахимаар болон танхимаар 70 гаруй оролцогчид оролцов. Мөн Монголын банкны холбоо, ЦЕГ-тай хамтран ажлын хэсгийг байгуулж сошиал орчин, мэдээллийн хэрэгслээр контентуудыг бэлтгэн идэвхтэй хүргэв. Аяны хаалтын арга хэмжээг 10-р сард ЦЕГ-тай хамтран зохион байгуулж, аянд идэвхтэй оролцсон ЦЕГ-ын салбар, хэлтсүүд болон Монголбанкны салбар, хэлтсүүдийг шалгаруулж, шагнаж урамшуулав. Монголбанкны зүгээс санаачлан хууль, шүүх, прокурорын байгууллагууд, Сангийн яам, арилжааны банкуудтай хамтарч Монголбанк, банкны тухай хуулиуд, зээл, мөнгө, санхүү, татвар, төсөв зэрэгтэй холбогдсон хууль, тогтоомжийн мэдлэгийг гүнзгийрүүлэх, сурталчлах сургалтуудыг 2022 оны эхний 2 улирлын байдлаар 2116 хүнд хүрсэн байна.	
Монголбанкны дотоод хяналт, үйл ажиллагааны төлөвлөгөө, хэрэгжилтийн тухай	2018.11.29 №4	23.	Монголбанкны дотоод аудитын хамрах хүрээ, эрх хэмжээ, хяналт шалгалтын үйл ажиллагааг сайжруулж, төгөлдөржүүлэх;	ДАГ	"Монголбанкны дотоод аудитын дүрэм"-ийг Олон улсын аудитын стандартад нийцүүлэн боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 8 дугаар сарын 15-ны өдрийн А-214 дүгээр тушаалаар батлуулсан. ДАГ нь Дэлхийн банкны МУ-д хэрэгжүүлж байгаа "Төсөв санхүүгийн тогтвортой байдлыг сайжруулах төсөл"-н хүрээнд Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан. Зөвлөх үйлчилгээний хүрээнд эрсдэлд суурилсан дотоод аудитын тогтолцоог сайжруулах, нэвтрүүлэхээр төлөвлөгөө гарган ажиллаж байна.	Биелэлт-60% “Чанарын баталгаажуулалт сайжруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах дунд хугацааны төлөвлөгөөний” дагуу Дотоод аудитын хамрах хүрээг боловсруулах ажил 50 хувьтай, “Аудитын эрсдэлийн үнэлгээ хийх, төлөвлөгөө боловсруулах заавар” боловсруулах ажил 70 хувьтай хийгдэж байна.

			24.	Мэдээллийн технологийн хурдацтай хөгжил түүнийг дагасан мэдээллийн аюулгүй байдлыг хангах, гадны халдлагын эрсдэлээс сэргийлэх ажлыг сайжруулж, мэдээллийн технологиор мэргэшсэн аудиторoor бэхжүүлэх.	МТГ ДАГ УТГ	Мэдээллийн аюулгүй байдлыг хангах, гадны халдлагын эрсдэлээс сэргийлэх ажлыг сайжруулах зорилгоор МБЕ-ийн 2021.01.08-ны өдрийн А-2 дугаар тушаалаар УТГ-ын бүтцэд Мэдээллийн аюулгүй байдлын нэгжийг шинээр байгуулсан. Тус алба нь 1 ахлах мэргэжилтэн, нууцлалын 2 мэргэжилтэн гэсэн орон тоотой. Баталсан ба тус орон тоонд мэргэжилтэн томилогон ажиллуулж байна. Компьютерүүдийн нууцлал болон аюулгүй байдлыг шалгах, илэрсэн алдаа дутагдлыг арилгах, нийт компьютерт хортой код байгаа эсэхийг илрүүлэх, илэрснийг устгаж аюулгүй болгох зэрэг ажлуудыг хийгээд байна. Мөн нийт дотоод сүлжээний аюулгүй байдлыг нэмэгдүүлэх зорилгоор сүлжээний VLAN технологийг нэвтрүүлсэн бөгөөд гадны халдлагаас сэргийлэх галт хана төхөөрөмжүүдийг тогтмол хянаж, ажиллаж байна. АХБ-ны санхүүжилттэй Төлбөрийн системийн шинэчлэл төслийн хүрээнд Санхүүгийн байгууллага дундын тоон гарын үсгийн PKI системийг 2018 оны 10 дугаар сард нэвтрүүлсэн. Тус системийг банк хооронд их, бага дүнтэй болон картын системүүдэд ашиглаж эхэлсэн ба Монголбанк руу хандсан бусад системүүдэд хэрэглэхээр МТГ-н 2019 оны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан. Санхүүгийн байгууллага дундын мэдээллийн нууцлал, аюулгүй байдлын систем болгон ашиглах боломжийн талаар танилцуулга бэлтгэгдэж байна. “Төлбөрийн системийн шинэчлэл” төслийн хүрээнд Үндэсний цахим гүйлгээний төвд Мэдээллийн аюулгүй байдлын хяналтын төвийг байгуулж, нууцлал аюулгүй байдлыг хянах, үнэлгээ хийх, цахим халдлагаас урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах зориулалт бүхий цогц систем програм хангамжийг амжилтай нэвтрүүлсэн. Төлбөр тооцооны системийн хурдацтай хөгжил, цахим төлбөрийн тооцооны хэрэглээ нэмэгдэхийн хэрээр мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах асуудал чухлаар хөндөгдөж байна. Иймд уг системийг нэвтрүүлсэн үйл явдал нь Монгол улсын төлбөрийн систем, төлбөрийн картын	Биелэлт-100%
--	--	--	-----	--	-------------------	--	--------------

						систем, бага дүнтэй гүйлгээний АСН+ систем болон банк дундын сүлжээний нууцлал аюулгүй байдлыг өндөр түвшинд хангаж үүсч болзошгүй эрсдэлийг бууруулахад чухал ач холбогдолтой. Дотоод аудитын газарт 2021 онд мэдээллийн технологийн 2 аудитор томилогдсон, ажиллаж байна.	
Монголбанкны гадаад валютын урсгын нөөцийн тухай	2018.11.29 №5	25.	Төгрөгийн тогтвортой байдлыг ханган баталгаажуулах, валютын орлогыг нэмэгдүүлэх, зарлагыг хорогдуулахад мөнгө, зээлийн бодлого, арга хэрэгслийг илүүтэй ашиглах боломжийг судалж, хэрэгжүүлэх;	МБГ ССГ НУСЗЗГ	ГВУН-ийг нэмэгдүүлэх, ханшийн тогтвортой байдалд эерэгээр нөлөөлөх зорилгоор экспортын орлого өндөртэй төрийн өмчит болон төрийн өмч давамгайлсан ААНБ-ууд, Оюутолгой ХХК-иас 9,569.5 сая ам.долларыг, Сангийн яамнаас 840.3 сая ам.доллартай тэнцэх валютыг 2018 оноос хойш 2022 оны 10 сарын эцсийн байдлаар худалдан авсан. Мөн Монголбанк 2022/09/30-ны өдрийн байдлаар 1,574.7 сая ам.доллартай тэнцэх хэмжээтэй урт хугацаат своп хэлцлийг арилжааны банкуудтай байгуулсан нь арилжааны банкуудын гадаад эх үүсвэр татах сонирхлыг нэмэгдүүлэх, ГВУН-ийг нэмэгдүүлэх ач холбогдолтой байна. Хэрэглээний зээл хурдацтай өсөж, хэрэглээний импортыг нэмэгдүүлэн, санхүүгийн системийн тогтвортой байдалд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй тул хэрэглээний зээлийн өсөлтийг сааруулах зорилгоор өр, орлогын харьцаа болон зээлийн хугацаагаар хязгаарлах макро зохистой бодлогын арга хэмжээг авч 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлж эхэлсэн. Хэрэглээний зээлийг дагаад хэрэглээний импортын өсөлт мөн саарч, Монгол улсын валютын гарах урсгал багасахад түлхэц үзүүлнэ гэж үзэж байна. Заавал байлгах нөөцийн хувийг гадаад валютын пассивын хувьд 12 хувь, төгрөгийн хувьд 10.5 хувиар тогтоож 2019 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс мөрдүүлж эхлээд байна. Ингэснээр гадаад валюттай харьцуулахад төгрөгийн хадгаламжийн өгөөж харьцангуй өндөр тогтож, төгрөгийн ханшийн тогтвортой байдлыг ханган баталгаажуулахад дэмжлэг болохоор байна. ССГ-ын зүгээс Монголбанкны гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх хүрээнд дараах судалгаа, шинжилгээний ажлыг гүйцэтгэх болон хурал хэлэлцүүлгийг зохион байгуулсан байна.	Биеэлт-100% Зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгаж, хэрэгжүүлэн ажиллажээ.	

					• Судалгааны ажил: МУ-ын Гадаад худалдааны бодлогод анхаарах асуудлууд, Гадаад өрийн удирдлагын 2020-2030оны стратегийн баримт бичиг, Монголбанкны гадаад валютын интервенцийн валютын ханшид үзүүлэх нөлөө, Валютын ханшийн ААН-ийн санхүүгийн байдалд үзүүлэх нөлөө зэрэг судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэсэн. • Хурал хэлэлцүүлэг: “Хөрөнгө оруулалтын орчин: Тогтвортой байдал”, “Төлбөрийн тэнцэл ба Гадаад өр”, “Гадаад валютын нөөц ба боломж” зэрэг хурал, хэлэлцүүлгүүдийг 2019 онд тус тус амжилттай зохион байгуулсан. Хуралд оролцогчид манай улсын хөрөнгө оруулалтын өнөөгийн орчин, тулгарч буй сорилтууд, цаашид хөрөнгө оруулалтын орчинг сайжруулах бодит алхмуудын талаарх бодлогын нэгдсэн зөвлөмж гаргаж, төрийн эрх бүхий байгууллагууд болон олон нийтэд хүргүүлсэн.		
			26.	Монгол төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн байдалд зах зээлийн бус аливаа хүчин зүйлийн сөрөг нөлөөлөл гарахаас урьдчилан сэргийлж ажиллах	МБГ НУСЗЗГ	Макро эдийн засгийн үзүүлэлтүүд, зах зээлийн нөхцөл байдал, Монголбанкны интервенц, оролцооны талаар ОНСБТ-тэй хамтран тухай бүр олон нийтэд мэдээ, мэдээллийг хүргэж, нийтэлж байна. Мөн валютын зах дээр үүссэн богино хугацааны эрэлт нийлүүлэлтийн зөрүүг арилгах зорилгоор гадаад валютын дуудлага худалдаа болон банк хоорондын цахим талбарын арилжаагаар 2018 онд 424.3 сая, 2019 онд 534.4 сая, 2020 онд 146.6 сая, 2021 онд 1,043.3 сая ам.доллар, 2022 оны 9 дүгээр сарын 30-ны байдлаар 2,404.8 сая ам.долларыг тус тус цэвэр дүнгээр нийлүүлжээ. Улирал бүрийн "Инфляцын тайлан"-гаар дамжуулан макро эдийн засгийн дотоод, гадаад орчин, төлбөрийн тэнцэлд гарсан өөрчлөлт нь төгрөгийн гадаад валюттай харьцах ханшинд хэрхэн нөлөөлж байгааг тайлбарлаж, макро эдийн засгийн цаашдын төлөв, тодорхой бус байдал болон Төв банкны хүлээлт зэргийг танилцуулах замаар төгрөгийн гадаад валюттай харьцах ханшинд нөлөөлөхүйц зах зээлийн хүчин зүйлсийг олон нийтэд таниулан ажиллаж байна.	Биелэлт-100% Зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган авч, ханшид зах зээлийн бус хүчин зүйлийн нөлөөлөл гарахаас сэргийлэн ажиллаж байна.

Монголбанкны батлагдсан төсөв, гүйцэтгэл, төсвийн удирдлагатай танилцсан тухай	2019.03.20 №2	27.	Монголбанк төсөвт зардал, түүний хуваарилтыг өөрийн үндсэн зорилт, чиг үүрэгтэй холбон авч үзэж дүгнэж байх, суурь, урсгал зардлыг нормчлох, зардлын өсөлтийг хязгаарлах боломжийг судлах,	УТГ	Монголбанкны захиргааны төсөв, түүнийг боловсруулахдаа суурь болон урсгал зардлыг сүүлийн 5 жилийн гүйцэтгэлд суурилан тооцоолон гаргаж байна. Монголбанк нь үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны хөтөлбөрийн хүрээнд бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэх, хүний нөөцийн чадавхи болон хууль, эрх зүйн орчинг сайжруулах, хамтын ажиллагааг бэхжүүлэх, дэвшилтэд технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх чиглэлийн хүрээнд газар, нэгж, алба, төвүүд өөрсдийн хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, “Монголбанкны төсөв зохиох, хянах, батлах журам”-ын дагуу дараа оны төсвийн төслийг ирүүлдэг. Төсвийн төслүүдийг нэгтгэн боловсруулж ТТХЗ болон Захирлуудын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн батлуулдаг. Монголбанкны системийн захиргааны зардлын төсвийн гүйцэтгэлийг зардлын зүйл анги тус бүрээр болон газар, нэгж, алба, төвүүдээр хагас, бүтэн жилээр нэгтгэн гаргаж ТТХЗ болон Захирлуудын зөвлөлийн хуралд танилцуулдаг. Энэ нь Монголбанк төсөвт зардал, түүний хуваарилтыг өөрийн үндсэн зорилт, чиг үүрэгтэй холбон авч үзэж чаддаг гэж дүгнэж байна. Монголбанкны захиргааны зардлын 50 хүртэл хувь нь цалин, урамшуулал, 18 хувь нь элэгдлийн зардал, 7 хувь нь нийгмийн хөгжлийн сангийн зардал, бусад 25 хувь нь 23 нэр төрлийн зардлаас бүрддэг. Ажлын онцгой нөхцлийг харгалзан тоологч, бичиг хэргийн ажилтнууд болон үйлчлэгч нарт Монголбанкны хэрэглээний зохистой байдлын журмын дагуу нормын сүү, хөдөлмөр хамгааллын ажлын хувцсыг тус тус олгодог. Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах, түүнчлэн зардлын өсөлтийг хязгаарлах боломжийг судлах ажлын хүрээнд үр ашиг бага зардлыг аль болох хэмнэх зарчмаар ажиллаж байгаа бөгөөд урт хугацаандаа зардлыг бууруулах зорилттой ажиллаж байна. Үүнд: Монголбанкны ажилтнаас гардаг гол бүтээгдэхүүн бол цаас тул Үндэсний цахим гүйлгээний төвийн шинэ оффист хэвлэх, хувилах машины нэгдсэн системийг нэвтрүүлж, тоног төхөөрөмж, цаас болон	Биелэлт-100% Монголбанкны захиргааны төсөв, түүнийг боловсруулахдаа суурь болон урсгал зардлыг сүүлийн 5 жилийн гүйцэтгэлд суурилан тооцоолон гаргажээ. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А-109 дүгээр “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”, 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн А-168 дугаар “Хэмнэлтийн тухай” тушаалаар төрийн хэмнэлтийн арга хэмжээний хүрээнд зардлыг хязгаарлах, хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаар үүрэг өгч арга хэмжээ авч хэрэгжүүлсэн.
--	---------------	-----	--	-----	--	--

					хорны зардлыг урт хугацаандаа бууруулахаар ажиллаж байна.		
			28.	Монголбанк цаашид төсөв, өөрийн үйл ажиллагааны чиглэлийг дунд хугацаагаар тооцоолж төлөвлөхийг зөвлөж байна.	УТГ	Монголбанкны системийн захиргааны зардлын төсвийн төслийг бодитой төсөвлөх, үр ашигтай, хэмнэлттэй байх зарчмыг сайжруулах ажлын хүрээнд “Монголбанкны төсөв зохиох, хянах, батлах журам”-ыг шинэчлэн боловсруулж, мөн 2021 оноос эхлэн төсвийн төслийг дунд хугацаагаар тооцоолж, төсөвлөн ажиллаж байна.	Биелэлт-100% Зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган төсвийн төслийг дунд хугацаагаар тооцоолж төсөвлөн ажиллажээ.
			29.	Монголбанк захиалгаар гадаадаас авдаг мэдээ, судалгааны материалыг орчуулж, олон нийтийн хүртээл болгоход анхаарч ажиллах.	ТГ	Цахим хэвлэл захиалан үйл ажиллагаандаа ашиглаж байгаа газар, нэгжүүдэд цаашид олон нийтийн хүртээл болгох талаар анхаарч ажиллах зөвлөмжийг ТГ-аас хүргүүлж ажиллав. Монголбанк нь цахим хэвлэл захиалан МБГ, ЭУА, ССГ-ууд өдөр тутмын үйл ажиллагаандаа тогтмол ашиглаж, шаардлагатай тохиолдолд бусад газар, нэгжүүд ашиглах (нэвтрэх нэр, нууц гс) боломжтой байдаг.	Биелэлт-100% Зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллажээ.
	Монголбанкны Эдийн засгийн судалгаа сургалтын хүрээлэнтэй танилцсан тухай	2019.05.10 №3	30.	Монголбанкны үйл ажиллагааны ашиг алдагдлын тэнцвэрийг хангах, банкны үр ашгийн төлөөх сэтгэлгээг ажилтнуудын дунд улам бэхжүүлэх тухай;	ЭЗССХ	Монголбанкны үйл ажиллагааны ашиг алдагдлын тэнцвэрийг хангах, банкны үр ашгийн төлөөх сэтгэлгээг ажилтнуудын дунд улам бэхжүүлэх зөвлөмжийн хүрээнд Хяналтын зөвлөлтэй хамтран Монголбанкны газар, хэлтсүүдийн удирдлагуудын хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулсан ба бусад орны туршлагыг хуваалцах ажлыг зохион байгуулж ХБНГУ-ын Төв банк, Европын Холбооны Төв банктэй холбогдох уулзалтуудыг зохион байгуулсан. “Цахим үндэстэн” хөтөлбөрийн хүрээнд бичиг хэргийн зардлаа танаж, бичгийн цаасны захиалгыг 2 жил хийгээгүй болно. Мөн цахилгааны хэмнэлт хийж хэвлэгч, хувилагч зэрэг standby горимд байхдаа ч цахилгаан зарцуулдаг цахилгаан хэрэгслүүдийг бүрэн унтрааж хэвшсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	Биелэлт-100% Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 4 дүгээр сарын 12-ны өдрийн А-109 дүгээр “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай”, 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн А-168 дугаар “Хэмнэлтийн тухай” тушаалаар төрийн хэмнэлтийн арга хэмжээний хүрээнд зардлыг хязгаарлах, хөрөнгийг үр ашигтай зарцуулах талаар үүрэг өгсөн.

			31.	Зээл, зээлийн хүүгийн нэгдсэн бодлого, зохицуулалтыг банк, банк бус санхүүгийн байгууллагын зээллэг, барьцаалан зээлдүүлэх үйлчилгээнд нэг мөр хамууруулах боломжийн тухай;	ЭЗССХ	“Зээлийн хүүг бууруулах эрх зүйн орчин, олон улсын туршлага” сэдэвт олон нийтийн нээлттэй хэлэлцүүлгийг 2018 оны 9 сарын 24-нд зохион байгуулсан. Мөн “Зээлийн хүүг бууруулах эрх зүйн орчинг бий болгох олон улсын туршлага” судалгааны ажлыг 2020 онд хийж гүйцэтгэсэн.	Биелэлт-100% Зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажиллажээ.
			32.	Монголбанкны судалгааны мөрөөр ажиллах, практик ач холбогдлыг дээшлүүлэхэд нэгдсэн дүгнэлт, санал гаргах тухай.	ЭЗССХ	Монголбанкны судалгааны мөрөөр ажиллах, практик ач холбогдлыг дээшлүүлэхэд Монголбанкны бодлогын гол баримт бичиг болох ТМБТБҮЧ-ийн хүрээнд судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэж байна. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн төслийн 2.1.2; 2.1.3; 2.2.1 заалтуудын хүрээнд дараах судалгааны ажлуудыг хийж гүйцэтгэж байна: • УУБ экспортын санхүүжилтийн тогтолцооны олон улсын туршлага, арга хэрэгслүүд • Аж үйлдвэржилт, ногоон эдийн засаг, санхүүжилтийн талаарх олон улсын туршлага, МУ-ын нөхцөлд хэрэгжүүлэх үзэл баримтлал • Санхүүгийн хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах хуулинд зээлдэгч зээлдүүлэгчийн эрх ашгийг тэгш оруулах санал боловсруулах, иргэний хуулинд тусгах чиглэлээр тодорхой саналууд	Биелэлт-100% Монголбанк судалгааны үр дүнг удирддагуудад тухай бүр танилцуулж, бодлогын шийдвэр гаргалтанд ашиглан ажиллаж байна.
			33.	Санхүүгийн тайлангийн үр ашгийн үзүүлэлтүүд, шинэ стандартын дагуу хийгдэх хөрөнгийн үнэлгээ, эрсдэлийн тооцоололд Монголбанкны удирдлага, нийт газар хэлтэс, дотоод аудитын газар онцгой анхаарал тавьж, тэдгээрийг үйл ажиллагааныхаа чиглэл, бодлогод илүүтэй ашиглаж хэвшүүлэх, нягтлан бодох	ДАГ СБГ ЭУА	Монголбанкны санхүүгийн хөрөнгийн үнэлгээ, эрсдэлийн тооцооллыг СТОУС-9-ийн дагуу хийж, түүний дагуу холбогдох бүртгэлийг хөтөлж байна. Монголбанкны суурь бүртгэлийн системийг шинэчлэх ажил нь цар тахлын халдвар тархсантай холбоотойгоор төслийн явц удааширч, хугацаа нь хойшилсон бөгөөд шинэ системийг энэ онд багтаан нэвтрүүлэхээр нийлүүлэгч компанийн ажилтнуудтай хамтран ажиллаж байна. 1. IFRS-9-ийн дагуу санхүүгийн хөрөнгийн хүлээж болзошгүй алдагдал (ECL)-ын тооцооллыг улирал	Биелэлт-95% Монголбанкны суурь бүртгэлийн системийг шинэчлэх ажил нь цар тахлын халдвар тархсантай холбоотойгоор төслийн явц удааширч, хугацаа нь хойшилсон бөгөөд шинэ системийг энэ онд

				бүртгэлийн мэдээ, тайланг бүрэн цахимжуулах ажлыг түргэтгэж ажиллах;	тутам хийж, холбогдох тайланг боловсруулан удирдлагуудад танилцуулж, СБГ-т хүргүүлж байна. Санхүүгийн хөрөнгийн хүлээж болзошгүй алдагдалыг бууруулах, Алт-2 санхүүжилт, Дотоод актив чанаргүйдэх эрсдэлийг бууруулах (ДАЧЭБ) арга хэмжээний хүрээнд тулгамдаж буй асуудлын талаар удирдлагуудад танилцуулж ХЭЗГ, НУСЗЗГ, СТБ ХШГ газруудад албан бичиг, танилцуулга, зөвлөмж хүргүүлж хамтарч ажилласан. “Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн үнэлгээний заавар”-ыг 2019 оны А340 дугаар тушаалаар шинэчилсэн. 2. IFRS-13-ын дагуу банкуудтай байгуулсан урт хугацаат своп хэлцлийн дахин үнэлгээг 7 хоног тутам гүйцэтгэж СБГ-т хүргүүлж байна. “Санхүүгийн үүсмэл хэрэгслийн бодит үнэ цэнийг тооцох заавар”-ыг 2021 оны А229 дугаар тушаалаар шинэчилсэн. 3. Төв банкны барьцаа хөрөнгийн бодлогын хүрээнд: Төв банкнаас банканд зээл, санхүүжилт олгоход барьцаалах хөрөнгө, худалдан авах үнэт цаасны жагсаалтыг 2021 оны 10 дугаар сард шинэчлэн батлуулсан. Үүнд: i. Ковид-19 цар тахлын үед эдийн засгийн сэргэлтийг дэмжих, банкны салбарын хөрвөх чадварыг хадгалах зорилгоор ипотекийн зээлээр баталгаажсан бонд (ИЗББ)-ын эрсдэлийн хямдруулалтыг бууруулсан. ii. Давуу эрхтэй хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаас (ХЗБҮЦ)-ыг барьцаа хөрөнгийн жагсаалтанд нэмсэн. Жижиг, дунд үйлдвэрлэл, уул уурхайн бус экспортын салбарт олгосон төгрөгийн ХЗБҮЦ-аар 2 жилийн хугацаатай репо арилжаа хийх шийдвэр гаргасантай холбоотойгоор 2020 онд урт хугацаатай репо санхүүжилтийн хэрэгслийг нэвтрүүлсэн. Энэ нь мөнгөний бодлогоор бодит эдийн засгийг дэмжих, зээлийн хүүг бууруулах стратегийг хэрэгжүүлэх, экспортын санхүүжилтийг	багтаан нэвтрүүлэхээр нийлүүлэгч компанийн ажилтнуудтай хамтран ажиллаж байна.
--	--	--	--	---	---	---

					нэмэгдүүлэхэд бодлогын хэрэгслийг ашиглах ач холбогдолтой. 4. Төв банкны санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдийг шинжилж, үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлох, эрсдэлийг удирдах арга хэмжээний санал боловсруулах зорилгоор улирал тутам төв банкны санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүдэд эрсдэлийн шинжилгээ хийж танилцуулгыг бэлтгэн удирдлагыг мэдээллээр ханган ажиллаж байна. 5. Тайлан мэдээний цахимжуулалт: i. Монголбанкны МТГ-аас хөгжүүлсэн Үнэт цаасны системд төв банкнаас зээл, санхүүжилт олгоход барьцаалах ипотекийн зээлээр баталгаажсан бонд болон хэвийн зээлээр баталгаажсан үнэт цаасны үнэлгээг цахимжуулсан. ii. Азийн хөгжлийн банкны Төлбөрийн системийн шинэчлэлийн төслийн хүрээнд Монголбанк, Сангийн яам, арилжааны банк болон бусад холбогдох байгууллагын дунд нэвтрүүлж буй Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон төв банкны арилжааны нэгдсэн системд төв банкнаас зээл, санхүүжилт олгоход барьцаалах үнэт цаасны барьцаа хөрөнгийн үнэлгээг цахимжуулах ажлыг хийж байна. iii. Монголбанкны бүртгэлийн “Core” систем шинэчлэгдсэнээр ЭУА нь ГВУН-ийн бүтэц, лимитэд тогтмол хяналт тавих боломж бүрдэх бөгөөд шинэчилсэн системийн хувьд гүйлгээнээс өмнөх болон дараах хяналтыг тавих боломж нэмэгдэнэ. Банкуудтай байгуулсан урт хугацаат своп хэлцлийн дахин үнэлгээг бүртгэлийн “Core” системд оруулах боломжийн талаар төслийн ажилтнуудтай хамтран ажиллаж байна. Мөн Монголбанкны МТГ-т бодлогын даалгавар хүргүүлсэн. Тус алба нь эрсдэлийн удирдлагын хүрээнд шаардлагатай функц, модулийг програмд тусгуулах, тоон мэдээллээр
--	--	--	--	--	--

				хангах зэргээр төслийн нэгжтэй тогтмол хамтран ажиллаж байна. 6. Судалгааны ажил: i. “Төв банкны барьцаа хөрөнгийн бодлого” судалгааг 2021 оны 2 дугаар улиралд хийж удирдлагуудад танилцуулсан. ii. “Ердийн болон хямралын үеийн барьцаа хөрөнгийн бодлого”-ын судалгааг 2022 оны 2 дугаар улиралд гүйцэтгэж удирдлагуудад танилцуулсан. iii. “Санхүүгийн хөрөнгийн хүлээж болзошгүй алдагдлын тооцооллыг сайжруулах нь” судалгааны ажил гүйцэтгэж байна.	
34.	Монгол Улсын хэмжээн дэх санхүүгийн нөөцийн удирдлага, банк, банк бус салбар дахь бүх шатны хүүгийн түвшингийн талаар холбогдох байгууллагуудын дунд нэгдсэн бодлого, стратеги бий болгох арга механизмыг тогтоох;	НУСЗЗГ МБГ	Монголбанкны мөнгөний бодлогын үйл ажиллагааны зорилт нь банк хоорондын захын жигнэсэн дундаж хүү байдаг. Монголбанкаас нээлттэй захын үйл ажиллагаа, хүүний нэгдсэн бодлого болон бусад мөнгөний бодлогын арга хэрэгслүүдийн тусламжтай банк хоорондын захын жигнэсэн дундаж хүүг бодлогын хүүтэй ойролцоо хадгалахыг зорьдог. Улмаар банк хоорондын зах дахь хүүний өөрчлөлт нь хадгаламж болон зээлийн хүү болон бусад хөрөнгийн үнэд нөлөөлснөөр инфляц болон түүний хүлээлтэд тодорхой хугацааны дараа нөлөөлдөг. Мөн нээлттэй захын үйл ажиллагаа гол хэрэгсэл болох Төв банкны үнэт цаас (ТБҮЦ)-ны арилжаа нь банк хоорондын захын богино хугацаатай хүү болон нөөцийн хэлбэлзлийг удирдах замаар Монголбанкны мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн арга хэрэгсэл болдог. Түүнчлэн бодлогын хүүтэй уялдсан хүүгийн коридор системээр Монголбанкны мөнгөний бодлогын бусад хэрэгслийн хүү тодорхойлогддог. Төв банкны нээлттэй захын үйл ажиллагаа нь мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл юм. Ингэхдээ банк хоорондын захын богино хугацаат хүү болон нөөцийн хэлбэлзлийг удирдах зорилгоор хугацаа, хүү, арилжаалагдах хэлбэрээр харилцан адилгүй ТБҮЦ-ыг Монголбанк банкуудад	Биелэлт-100% Санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган ажиллаж байна.	

			арилжаалдаг. Энэ нь арилжааны банкны нөөц, илүүдэл нөөцийг удирдах мөнгөний бодлогын гол хэрэгсэл юм.	
35.	Хуримтлагдсан ашиг, алдагдал, актив, пассив хөрөнгийн зөрүүг санхүүжүүлэх арга механизмыг олох, санхүүгийн цэвэр орлогын хэмжээ, Монгол Улсын 1925 оны мөнгөн зоосны шинэчилсэн үнэлгээ зэргийг тогтооход ашиглах хууль, эрх зүйн болон эдийн засгийн шалгуурыг нарийвчлан авч үзэн, нэгдсэн ойлголтод хүрч холбогдох бичилт, залруулга хийж байх;	НУСЗЗГ СБГ ХЭЗГ	Франц улсад үйл ажиллагаа явуулдаг хөрөнгийн үнэлгээний “Cabinet Portier” компанийн Азийн урлагийн мэргэшсэн шинжээч Алисс Джоссим нь 2018 оны 06 дугаар сарын 20-23-ний өдрүүдэд олон улсын стандарт, арга аргачилалын дагуу үнэлэх ажлыг гүйцэтгэсэн бөгөөд Сангийн сайдын 2013 оны 6 дугаар сарын 17-ны өдрийн 140 дугаар тушаалаар батлагдсан “Түүх соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнэ тогтоох журам”, “Түүх соёлын дурсгал, үзмэр, эд өлгийн зүйлийн шинэчилсэн дансны үнийн жагсаалт”-аар Монгол Улсын 1925 оны мөнгөн зоосны шинэчилсэн үнэлгээ зэргийг тогтоож байгаа. “Төв банк /Монголбанк/-ны тухай” хуулийн дагуу Монголбанкны аудитлагдсан санхүүгийн тайланг жил бүр УИХ-д хүргүүлж, мэдээллээр хангаж ажилласан болно. 2022 оны Эрдэнэсийн сангийн тухай хуулиар Эрдэнэсийн сангийн эрх зүйн орчин боловсронгуй болж, Монгол Улсын түүх, соёлын өвийн эрх зүйн хамгаалалт сайжирч, үнэ цэнэ нэмэгдэх, Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын жилийн төсөв, гүйцэтгэлийн тайлан, тооллогын дүн олон нийтэд ил болж, Эрдэнэсийн сангийн хөрөнгийн нягтлан бодох бүртгэлийг илүү ойлгомжтой тодорхой болгосон.	Бнэлэлт-100% Саналыг үйл ажиллагаандаа тусган авч хэрэгжүүлж ажиллажээ.
36.	Таваарын бүтээгдэхүүний үнийн мөчлөг, ирээдүйн гадаад өр төлбөрийн хуваарь зэргийг бодолцон гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэх, зэс, нүүрс, алт зэрэг голлох экспортын бүтээгдэхүүний орлогын дийлэнхийг дунд хугацаанд Монголдоо үлдээх стратеги төлөвлөгөөг холбогдох байгууллагуудтай хамтран	НУСЗЗГ МБГ	ГВУНУХ нь улирал тутам Экспортын голлох түүхий эдийн зах зээлийн төлөв байдлын шинжилгээг боловсруулж, удирдлагад танилцуулж байна. Тус тайланд ашигласан экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн таамаглал болон гадаад өр төлбөрийн хуваарийг өдөр тутмын үйл ажиллагаандаа мөрдөхийн зэрэгцээ ГВУН-ийн богино таамаглалыг бэлтгэхэд ашиглаж байна. Үүний зэрэгцээ өндөр хэмжээний экспортын орлого бүхий ААНБ-уудтай санал солилцон холбогдох хууль эрх зүйн зохицуулалтын хүрээнд валютын дотогшлох урсгалыг богино хугацаанд нэмэгдүүлэх	Бнэлэлт-100% Санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж ажиллажээ.

				боловсруулж, хэрэгжүүлж ажиллах		арга хэмжээний хүрээнд 2019 онд 2,214.6, 2020 онд 1,776.5, 2021 онд 2,414.5, 2022 онд 2,454.6 сая ам.доллартай тэнцэх хэмжээний валютыг экспортын орлого бүхий ААНБ-уудаас худалдан авчээ.	
			37.	Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэхэд өөрийн орны санхүүгийн хязгаарлагдмал нөөцийг зөв ашиглах харилцан уялдаа бүхий макро-мөнгөний болон макро-сангийн бодлогыг хэрэгжүүлэх арга механизм, олон улсын тэргүүний туршлагыг хамтран судалж, хэрэгжүүлэх.	МБГ	2020 оноос эдийн засгийн төрөлжилт, уул уурхайн бус экспортыг дэмжих зорилгоор тус салбарт урт хугацаат санхүүжилтийг Монголбанкнаас олгож эхлэв. Мөн уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх бодлого, санхүүгийн дэд бүтцийг тодорхойлох тухай заалтыг 2022 оны “Төрөөс Мөнгөний бодлогын талаарх баримтлах үндсэн чиглэл”-д тусган ажиглаж байна. Үүний хүрээнд ССГ-аас уул уурхайн бус экспортод учирч буй хүндрэлийн талаар судалгааны ажил боловсруулж хэвлүүлэв. Түүнчлэн, Засгийн газар, Монголбанк, МҮХАҮТ хамтран Ерөнхий сайдын ивээл дор “Экспортлогч үндэстэн-Уул уурхайн бус экспорт, түүний санхүүжилт” сэдэвт үндэсний чуулганыг 2022 оны 10 сарын 28-ны өдөр зохион байгуулсан. Уул уурхайн бус экспортыг нэмэгдүүлэх чиглэлд бодлогын үйл ажиллагааг цаашид үргэлжлүүлэх бөгөөд 2023 оны “Төрөөс Мөнгөний бодлогын талаарх баримтлах үндсэн чиглэл”-д уул уурхайн бус экспортын бүтээгдэхүүний боловсруулалтыг шат ахиулж, экспортыг дэмжихэд чиглэсэн гадаад худалдааны санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, хүртээмжийг нэмэгдүүлэх заалтыг оруулан ажиллаж байна.	Биелэлт-100% Санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллажээ.
Хяналтын зөвлөлөөс 2019 онд Монголбанкны удирдлагад хүргүүлсэн санал зөвлөмжийн хэрэгжилтийн талаар мэдээлэл сонсох	Хяналтын зөвлөлийн хурлын мэдээ 2020.02.28	38.	Мэдээллийн технологийн газрын ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар баримтлах бодлого, цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар авах арга хэмжээ	ТГ МэТГ	Монголбанкны хүний нөөцийн бодлого болон хөдөлмөрийн дотоод журмын зохицуулалтын хүрээнд ажилтнуудаа тогтвор суурьшилтай ажиллуулахад удирдлагын зүгээс тогтмол анхаарч ажиллаж ирсэн. Мэдээллийн технологийн чиглэлийн боловсон хүчний цалин өндөр байдгийг харгалзан үзэж зарим тохиолдолд шаардлагатай шагнал урамшууллын бодлогыг авч хэрэгжүүлсэн. МТГ-с Тамгын газарт жил бүр ажилтнуудын цалингийн шатлалыг нэмэгдүүлэх тухай бичиг илгээдэг бөгөөд хамгийн сүүлд Монголбанкны ерөнхийлөгчийн 2022 оны 6-р сарын 16-ны Б-248	Биелэлт-100% Мэдээллийн технологийн газрын ажилтнуудыг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар холбогдох арга хэмжээг авч ажиллажээ.	

						тоот тушаалаар зарим ажилтны цалингийн шатлал нэмэгдсэн.	
МБЕ	Албан бичиг 2020.04.28 №8	39.	Монголбанкны Хяналтын зөвлөлөөс 2019 оны 4 дүгээр сард Монголбанкны Тэргүүн дэд Ерөнхийлөгч О.Эрдэмбилэгт 10 тоот бичгийг хүргүүлсэн билээ. Тус бичгээр Хяналтын зөвлөлийн гишүүд татан буугдсан банкуудын Эрх хүлээн авагчдын үйл ажиллагааг хангалтгүй байна гэж дүгнэсэн болохоо мэдэгдсэн юм. Үүний зэрэгцээ татан буугдсан, дампуурсан банкуудын үйл ажиллагаатай холбогдож Монголбанкны дээр үүссэн өр авлагыг барагдуулах ажлыг эрчимжүүлж, үр дүнг нь мэдээлэхийг хүссэн билээ. Мөн эрх хүлээн авагчдын үүрэг, хариуцлага, хамгаалалтын арга механизмыг чангатгах шаардлагатай гэж үзэн цаашид арилжааны банкныг татан буулгах үндэслэл, шалгуурыг хуулиар нарийвчлан тогтоох, дампуурсан банкуудын өмнөх удирдлага, эздийн хүлээх үүрэг, харнуцлага, тэднээс мэдээлэл, дэмжлэг, тусалцааг хэрхэн авах асуудлыг судалж үзэх, банкны эрх хүлээн авагч томилог ажиллуулдаг механизмыг боловсронгуй болгохын чухлыг тус бичигт тэмдэглэсэн. Мөн олон жил	ХЭЗГ ББӨБГ	Банкны эрх хүлээн авагчаас санхүү, үйл ажиллагааны тайлан мэдээ авах, түүнийг боловсруулах системийг Монголбанкны цахим тайлангийн систем/Fipa/-д холбож автоматжуулсан. Татан буугдсан банктай холбоотой мэдээллийн сан бүрдүүлж ажиллаж байна. Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан хуулиар банкныг албадан татан буулгах, Банкны эрх хүлээн авагчийн (Цаашид БЭХА гэх) үйл ажиллагаатай холбоотой зохицуулалтад нэмэлт, өөрчлөлт орсон. Тухайлбал БТХ-ийн 68 дугаар зүйлийн 68.2 болон 69 дүгээр зүйлийн 69.1.4, 69.1.13 дахь заалтад тус тус нэмэлт, өөрчлөлт орсон бөгөөд уг нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх, БЭХА-ын үйл ажиллагаанд бэрхшээлтэй байгаа зүйлийг тодорхой зохицуулах, олон улсын туршлагыг нэвтрүүлэх зорилгоор “Банкныг албадан татан буулгах арга хэмжээг хэрэгжүүлэх журам”-ыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу шинэчлэн боловсруулж байна. Энэхүү шинэчилсэн журмын төсөлд БЭХА-ийг томилох, тус арга хэмжээг хэрхэн дуусгавар болгох үйл явцыг нарийвчлан зохицуулж, БЭХА-ийн үйл ажиллагаанд тавих хяналт, харнуцлагыг нэмж тусгасан.	Биеэлт-100% Тус албан бичгийн хариут 2020 оны 8 дугаар сарын 21-ний өдрийн А-1/1003 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.	

			бүх түвшинд яригдаж гарсан чиглэлээс үзэхэд Зоос банкны жижиг хувьцаа эзэмшигчдийн хохирлыг Монголбанк, түүний эрх хүлээн авагчид шийдэх шаардлагатай болжээ гэдгийг сануулсан билээ. Өнөөгийн цар тахалын үед уг асуудлыг шийдэх нь чухал биз ээ. Ийнхүү манай бичигт дурдсан өр авлагыг барагдуулах, арилжааны банкуудтай ажиллах арга механизмыг боловсронгуй болгох, иргэдийн хохирлыг шийдэх асуудалд Таны зүгээс анхаарал хандуулж, зохих шийдэл, хариу өгөхийг хүсэж байна Дашрамд таны мэдэх нэгэн зүйлийг бас сануулж байна. Монголбанк, Дэлхийн банкаас 2019 оны 10 дугаар сарын 22-ны өдөр Монголд зохион байгуулсан семинар дээр Дэлхийн банкны Олон улсын Санхүүгийн корпорацийн Зүүн Ази, Номхон далайн төлөөлөгч Жинчан Лай Монгол Улс нь санхүүгийн байгууллагуудын төлбөрийн чадваргүйдлийг шийддэг үзүүлэлтээр бага оноо авдаг, тухайлбал өр зээлийн эргэн төлөлт нь бусад орнуудтай харьцуулахад хамгийн бага гарсан тухай судалгааг танилцуулж байсан билээ. Тэрээр мөн Монгол улс хүндэрсэн банкны өр авлага барагдуулахдаа		
--	--	--	--	--	--

				зээлдүүлэгчийг оролцуулах үзүүлэлтээр 4 оноо авахаас тэг оноо, банкыг хөрөнгөжүүлж, дахин зохион байгуулалтад оруулах шалгуураар 3 оноо авахаас 0.5 оноо авсан болохыг сануулж байсан. Энэ бол бодлогын, үндэсний эрх ашгийн том асуудал болохыг Та бүхэн сайтар мэдэх бөгөөд бодлого, шийдвэр гаргагчдад бүрэн ойлгуулж дэмжлэг авч ажиллах талаар хичээн ажиллаж буй гэдэгт итгэлтэй байна. Ер нь Монгол дахь банкны төлбөрийн чадваргүйдлийн талаарх өмнөх шийдвэрүүдийн хэрэгжилтийн үр дүнг олон улсын шилдэг туршлага, Монгол улсын онцлогтой холбон судалж, оновчтой хувилбарыг олох, улсыг хохиролд оруулахаас сэргийлэх нь чухал гэж үзэж байна. Хуулбарыг УИХ-ын Эдийн засгийн Байнгын Хороонд		
	Албан бичиг 2020.07.28 №14	40.	Роберт Корнелисс: Тайландаа хамгийн түрүүнд тусгах зүйл бол нэгд Хяналтын зөвлөл нь Дотоод аудитын газрын захирлыг нь томилж бас халах эрхтэй. Ерөнхийлөгч бол санал оруулах эрхтэй. Ингэж хувиарладаг. ДАГ-ын бие даасан чадварыг сайжруулахад түлхэц болно.	ДАГ ЭУА	<u>Үйл ажиллагааны эрсдэлийн хувьд</u> Эрсдэлийн соёлыг бий болгох, хамгаалалтын 3 шугамаа сайжруулахтай холбоотой дараах ажлууд хийгдсэн. Үүнд: i. ЭУА-наас үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагатай холбоотой сэдвүүдээр шинэ ажилтнууд, нэгжүүдийн үйл ажиллагааны эрсдэл хариуцсан ажилтнуудад тогтмол сургалт хийж байна. ii. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагатай холбоотой мэдээ, мэдээллээр 14 хоног тутмын тойм бэлтгэн удирдлагуудад хүргүүлж байна.	Биеэлэлт-70% Санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

			Хяналтын зөвлөлд Дотоод аудитын газрын жилийн төлөвлөгөө батлах эрх байхгүй байна. Мөн Дотоод аудитын газар нь тайлангаа Ерөнхийлөгчид шууд тайлагнаж байгаад, үүнийг бас Хяналтын зөвлөлд давхар тайлагнадаг байх ёстой. Төв банкны хууль, Хяналтын зөвлөлийн журам дээрээ саяын ярьсанг тусгаад эрх хэмжээгээ сайжруулах шаардлагатай. Өөр нэг зүйл бол Хяналтын зөвлөл, Монголбанкны удирдлага, Захирлуудын зөвлөл Монголбанкны үйл ажиллагааны зарим эрсдэлийг (risk appetite) хүлээж авах тодорхой нэгдсэн ойлголттой байх ёстой. Risk appetite гэдгийг нарийвчлаад хэлэхэд эрсдэлээс хамгаалахын тулд ямар хэмжээний эрсдэлийг хүлээн зөвшөөрөх гэсэн санаа. Тухайлбал байгууллагын хүлээн зөвшөөрсөн эрсдэл, бид ийм хэмжээний эрсдэлийг хүлээгээд авч чадна гэдгийг ДАГ, ЭУА болон бусад нэгжүүд нь ч зөвшөөрч мэдвэл, шинэ зүйл санаачлах ч юм уу эрсдэлээ хянах тал руугаа сайн ажиллах боломжтой.	iii. Монголбанкны хэмжээнд үйл ажиллагааны эрсдэлийн нэгдсэн ойлголттой болох үүднээс ҮАЭУ-ын нэр томъёоны толь бичгийг боловсруулан ном болгон хэвлүүлж нийт ажиллагсдад тараасан. iv. Хамгаалалтын 3-р шугам болох ДАГ-т ЭУА-наас бусад газар нэгжүүдэд өгсөн зөвлөмжийг хагас жил тутам, эрсдэлийн үнэлгээний үр дүнг тухай бүр хүргүүлж байна. Мөн 2020 оны 12 дугаар сард шинээр боловсруулан батлуулсан “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг” болон шинэчлэн батлуулсан “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”-д Монголбанкны эрсдэлийн талаарх байр суурь, мөрдөх зарчим, эрсдэлийн хүлээн зөвшөөрөх түвшин болон эрсдэлийн талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг илүү тодорхой болгохыг зорьсон. Тодруулбал, эрсдэлийн түвшинээс шалтгаалан эрсдэлийг удирдах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг илүү тодорхой болгосноос гадна Монголбанк нь ҮАЭ-ийг хүлээн зөвшөөрөгдөхүйц хэмжээн дотор удирдах зарчмыг тусгасан. <u>Санхүүгийн эрсдэлийн хувьд</u> ГВУН-ийн удирдлагын хүрээнд санхүүгийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшин буюу “Risk appetite”-ийг Хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд тодорхойлох шаардлагатай бөгөөд Төв банкны хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичгийг 2023 онд боловсруулахаар төлөвлөн ажиллаж байна. Хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг батлагдснаар хөрөнгө оруулалтын зорилго, стратеги, эрсдэл даах болон хүлээн зөвшөөрөх түвшин зэргийг тодорхойлох (risk appetite, risk tolerance) бөгөөд ингэснээр удирдлага, институцийн хувьд эрсдэлийн удирдлагын нэгдсэн ойлголтыг бэхжүүлэх боломж бүрдэнэ.	
--	--	--	---	---	--

			<i>Зөвшөөрөгдөх</i> эрсдэлийн хувьд 3 хэсэг арга замууд байдаг. 1. Санхүүгийн хувьд хүлээн зөвшөөрсөн эрсдэл 2. Нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрсөн эрсдэл 3. Үйл ажиллагааны хувьд хүлээн зөвшөөрсөн эрсдэл. Эд нар хүлээж авах эрсдэл тодорхой болчих юм бол дотоод хяналтаа хэрхэн явуулах, аудитаа ямар хэмжээгээр хэрэгжүүлэх нь тодорхой болно. Саяын бүх зүйлсийг хэрэгжүүлэхэд хугацаа шаардагдана. Гэхдээ хэрэгжүүлээд эхэлж болох зүйл бол хамгаалалтын 3 шугамаа сайжруулах, risk appetite, хүлээж болох эрсдэлийг тодорхойлох зэргийг банк дотроо хэрэгжүүлж болох байх. Харин хуульд өөрчлөлт оруулах, Хяналтын зөвлөлийн журамд өөрчлөлт оруулах зэрэг асуудал бол хугацаа шаардсан асуудал юм.			
		41.	МБХЗ-ийн хуулиар хүлээсэн бүрэн эрхэд Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих учиртай. Энэхүү "зөвлөл" гэдгийг Монголбанкны Захирлуудын зөвлөл гэдэг утгаар ойлгож байгаа ба	ХЭЗГ	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-103 дугаар тушаалаар баталсан Монголбанкны Захирлуудын зөвлөлийн ажиллах журмын дагуу Захирлуудын зөвлөл үйл ажиллагаа явуулж, Мөнгөний бодлогын хороо, Банкны хяналт шалгалтын хорооны хэлэлцэх асуудлаас бусад асуудлаар зөвлөх чиг үүргийг хэрэгжүүлж байна.	Биелэлт-100% Монголбанкны зүгээс Удирдах зөвлөлийг хуульчлахаар хуулийн төсөлд тусгасан боловч тус зохицуулалт батлагдаагүй байна.

				Хууль дахь “Зөвлөл” гэдэг нь зөвхөн зөвлөмж гаргадаг Банкны Ерөнхийлөгчийн шууд удирдлага, хараанд байдаг Захирлуудын зөвлөл гэдэг утгаар одоо ажиллаж байгаа. Санал: Монголбанкыг бие даасан, улс төрөөс ангид, мэргэжлийн байгууллагын хүрээнд ажиллуулах гүйцэтгэх/удирдах/ зөвлөл, ялангуяа дээд удирдлагаас улс төрийн шинжтэй шийдвэрийг зогсоох эрх зүйн чадамж бүхий мэргэжлийн Гүйцэтгэх/Удирдах/ Зөвлөл байгуулах, ажиллах журмыг боловсруулан УИХ-аар батлуулахад онцгой анхаарах, ялангуяа хөндлөнгийн цөөн гишүүд, Монголбанкны гүйцэтгэх удирдлага оролцсон Зөвлөлтэй болж, мөнгө, зээл, банк, санхүүтэй холбоотой асуудлыг эцэслэн шийддэг, дээд удирдлагын зарим эргэлзээтэй санал зөвлөмжийг зогсоох чадвартай болох хэрэгтэй гэж үзлээ.		2018 онд УИХ-д өргөн мэдүүлсэн Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлд Удирдах зөвлөлийг хуульчлахаар тусгасан. Тус зөвлөл нь одоогийн Монголбанкны захирлуудын зөвлөлийн хэлэлцдэг асуудлыг хэлэлцэхээр хуулийн төсөлд тусгасан ч тус зохицуулалт батлагдаагүй болно.	
			42.	Монголбанкны Судалгаа, статистикийн газрын хийсэн судалгааг гадны судлаач эрдэмтэд ишлэл авч байгаад болон олон улсын нэр хүндтэй сэтгүүлүүдэд хэвлүүлж ажилласныг Хяналтын зөвлөл сайшаагаад Сангийн яаман дээр нэмэгдсэн өртгийн албан	ССГ	Монголбанкны их өгөгдлийн системийг бий болгох ажлын бэлтгэлийг 2020-2021 онуудад хийж гүйцэтгэсэн. Үүний дагуу Төрөөс мөнгөний бодлогын талаар 2022 онд баримтлах үндсэн чиглэлийн Зорилт 3.4-т “Макро эдийн засаг, санхүүгийн зах зээлийн шинжилгээнд их өгөгдлийг ашиглах техникийн болон мэргэшлийн ур чадварыг үе шаттайгаар бүрдүүлж эхэлнэ” гэж санал өгч УИХ-аар батлуулсан. Энэхүү шийдвэрийн дагуу Монголбанк 2022 ондоо багтаан их өгөгдлийн	Биелэлт-70% Монголбанк 2022 ондоо багтаан их өгөгдлийн системийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

			татварын бүх дата бааз байдаг ба 2019 онд гэхэд л 670-аад сая буюу ойролцоогоор 74 их наяд төгрөг тэмдэглэгдсэн бөгөөд жилд дунджаар давхардсан тоогоор 15-20 их наяд төгрөгөөр өсч байдаг. Гэтэл энэ хэрэглээтэй холбоотой дата бааз руу Монголбанк орох эрхгүй байгааг цаашид хуулиараа, зохицуулахыг тэмдэглэв. Дээр дурдсан дата баазыг ашиглах эрхийг албан ёсны болгоход анхаарч ажиллах, Төв банкны статистикийн тоон мэдээллийг ашиглах, их өгөгдөл хөгжүүлэх нөхцөл боломжийг нь нарийвчлан судалж, бололцоот санхүүжилтээр дэмжиж өгөх, шийдвэр гаргалтанд нөлөөлөх ач холбогдол бүхий мэдээлэл, судалгааны үр дүнг макро түвшинд хэлэлцүүлэг хийж бодлого боловсруулах асуудалд онцгой анхаарах. Монголбанк хэрэглээний шинжтэй зарим мэдээлэлд орох эрхээ нэмэгдүүлэхийг МБХЗ-ийн зарим гишүүд зөвлөсөн.		системийг нэвтрүүлэх ажлын хүрээнд дараах ажлууд үе шаттайгаар хэрэгжиж байна. • Их өгөгдлийн системийн хатуу дэд бүтцийг суурилуулсан. • Их өгөгдлийн санд тоо мэдээлэл хүлээн авах өгөгдлийн загвар (Data model)-ыг хийж гаргасан. • Банкуудаас ирүүлэх мэдээллийг PKI (Public Key Infrastructure) буюу тоон гарын үсэг ашиглан баталгаажуулалт, шифрлэлт-нууцлал хийх техник шийдлүүдийг гарган тоо мэдээллийн үнэн байх, аюулгүй дамжуулалтыг баталгаажуулах нөхцөлийг бүрдүүлсэн. • Монголбанкны газар нэгжүүдэд их өгөгдлийн системийн тоо мэдээллийг хариуцах ажилтан буюу Data steward-уудын нийт 26 ажилтанд Tableau программын сургалт зохион байгуулав. • Их өгөгдлийн системд тоо мэдээлэл хүлээн авах хөгжүүлэлтийг банкууд гүйцэтгэж байна. • Хуучин системүүдийн тоо өгөгдлүүдийг нүүлгэж, шинэ их өгөгдлийн системээр авах тоо мэдээллүүдтэй холбох ажил хийгдэж байна. Системд орсон тоо мэдээллүүдийг Tableau BI програм ашиглан автоматаар тайлагнах загваруудыг боловсруулж байна.	
	43.	Монголбанкнаас арилжааны банкуудын төлбөрийн чадавхийг сайжруулах талаар хэрэгжүүлж буй арга хэмжээ, үр дүнтэй танилцахдаа Монгол Улсын санхүүгийн тогтолцооны үндсэн цөм болсон	ХШГ ББӨБГ	Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр МУ-д үйл ажиллагааг эрхэлж буй банкуудад хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулагдах зохицуулалтыг оруулсан. Түүнчлэн, системийн нөлөө бүхий банкуудыг нээлттэй хувьцаат компани болж, олон нийтэд өөрийн хувьцааг худалдах шаардлагыг тавьсан нь тэдэнд тавих хяналтыг сайжруулж, олон талт хэлбэртэй болгох юм.	Биелэлт-100% Санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллажээ.	

			арилжааны банкуудыг Монголбанк зөв удирдах нь нийгмийн шаардлага, хүлээлт байгааг онцолсон. Тиймээс МБХЗ нь Монголбанкны үйл ажиллагаа, түүний дотор арилжааны банкуудыг удирдах чадварт хөндлөнгийн дүгнэлт өгч байх чухал гэж үзэж байгаа. Монголбанкны активын бүтцийг үзэхэд найдваргүй авлага, эрсдэл үүсгэж буй зүйлүүд голчлон төлбөрийн чадваргүй, дампуурсан банктай холбоотой харагддаг тул арилжааны банкуудын төлбөрийн чадавхийг сайжруулах асуудалд Монгол Улсын ялангуяа Монголбанкны үйл ажиллагааны дийлэнх хэсэг нь чиглэгдэх ёстой гэж үзэж буйгаа илэрхийлэв. Арилжааны банкны хувь заяа бол үндэсний эрх ашгийн асуудал тул мэргэжлийн давхар шалгалт хийдэг, үнэлгээ хийдэг, рейтинг тогтоодог болгохыг Монголбанк дэмжих нь зүйтэй биз ээ. Ийм давхар шалгалтын зарчим дэлхийн томоохон орнуудад байдаг гэдгийг тэмдэглэсэн. Мөн Монголбанк бодлого шийдвэр гаргахдаа иргэд, бизнес эрхлэгчдийн мөнгөөр зуучлал явуулдаг (банк, ББСБ, ломбард, хөрөнгийн	Нээлттэй ХК хэлбэртэй банкнуудын зүгээс жил бүр аудитлагдсан санхүүгийн тайлан болон банкны талаарх бусад дэлгэрэнгүй мэдээ, мэдээллийг олон нийтэд танилцуулах үүрэгтэй болж байгаа нь банкны хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчид болон олон нийтийн зүгээс тавих хяналтыг нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна. Давхар хяналт шалгалтын тухайд, Монголбанк банкны салбарын хувь эзэмшлийн төвлөрлийг тархаах, хөндлөнгийн хяналт, ил тод байдлыг нэмэгдүүлэх, эрсдэл даах чадварыг сайжруулж, банкны салбарын тогтвортой байдлыг хангах зорилгоор “Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-ийг 2020 оноос эхлүүлэн хэрэгжүүлж ажилласан. Энэ хүрээнд, Монголбанкны санаачилгаар хараат бус үнэлгээг Бүгд Найрамдах Казахстан улсын “PricewaterhouseCoopers Tax & Advisory LLP” компани 2022 оны 6-8 дугаар сарын хугацаанд гүйцэтгэж, үр дүнгийн тайлангаа Монголбанканд ирүүлээд байна. Өмнө нь активын чанарын үнэлгээ 2017 онд хийгдэж байсан бол 5 жилийн дараа дахин хийгдэж байна. Цаашид тус хөндлөнгийн үнэлгээг 5 жил тутамд хийж, үр дүн мэдээлэх үйл ажиллагааг жишиг болгон хэрэгжүүлэх төлөвлөгөөтэй ажиллаж байна. Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлд заасны дагуу зохицуулагч байгууллага нь аливаа нэг эрх зүйн акт боловсруулан, мөрдүүлж хэрэгжүүлэхээс өмнө цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж олон нийтээс саналыг авч хэрэгжүүлдэг болсон. Монгол Улсад эргэлдэж байгаа мөнгө, санхүүгийн хэрэгслийн 90 хувь нь банкаар дамжиж байна. Хэдийгээр санхүүгийн салбарт мөнгөний эх үүсвэр байгаа ч зээлдэгчдэд очихгүй байна. Үүний хамгийн ойлгомжтой шалтгаан нь эдийн засгийн хүндрэл юм. Иргэд, аж ахуйн нэгжүүд шинэ зээл авахаас илүүтэй авсан зээлийнхээ хүүг бууруулах, хугацааг нь сунгах сонирхолтой байна.
--	--	--	--	---

			бирж, даатгал) байгууллагуудын эздийн болоод зээлдэгч нарынхаа санаа бодлыг сонсож, тэдэнтэй хамтарч ажиллах явдал дутагдалтай гэдгийг олон улсын шинжээчдийн дүгнэлтээр гарсан. Санал: Монголбанк арилжааны банкиг удирдах монополь эрхээ эдлэхдээ эрх үүргээ хэрхэн биелүүлж чадаж байгаа эсэхдээ дүгнэлт хийх, Монголбанк арилжааны банкуудын активын бүтцэд судалгаа хийх, чанаргүй актив үүссэн шалтгааныг тодруулж, цаашдын бодлогын чиглэлээ гаргах, Монголбанкнаас арилжааны банкуудад хийж буй хяналтыг хөндлөнгийн давхар хяналттай болгох асуудлыг анхааралдаа авах.		Банкны систем 2018 онд 17 их наяд төгрөгийн зээл олгосон байна. Үүний 1.7 их наяд нь буюу 10 хувь нь чанаргүй ангилалд оржээ. Өмнөх түүх харвал, эдийн засгийн хүндрэлтэй үед буюу 2016 онд чанаргүй зээл 12 хувьд хүрсэн. Тэгвэл эдийн засаг нэлээд сэргэсэн үе буюу 2018 онд найман хувь болж буурсан. Харин 2019 онд чанаргүй зээл 10 хувьд хүрсэн бол 2021 онд 9 хувь, 2022 оны 8 сарын байдлаа буцаад 10.4 хувьд хүрэв. Эдийн засаг хүндрэхээр зээлд сөргөөр нөлөөлж байна. Монголбанкны бүтцийн өөрчлөлтийн хүрээнд ХШГ нь ББӨБГ шинээр байгуулагдаж чиг үүргийн хувьд бодлогын арга хэмжээг хариуцан ажиллах болсон.	
Төлбөрийн чадваргүй болсон банкинд ажиллаж буй Монголбанкны эрх хүлээн авагчдын ажлын үр дүн болоод цаашдын үйл ажиллагааны талаар	Хурлын мэдээ 2020.09.14	44.	Түүнчлэн хурлаар дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон банкинд ажиллаж буй Монголбанкны эрх хүлээн авагчдын ажлын үр дүн болоод цаашдын үйл ажиллагааны талаар санал солилцов. Монголбанкны Хяналтын зөвлөлийн зүгээс хууль, эрх зүйн асуудал зөрчигдөж, иргэдийн хохирлыг барагдуулах үйл ажиллагаанд учирч буй саад бэрхшээлийг зохих шатны холбогдох газруудад уламжилж ажиллах, мөн дампуурсан банкны эздийг, зээлдэгч нарыг хохирол	ББӨБГ	Банкны тухай хуульд 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн хуулиар банкнийг албадан татан буулгах, БЭХА-ийн үйл ажиллагаатай холбоотой нэмэлт, өөрчлөлт орсон. Уг нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэх, БЭХА-ын үйл ажиллагаанд бэрхшээлтэй байгаа зүйлийг тодорхой зохицуулах, олон улсын туршлагыг нэвтрүүлэх зорилгоор журмыг Захиргааны ерөнхий хуулийн дагуу шинэчлэн боловсруулж удирдлагуудад танилцуулж байна. Шинэчилсэн журмын төсөлд БЭХА-ийг томилох, тус арга хэмжээг хэрхэн дуусгавар болгох үйл явцыг нарийвчлан, БЭХА-ийн үйл ажиллагаанд тавих хяналт, хариуцлагыг нэмж тусгасан. Капитал банкны БЭХА нь АТГ-тай хамтран ажилласаны үр дүнд тус банкны хувьцаа эзэмшигчийн банкинд бүртгэгдээгүй байсан үл	Биелэлт-90% Санал, зөвлөмжийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллажээ.

				барагдуулахад хэрхэн татан оролцуулах, зээлдэгчдийг дэмжин өр төлүүлэх арга механизмыг боловсронгуй болгох, олон улсын туршлага судлах талаар анхаарч ажиллахыг санал болгов.		хөдлөх хөрөнгөөр 90 орчим тэрбум төгрөгийн хохирлыг барагдуулан ажилласан.	
	Зээлийн мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаар		45.	Монголбанкны мэдээллийн сангийн үйл ажиллагааг чанаржуулж, чадваржуулахын тулд эхний ээлжинд дотоод нөөц бололцоогоо бүрэн ашиглах бололцоог хайх, шаардлагатай тохиолдолд гаднаас хүч нэмэх асуудлыг Монголбанкны удирдлагад уламжилж, шийдвэрлүүлэхийг санал болгов.	ЗМА	Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн А-127 дугаар тушаалаар Зээлийн мэдээллийн албанд хянан шалгагчийн 2 орон тоо нэмж энэхүү орон тоон дээр дотоод нөөцөө ашиглаж Монголбанкны бусад газар, нэгжүүдээс ажилтнууд томилогдсон болно.	Биелэлт-100% Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллажээ.
		Албан бичиг 2020.09.25 №18	46.	Дүгнэлт, санал хүргүүлэх тухай Монголбанкны ЭУА-аас 2019-2020 онд санхүүгийн болон үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хүрээнд хийсэн гол ажлууд, мэдээлэл, үйл ажиллагааны эрсдэлийн зураглал, үйл ажиллагааны эрсдэлийн гол үзүүлэлтийн мэдээлэл зэрэг материалтай танилцан, хурлаар хэлэлцүүлэн ДҮГНЭХ нь: Хяналтын зөвлөлийн 2017, 2018 онд өгсөн зөвлөмжийн дагуу санхүүгийн эрсдэлийн удирдлага ялангуяа ГВУН-ийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах чиглэлээр тодорхой судалгаанууд	ЭУА УТГ	ЭУА нь 2019 оны 2 дугаар сарын 28-ны өдөр "Цахим эрсдэлийн тухай" танилцуулга бэлтгэж мэдээллийн аюулгүй байдлын алба, түүний орон тоо, хүний нөөц, мөн шаардлагатай програм хангамж, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэх, одоо байгааг сайжруулах талаар санал, дүгнэлтийг удирдлагад хүргүүлсэн. Үүнээс гадна ЭУА нь жил бүр үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын жилийн тайлан бэлтгэж банкны удирдлагад танилцуулдаг бөгөөд 2020 оны жилийн тайланд мэдээллийн аюулгүй байдал, кибер аюулгүй байдалд илүү анхаарал хандуулах, програм хангамж, тоног төхөөрөмжийг сайжруулах, ажиллагсдын энэ талаарх мэдлэгийг дээшлүүлэх, мэдээллээр тогтмол хангах арга хэмжээ авах шаардлагатай байна гэсэн дүгнэлт, саналыг удирдлагад хүргүүлсэн. Үүнээс гадна 2021 оны 1 дүгээр сарын 5-ны өдөр МТГ-т мэдээллийн аюулгүй байдлыг сайжруулах үүднээс авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний	Биелэлт-100% Санал, зөвлөмжийг хүлээн авч, үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллажээ.

			хийж, судалгаанд үндэслэн зээлийн болон хөрөнгө оруулалтын хөрөнгө эрсдэл тооцоолох аргачлалыг сайжруулах, Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн үнэлгээний зааврыг шинэчлэх, Монголбанкны санхүүгийн тайланд эрсдэлийн шинжилгээ хийх зэрэг олон ажил хийсэн байна. Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлага нь 2016 онд батлагдсан журам, 2017 онд баталж 2019 онд шинэчилэн баталсан үйл ажиллагааны эрсдэлийн гол үзүүлэлтийг ашиглан эрсдэлийн өөрийн үнэлгээ, гол үзүүлэлтийн үнэлгээ, эрсдэлийн зураглал хийх, эрсдэлийн мэдээллийн сан хөтлөх зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна. Хяналтын зөвлөлийн 2020 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн хурлаар хэлэлцүүлэн дараах саналыг дэвшүүлж байна. Үүнд: Үйл ажиллагааны эрсдэлийн гол үзүүлэлтийн байдал, зураглал зэргээс харахад цаашид Монголбанк кибер аюулгүй байдалд онцгой анхаарч техник хангамжаа сайжруулах нь зүйтэй. Монголбанк эрсдэлийн удирдлагын олон улсын стандарт (ISO 31000)-г эрсдэлээ үнэлэх болон удирдах үйл ажиллагааг сайжруулахад авч	талаар зөвлөмж газар хоорондын албан бичгээр хүргүүлсэн. ЭУА нь эрсдэлийн удирдлагын олон улсын стандарт (ISO 31000)-ыг судалж үзсэн бөгөөд 2020 оны 12 дугаар сард шинээр боловсруулан батлуулсан “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын бодлогын баримт бичиг” болон шинэчлэн батлуулсан “Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын журам”-ыг дээрх стандарттай нийцтэй байхад анхаарч боловсруулсан болно.	
--	--	--	--	---	--

				хэрэгжүүлэх нөхцөл боломжийг судлахыг зөвлөж байна.			
	Хурлын тэмдэглэлээр өгсөн	2021.03.09	47.	Гарьд захирал: өөрсдөө хоорондоо ярьж байгаад зоосныхоо бүртгэл үнэлгээний асуудлыг дахинж яриад, 2021 онд зохицуулах арга хэмжээ авъя гэсэн амлалт өгсөн. Түүнийг бид анхааралдаа авлаа. Эргэн мэдэгдэх	НУСЗЗГ СБГ	Эрдэнэсийн сан дахь 1925 оны зоосон мөнгөн тэмдэгтийг 2017 онд олон улсын хөндлөнгийн үнэлгээний MAD байгууллагаар үнэлүүлсэн. Тус байгууллагын үнэлгээний аргачлалын дагуу эдгээр зоосны зах зээлийн үнийн судалгааг НУСЗЗГ-ийн Эрдэнэсийн сангийн асуудал харнуцсан эдийн засагч нар хийж байгаа бөгөөд хэрэв зах зээлийн үнэ тэнцлийн үнээс огцом өсөлт бууралттай байх тохиолдолд (судалгааны үр дүнгээс шалтгааж) хөндлөнгийн үнэлгээний компаннар зоосны үнэлгээг дахин хийлгүүлэх болно.	Биелэлт-70% Тус ажил хийгдэж байна.
	Хурлын тэмдэглэлээр өгсөн	2021.06.04	48.	МБ-ны захирлуудын зөвлөл гэсэн хамтын удирдлагын зарчимдаа орж чадаж байгаа юу?	ХЭЗГ	2018 онд Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу тус хуулийн 27.2 дахь хэсэгт зааснаар Монголбанкны Ерөнхийлөгч уг хуульд тусгайлан заасан Мөнгөний бодлогын хороо, Банкны хяналт шалгалтын хорооны хэлэлцэх асуудлаас бусад асуудлаар зөвлөх эрх бүхий Зөвлөл байгуулж болно. Тус бүрэн эрхийн хүрээнд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2018 оны А-103 дугаар тушаалаар Монголбанкны Захирлуудын зөвлөлийн ажиллах журмыг баталсан. Захирлуудын зөвлөлийн хурлаас Зөвлөлийн шийдвэр гарна. Тус шийдвэр нь Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд заасны дагуу зөвлөмжийн шинжтэй боловч Монголбанкнаас хамтын шийдвэр гарч буйн илэрхийлэл гэж үзэж байна.	Биелэлт-100%
			49.	Арилжааны банкуудыг МБ дангаараа монопольдоод шалгаад, бусдаар шалгуулахгүй байдаг, энэ чинь болж байгаа юм уу, олон улсын жишгээр бол 3-4 шалгалт хийгдэж байж арилжааны банкуудын үйл ажиллагаа жингдэрнэ, Монголын судас гэсэн үг. Энэ дээр зөвхөн зөвшөөрлөө олгогчхоод, өөрөө шалгаад	ХШГ ББӨБГ	Төвбанк /Монголбанк/-ны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1-д “Монголбанк хадгаламж эзэмшигч, харилцагчийн эрх ашгийг хамгаалах, банкны тогтолцооны найдвартай байдлыг бэхжүүлэх зорилгоор банк байгуулах зөвшөөрөл болон банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгох, банкны өөрийн хөрөнгө, төлбөрийн чадварыг хангуулах, үйл ажиллагааг нь зохицуулах, албадлагын арга хэмжээ авахтай холбогдсон дүрэм, журам, заавар, аргачлал болон холбогдох бусад шийдвэр гаргаж, хэрэгжилтэд нь хяналт тавина.” гэж заасан байдаг.	Биелэлт-100% Зөвлөмжнийг үйл ажиллагаандаа тусган ажиллажээ.

				байх нь зөв үү буруу юу гээд тусдаа хяналтын хороотой болгоорой гэсэн. Хяналтын хороо шиг, үүнийг цаашид яах вэ? хөндлөнгийн хяналттай болгох шаардлагатай.		Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөөр банкууд нээлттэй хувьцаат компани хэлбэрт шилжсэнээр банкуудын үйл ажиллагаа, мэдээллийн ил тод байдалд Санхүүгийн Зохицуулах Хороо хууль тогтоомжид заасны дагуу хяналт шалгалтаа давхар хэрэгжүүлэх юм. Цаашид Монголбанкнаас Санхүүгийн зохицуулах хороо болон бусад эрх бүхий байгууллагуудтай хамтран Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд банкны салбарын тогтвортой байдлыг хангах чиглэлээр шаардлагатай арга хэмжээнүүдийг тухай бүр авч, банкны хяналт шалгалтыг хэрэгжүүлэх, банкны салбарын шинэтгэлийг амжилттай үргэлжлүүлэхэд анхаарч ажиллана. Төв банкны тухай хуульд заасны дагуу Монголбанкнаас СЗХ, СЯ-тай хамтарсан шалгалтыг хийж байна. Тухайлбал 2019-2022 онуудад давхардсан тоогоор 23 удаагийн хамтарсан шалгалтыг хийж гүйцэтгэн үр дүнг тооцож ажилласан байна.	
Хурлын тэмдэглэлээс	2021.09.10	50.	Банкууд дээр байгаа мөнгө, ерөнхийдөө мөнгөний тэнцвэрийг хангана гэдэг бол эдийн засгийн маш чухал асуудал. Та бүхний ярьсан арилжааны банк дээр байгаа мөнгө хөдлөхгүй байх юм бол эргээд валют өсөөд асар их эдийн засгийн дарамт учруулна гэж энэ үүднээс төв банкны үнэт цаасыг гаргаж байгаа гэдэг бол онолын хувьд зөв л дөө. Гэхдээ тэр мөнгийг заавал төв банкны үнэт цаасаар татаж авч байх нь зөв үү эсвэл саяын Засгийн газрынх шиг 10 их наядын хөтөлбөр гэдэг шиг ийм байдлаар эргэлтэнд оруулж байх уу гэдэг	НУСЗЗГ МБГ	2022.09.30-ны өдрийн байдлаар ТБҮЦ-ны нийт үлдэгдэл 4,322.0 тэрбум төгрөг байна. Энэ нь 2022 оны эхэн үеэс 50.0 хувьнаар буюу 4,323.0 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлт юм. Тус өөрчлөлтөд Монголбанкны алт худалдан авалтаар нийлүүлсэн 2,125.1 тэрбум төгрөг, Монголбанкны валютын үйл ажиллагаагаар банк хоорондын захаас татсан 6,760.4 тэрбум төгрөг, төгрөгийн ЗБН-ийн хувь хэмжээг нэмэгдүүлсэнтэй холбоотой 219.2 тэрбум төгрөг татсан нь гол нөлөөг үзүүлсэн байна. Арилжааны банкууд өөрсдийн илүүдэл нөөц, эрсдэлийн түвшин болон хөрвөх чадвар зэргийг харгалзан нөөцийн удирдлагаа оновчтой хэрэгжүүлэх хүрээнд ТБҮЦ-ыг ашигладаг. Ингэснээр банк хоорондын захын нөөцийн хэт илүүдэл болон дутагдлаас үүдэх хүүгийн хэлбэлзлээс сэргийлдэг байна. Иймд ТБҮЦ-ны арилжаа нь цэвэр арилжааны банкуудын өөрсдийн шийдвэр дээр үндэслэдэг. ТБҮЦ-ны хэмжээ 2021 оны 5 сард 10.2 их наяд төгрөгт буюу түүхэн дээд	Биедэлт-100% Санал, зөвлөмжийг хүлээн авсан.	

			зүйлүүдийг цааш нь сайн бодмоор байна л даа. Өөр зарим байдлаар чөлөөт байдалд байгаа мөнгийг эргэлтэнд оруулах уу гэдгийг төв банк л санаачилна. Түүнээс биш төв банк өөр дээрээ алдагдал хүлээгээд арилжааны банкуудаа дэмжиж байгаа гээд мөнгөний бодлого явуулж байгаа гээд хохироод байхаар түүнийг цааш нь зах зээл рүү оруулж тэтгэгдэж тэжээх тэндээс эх үүсвэрийг нь олох, тэнд нь шингээх ийм арга хэмжээг л цаашид авч явуулж баймаар байна. Үүнийг та нар цаашид бодлого дээрээ сайн бодож, ярьж байгааг гэсэн зүйлийг хэлмээр байна, та бүхний саналыг сонсмоор байна.		түвшинд хүрсэн. Үүнээс хойш буурсаар өмнөх оны мөн үеэс 2 дахин буурсан үзүүлэлттэй байгаа нь цар тахлын өмнөх үеийн түвшинд эргэн очсон.	
--	--	--	---	--	---	--

Монголбанкны Хяналтын зөвлөлөөс гаргасан санал, зөвлөмж түүний хэрэгжилтийг нэгтгэн үзэхэд нийт 50 санал зөвлөмжөөс 42 буюу 84 хувь нь 100% бүрэн биелэсэн бол 8 санал, зөвлөмж буюу 16 хувь нь (30%-90%)- ийн гүйцэтгэлтэй байна.

Дутуу биелэлттэй ажлуудыг задлан харвал 90, 95%-ийн гүйцэтгэлтэй санал зөвлөмж тус бүр 1, 70%-ийн гүйцэтгэлтэй 3 санал, 60%-ийн гүйцэтгэлтэй 1, 30% ийн гүйцэтгэлтэй 2 санал зөвлөмжүүд багтаж байна.

—o—

**ТӨВ БАНК (МОНГОЛБАНК)-НЫ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛД ОУВС-ААС ӨГСӨН САНАЛ**

I. Захиргааны хэм хэмжээ гаргах бүрэн эрх

1. Монголбанк Төв банк (Монголбанк)-ны тухай хууль болон бусад хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлэх хүрээнд журам, заавар, тушаал гаргах бүрэн эрхтэй.
2. Монголбанкнаас гаргасан журмыг нийтээр шууд, дагаж мөрдөнө.
3. Монголбанкны журмыг нийтлэх бөгөөд нийтэлсэн өдрөөс эхлэн, эсвэл тусгайлан заасан өдрөөс дагаж мөрдөнө.
4. Монголбанкнаас гаргасан заавар нь зөвхөн чиглэсэн этгээдэд үйлчилнэ. Монголбанк гаргасан зааварчилгаа болон тушаалын талаар нийтэд мэдээлж болно.
5. Захиргааны Ерөнхий хууль нь Монголбанкаас гаргах зохицуулалтын журамд үйлчилэхгүй.

II. Чиг үүрэг:/Нэмэлтээр тусгах/

1. Монголбанк өөрийн үндсэн зорилтоо хангах хүрээнд энэ хуульд тодорхойлсон дараах чиг үүргийг хэрэгжүүлнэ:

а. Банкны хууль тогтоомжид тусгайлан заасан урьдчилан сэргийлэх (preventive), урьдчилсан оролцоо (early intervention) болон шийдвэрлэлтийн (resolution) арга хэмжээг *баталж*, хэрэгжүүлэх

б. Макро зохистой бодлогын арга хэмжээг СЗХ болон СЯ-тай хэлэлцсэний үндсэн дээр *баталж*, хэрэгжүүлэх.

III. Төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зээл

1. Онцгой тохиолдолд, Монголбанк нь Мөнгөний бодлогын зөвлөлийн тодорхойлсон нөхцөл, шаардлагын хүрээнд 90 хоногоос дээшгүй хугацаатай зээлийг торгуулийн хүүтэйгээр банкинд /benefit/ олгож болно. Зээлийн хугацааг Монголбанк нь дахин нэг удаа 90 хугацаагаар сунгах шийдвэр гаргаж болно. Монголбанк энэ хуульд заасан зээлийг үүссэн асуудлаа шийдвэрлэх талаар тухайн банкны гаргасан хөтөлбөр, арга хэмжээний талаарх хяналт шалгалтын мэдээллийг үндэслэн дараах тохиолдолд олгож болно:

а. Монголбанкны тодорхойлсноор зээлдэгч банк нь төлбөрийн чадвартай, зээлийг эргэн төлөлтийг баталгаажуулах хангалттай барьцаатай, зээлийн хүсэлт нь зөвхөн төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг дэмжих зориулалттай байх;

б. зээл нь санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хадгалахад шаардлагатай бөгөөд зээлийн эргэн төлөлт нь Засгийн газар (Сангийн яам)-ын бичгээр гаргасан хуулийн хүчин төгөлдөр баталгаатай байх.

2. Аль ч тохиолдолд, өмнөх хэсэгт заасны дагуу олгосон зээлийн 90 хоногийн хугацааг сунгахад Засгийн газрын бичгээр гаргасан баталгааг шаардана. Зээлийг эргэн төлөх хугацааны сунгалт нь 90 хоногоос хэтрэхгүй байна.

3. Монголбанкны Зөвлөл энэ хуулийн 1-д заасан зээлийн барьцаа хөрөнгийн үнэлгээний дээд хэмжээг тодорхолно.

4. Зээлдэгч банк энэ хуулийн 1-д заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй, эсвэл арга хэмжээ нь үр дүнд хүрээгүй бол Монголбанк банкинд торгох зэрэг хуульд заасан шаардлагатай арга хэмжээг авна.

IV. Засгийн газрын санхүүгийн зуучлагчийн үүрэг

1. Монголбанк төрөөс болон төрийн өмчит хуулийн этгээд, эсвэл нийтийн хуулийн этгээдээс гаргасан үнэт цаасыг анхдагч зах зээлээс худалдан авахгүй. Монголбанк энэ хэсэгт заасан үнэт цаасыг хоёрдогч зах зээлээс авч болох ч энэхүү худалдан авалт нь хуульд заасан хориглолт, хязгаарлалтын хүрээнд байна.

2. Энэ зүйлд заасан үйл ажиллагаа явуулахад Монголбанкинд үүссэн зардлыг Засгийн газар хариуцана.

V. Статистик мэдээлэл цуглуулах

1. Монголбанк дараах бүрэн эрхтэй байна:

а. Чиг үүргээ хэрэгжүүлэхтэй холбоотойгоор статистик мэдээлэл цуглуулах, эмхэтгэх, шинжлэх, нийтлэх,

б. Монголбанкинд статистик мэдээлэл гаргаж өгөх иргэн, хуулийн этгээдийн үүрэг, статистик мэдээллийн хэлбэр, нууцлал хадгалах журам болон мэдээлэх үүргээ биелүүлээгүй тохиолдолд авах хариуцлага зэргийг журамд тусгаж тодорхойлох,

в. Статистик болон бусад мэдээллийг цуглуулах, эмхэтгэх, нийтлэх талаар төрийн бусад байгууллагатай хамтран ажиллах,

г. Үр дүнтэй, уялдаатай статистик мэдээллийг бүрдүүлэх зорилгоор олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн статистикийн арга зүй, өгөгдөл түгээх стандартыг нэвтрүүлэх талаар хоёр талын болон олон талын байгууллагатай хамтран ажиллах.

2. Монголбанк дараах мэдээллийг нийтэлнэ:

а. Энэ хуулийн хэсэгт заасан нууцлалд хамаарах статистик

б. Холбогдох статистик мэдээллийг боловсруулах арга зүй,

в. Монголбанкнаас боловсруулсан статистик мэдээллийг баталгаажуулж болохуйц холбогдох статистик өгөгдөл, зарчим.

VI. Банкны хяналт шалгалтын бүрэн эрх

1. Монголбанк банкныг зохицуулах, зөвшөөрөл олгох, бүртгэх, хянан шалгах зэргээр Банкны тухай хуульд зааснаар чиг үүргийг тусгайлан хариуцана /*банкинд хяналт тавих онцгой бүрэн эрхтэй байна*/. Энэ чиг үүрэгт нь Банкны тухай хуульд заасан захиргааны торгууль оногдуулах бүрэн эрх хамаарна.

2. Монголбанкны албан хаагч, эсвэл Монголбанкнаас эрх олгосон шаардлага хангасан этгээд нь банкны данс, нягтлан бодох бүртгэлийн баримт бичиг, тэмдэглэлтэй танилцах, тэдгээрээс мэдээлэл авах, тэмдэглэгээ хийх, банкны байранд нэвтрэх эрхтэй байна.

3. Монголбанк банкны хөрөнгийн чанарыг нягтлан үнэлэх, Монголбанкнаас тогтоосон стресс /ачааллын/ сорилд орохыг шаардах эрхтэй бөгөөд уг үйл ажиллагааг хэрэгжүүлэх болон зөвлөх хөлсөлсөнтэй холбоотой гарсан зардлыг холбогдох банкаар нөхөн төлүүлэх эрхтэй.

4. Банкинд хийсэн газар дээрх болон зайнаас тавих хяналт, активын чанарын үнэлгээ, стресс сорилд үндэслэн Монголбанк шаардлагатай гэж үзсэн нэмэлт өөрийн хөрөнгө шаардах, эрсдэлийн сан байгуулах зэрэг аливаа арга хэмжээ авахыг банкнаас шаардах эрхтэй.

5. Банк нь банкны үйл ажиллагаа, санхүүгийн байдалтай холбоотой аливаа мэдээлэл, тайланг Монголбанкны шаардснаар гаргаж өгөх, хамтран ажиллах үүрэгтэй.

6. Монголбанк энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу авсан нууц мэдээллийг банкны үйл ажиллагааны онцлогоор нь ангилж бүхэл эсвэл хэсэгчилсэн байдлаар бусад эрх бүхий байгууллагатай солилцох, эсвэл бусад улсын дараах байгууллагатай солилцож болно:

а. Санхүүгийн бусад байгууллагын хяналт шалгалт хариуцсан

б. санхүүгийн зах зээлийн хяналт шалгалт

в. Макро зохистой бодлогоор дамжуулан санхүүгийн тогтолцооны тогтвортой байдал хариуцсан

г. Банкны шийдвэрлэх болон өөрчлөн байгуулах арга хэмжээ хариуцсан.

VII. Макро зохистой байдлын чиг үүрэг

1. Монголбанкн энэ хүрээн дараах чиг үүрэгтэй байна:

а. Санхүүгийн зах зээл эрсдлийн хуримтлал, weaknessд ажиглалт хийх

б. Тогтолцооны шинжтэй эрсдэлийн эх сурвалж-үүсгэлийг арилгах чиглэлээр энэ хууль болон бусад холбогдох хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх

2. Энэ хэсэгт заасан чиг үүргийн хүрээнд Монголбанк дараах зорилтыг хангана:

а. Санхүүгийн тогтолцооны хүндрэл давах, сэргэх байдлыг бэхжүүлэх

б. Зээл, хөшүүрэг, хөрөнгийн үнийн тогтворгүй өсөлтөөс бий болох эрсдэлийг бууруулах

в. Санхүүгийн зах зээлийн харилцан хамаарлаас үүдэлтэй тогтолцооны эрсдэлийг бууруулах

3. Монголбанк өөрийн үндсэн зорилтод харшилахгүйгээр дараах чиглэлтэй ажиллана:

а. Эдийн засгийн урт хугацааны хөгжилд санхүүгийн тогтолцоо нэмэр оруулах байдлыг хангах

б. Хадгаламж эзэмшигч, хөрөнгө оруулагчдын ашиг сонирхолыг хамгаалах

4. Монголбанк дараах зүйлийг бэлтгэж, нийтэлнэ:

а. Энэ хууль болон бусад холбогдох хуульд заасан макро зохистой бодлогын хэрэгсэлийг Монголбанкнаас ашиглах стратегийг тодорхойлсон бодлого

б. Хэлэлцсэн асуудал, саналын өгсөн байдал зэргийг тусгасан макро зохистой бодлогын шийдвэр гаргах талаар хурлын тэмдэглэл

в. Эрсдэлийн үнэлгээ болон уг эрсдэлийг бууруулах талаар бодлогын арга хэмжээ зэргийг тусгасан макро зохистой байдлыг хангах үйл ажиллагааны талаарх тогтмол тайлан.

VIII. Монголбанкны удирдлага

Энэхүү зовломж нь гүйцэтгэх болон бие даасан хяналтын зөвлөлөөс бүрдсэн хоёр шатлалт зөвлөлийн тогтолцооноос илүүтэйгээр нэгдсэн зөвлөлийг нэвтрүүлэх талаар Монголбанкны урьдчилсан байр суурийг харгалзсан болно.

1. Монголбанкны удирдлага нь Монголбанкны Ерөнхийлөгч, Мөнгөний бодлогын хороо, Хяналт шалгалтын хороо болон Удирдах зөвлөлөөс бүрдэнэ.
2. Мөнгөний бодлогын хороо нь Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон... захирлуудаас бүрдэнэ.
3. Хяналт шалгалтын хороо нь Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон... захирлуудаас бүрдэнэ.
4. Удирдах зөвлөл нь Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч болон хараат бус ... гишүүнээс бүрдэнэ.
5. Монголбанкны Ерөнхийлөгч Монголбанкны өдөр тутмын үйл ажиллагааг удирдан зохион байгуулж, Удирдах зөвлөл, Мөнгөний бодлогын хороо, Хяналт шалгалтын хорооноос гаргасан бодлогын шийдвэрийн хэрэгжилтийг хангуулж ажиллана.
6. Монголбанкны Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгч нь Монголбанкны Ерөнхийлөгчид туслах чиг үүрэгтэй байх бөгөөд түүний эзгүйд орлон ажиллана.

IX. Хяналт шалгалтын хорооны бүрэн эрх, чиг үүрэг

Энэ хуулийн ... -д заасан Монголбанкны чиг үүргийн хүрээнд, дараах бүрэн эрхтэй Хяналт шалгалтын хороо Монголбанкны бүтцэд ажиллана:

- а. Банкны хууль тогтоомж болон энэ хуулийн ...-д заасан банкинд хяналт тавих Монголбанкны бүрэн эрхийн хүрээнд Хяналт шалгалтын шийдвэр гаргах (Хянан шалгагчид тусгайлан олгоогүй эрх зүйн үр дагавар ихтэй томоохон шийдвэр)
- б. Энэ хууль болон Банкны тухай хуульд заасны дагуу хямралаас урьдчилан сэргийлэх, урьдчилсан оролцоо, тухайлсан банкийг шийдвэрлэх арга хэмжээ авах
- в. Банкнд хяналт тавих Монголбанкны бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбоотой Монголбанкны бодлогыг тодорхойлж, батлах, шаардлагатай тохиолдолд үүнийг хэрэгжүүлэх дотоод дүрэм, хэм хэмжээ батлах
- г. Монголбанкны зохицуулалтад хамаарах банк, санхүүгийн байгууллага, төлбөр тооцооны системийн оролцогч (клиринг болон үнэт цаасны тооцоо)-ийн эсрэг албадлагын арга хэмжээ авах, тэдгээрт эрх хүлээн авагч томилох
- д. Энэ хууль болон бусад хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах
- е. Хяналт шалгалтын чиг, үүрэг бүрэн эрхтэй холбоотойгоор Монголбанкнаас гаргах журмыг батлах
- ё. Чиг үүргийн дагуу хороо байгуулж, тэдгээрийн гишүүдийг томилох хугацаа нөхцөл, ажиллах журмыг ToR тогтоох
- ж. Урьдчилан тодорхойлсон нөхцлөөр тусгайлсан бүрэн эрхийг МБЕрөнхийлөгч, хороо, Монголбанкны ажилтанд шилжүүлэх

з. Хорооны дүрэм, журмыг батлах

Х. Энэ хуульд заасны дагуу дараах чиг үүрэг бүхий мөнгөний бодлогын хороо ажиллана:

- Зохистой гол хүүгийн түвшин заавал байлгах нөөцийн доод хэмжээг тогтоосон мөнгөний бодлогыг тодорхойлж батлах, тэдгээрийг хэрэгжүүлэх дотоод дүрэм батлах
- Энэ хуультай нийцүүлэн засгийн газарт зээл олгох, засгийн газрын үнэт цаасыг худалдан авах, худалдах эсэхийг шийдвэрлэх.
- Дэд хороо байгуулах, тэдгээрийн гишүүдийн томилгоо, нөхцөл шалгуурыг тогтоох, үйл ажиллагааны журмыг тодорхойлох.
- Урьдчилан тогтоосон нөхцлөөр тусгай бүрэн эрхийг Монголбанкны Ерөнхийлөгч, хороо, Монголбанкны ажилтанд шилжүүлэх.
- Мөнгөний бодлогын хорооны ажиллах журмыг батлах.

XI. Удирдах зөвлөлийн бүрэн эрх, чиг үүрэг

Удирдах зөвлөл нь дараах бүрэн эрхтэй байна.

- Улсын гадаад валютын нөөцийг удирдах
- Монголбанкны санхүүгийн эх үүсвэрийн хөрөнгө оруулах тохиромжтой активын төрлийг тодорхойлох
- Гадаад валютын бодлогын хэрэгжилтийг тодорхойлох
- Мөнгөн тэмдэгтийн загвар, нэрлэсэн үнэ болон түүнийг гаргаж зохицуулах асуудлыг шийдвэрлэх
- Монголбанкнаас үйл ажиллагаа явуулах дүрэм журмыг тодорхойлж батлах
- Монголбанкны стратегийг тодорхойлох
- Монголбанкны төсөв батлах
- Монголбанкны жилийн тайлан, тэнцэл, дансыг батлах
- Монголбанкны бүтэц, зохион байгуулалтыг тодорхойлох, ажилтан, хүний нөөцийн ерөнхий зохицуулалтыг тодорхойлох, ажилд авах, дэвшүүлэх, сахилга хариуцлагын асуудлыг шийдвэрлэх
- Монголбанкны ерөнхий дотоод аудитрыг томилох
- Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцүүлэн Монголбанкны нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмыг батлах
- Монголбанкны тайлан тэнцлээр тодорхойлох эрсдэлийн сан, эрсдэлийн удирдлага, нийцэл, мэдээллийн технологи, аюулгүй байдал, дотоод удирдлагыг тодорхойлж хянах
- Аудитын хорооноос бэлтгэсэн дотоод аудитын тайланг батлаж, дотоод аудитрын зөвлөмжийн хэрэгжилтийг хянах
- Дэд хороо байгуулах, тэдгээрийн гишүүдийн томилгоо, нөхцөл шалгуурыг тогтоох, үйл ажиллагааны журмыг тодорхойлох.
- Урьдчилан тогтоосон нөхцлөөр тусгай бүрэн эрхийг Монголбанкны Ерөнхийлөгч, хороо, Монголбанкны ажилтанд шилжүүлэх.

- Мөнгөний бодлогын хорооны ажиллах журмыг батлах.
- Монголбанкны Ерөнхийлөгч, мөнгөний бодлогын хороо, хянан шалгалтын хороонд хамаарахгүй бусад чиг үүргийг хэрэгжүүлэх

XII. Төсөв

1. Дараагийн санхүүгийн жил эхлэхээс өмнө удирдах зөвлөл Монголбанкны жилийн төсвийг батлана.
2. Үнэ цэнийн бууралт, алдагдлын сан зэрэг төлөвлөгдсөн зарлага болон Монголбанкны үйл ажиллагаа эсвэл Монголбанканд аливаа эх сурвалжаас бий болох орлого, ашиг зэрэг нь жилийн төсөвт багтана.
3. Батлагдсан жилийн төсвийг мэдээллийн зорилгоор Сангийн яаманд илгээнэ.
4. Удирдах зөвлөл нь жилийн төсвийг хэрэгжүүлэх дотоод дүрмийг батлана.

XIII. Дотоод ерөнхий аудит

1. Монголбанкны дотоод ерөнхий аудитрыг Ерөнхийлөгчийн санал болгосноор удирдах зөвлөл томилно.
2. ДХА нь нягтлан бодох бүртгэл эсвэл аудитын чиглэлээр өндөр зэргийн мэргэжлийн туршлагатай хүн байна.
3. ДХА-г 5 жилийн хугацаатай томилох бөгөөд сунгаж болно. Түүнийг хууль бус үйлдэл гаргасан эсвэл ноцтой ёс зүйн алдаа гаргасан гэдгийг шүүхээс тогтоосноос бусад тохиолдолд ажлаас чөлөөлөхийг хориглоно.
4. ДХА бусад дотоод аудитруудын дэмжлэгтэйгээр дараах чиг үүргийг гүйцэтгэнэ.
 - a. Зохистой эрсдлийн удирдлагын журам хэрэглээний талаар аудитын хороо, Монголбанкны Ерөнхийлөгчид зөвлөмж өгөх, тэдгээрийн хэрэгжилтийг хянаж үр дүнд байнгын үнэлэлт өгч байх.
 - b. Монголбанкны удирдлага, үйл ажиллагаанд давтамжтайгаар аудит хийх.
 - c. Энэ хуульд заасан санхүүгийн тайлан тэнцэл, бусад баримт бичгийг хянан үзэх.
 - d. Аудитыг хороо болон Монголбанкны Ерөнхийлөгчөөс шаардлагатай гэж үзсэн хэдийд ч хамгийн багадаа улирал тутамд санхүүгийн тайлан тэнцэл, тэмдэглэл, төсөв ба нягтлан бодох бүртгэлийн журам, эрсдэлийн удирдлага, бусад хяналт зэргийг Монголбанкнаас хэрхэн хэрэгжүүлж байгаа талаар тайлан, зөвлөмжийг удирдах зөвлөлд бэлтгэж, хүргүүлэх, үр ашигтай, зардал багатайгаар Монголбанк үйл ажиллагаа явуулж байгаа эсэх, өөрийн чиг үүрэгт хамаарах бусад зүйлсийн талаар мэдээ, тайлан бэлтгэж удирдах зөвлөлд хүргүүлэх.
 - e. Монголбанкны хөндлөн аудитртай хамтран ажиллах.
 - f. Аудитын хороо эсвэл Монголбанкны Ерөнхийлөгчөөс даалгасан бусад үйл ажиллагаа нь өөрийн үндсэн чиг үүрэгт харшилдахгүй тохиолдолд авч хэлэлцүүлэх.

XIV. Аудитын хороо

1. Удирдах зөвлөл аудитын хороог томилно.
2. Аудитын хорооны гишүүд нь удирдах зөвлөлийн хараат бус гишүүдээс томилогдоно.
3. Аудитын хорооны нэгээс доошгүй гишүүн нь нягтлан бодох бүртгэл эсвэл аудитын чиглэлээр мэргэжлийн ихээхэн туршлагатай байна. Хэрэв ийм гишүүн байхгүй тохиолдолд аудитын хороо нь гадны мэргэжилтнийг томилно. Энэ хуулийн т заасан томилгооны шалгуур нь удирдах зөвлөлийн гишүүн биш байх, гадны мэргэжилтэн эсвэл

аудитын хорооны гишүүнээс томилогдохоос өмнөх 3 жилийн хугацаанд Монголбанкны ажилтан биш байх шаардлагыг хангасан байна.

4. Өмнөх зүйлд заасан гишүүнийг ажлаас чөлөөлнө хэрэв зөвлөл тухайн аудитын хорооны гишүүнтэй холбоотойгоор хуульд заасан чөлөөлөх нөхцөл бүрдсэн зөвлөлийн гишүүний шалгуур хангахаа больсон чөлөөлөх нөхцөл бүрдсэн гэж үзсэн тохиолдолд. Цаашилбал аудитын хорооны гишүүн нь зөвлөлийн шийдвэрээр чөлөөлөгдөнө - удирдах зөвлөлийн гишүүнийг чөлөөлөх нөхцөлтэй адил. Аудитын хорооны гишүүн чөлөөлөгдсөн бол тухайн этгээд чөлөөлөгдсөн тухай мэдэгдэл, шийдвэр хүлээн авснаас хойш өдрийн дотор шүүхэд хандах эрхтэй.
5. Аудитын хорооны дуудсанаар удирдах зөвлөл, МБХ, ХШХ эсвэл Монголбанкны ажилтан хорооны хуралд саналын эрхгүйгээр оролцож болно.
6. Аудитын хороо дараах чиг үүрэгтэй.
 - а. Дотоод аудитын чиг үүрэгт хяналт тавих.
 - б. Хөндлөнгийн аудитыг сонгоход болон үзүүлэх аудитын ба бусад үйлчилгээний хүрээний талаар зөвлөж өгөх.
 - в. Аудитруудтай тэдгээрийн дүгнэлтийн талаар уулзалт хийх.
 - д. Хөндлөнгийн аудртай жилийн эцсийн санхүүгийн тайланг нягтлан үзэх.
7. Аудитын хороо нь удирдах зөвлөлд давтамжтайгаар тайлагнана.
8. Удирдах зөвлөл нь аудитын хорооны дүрэмд тус хорооны бүрэлдэхүүн, бусад чиг үүргийн талаар тусгана.
9. Аудитын хороо дотоод үйл ажиллагааны журмыг тогтооно.

XV. Шүүхээс хууль ёсны дархлаа

1. Монгол улсын шүүхэд үүсгэсэн аливаа хэргийн талаар эцсийн шийдвэр гаргахаас өмнө Монголбанкны эсрэг болон түүний хөрөнгө, алт, тусгай зээлжих эрх, валют, зээл, хадгаламж, үнэт цаас зэрэг аливаа хөрөнгийг барьцаалах, түдгэлзүүлэх зэргийг хязгаарлах гүйцэтгэх ажиллагаа явуулахыг хориглоно.
2. Алт ба зээлжих тусгай эрхээс бусад тохиолдолд Монголбанк нь энэ хуулийн 1-т заасан эрхзүйн хамгааллаас бичгээр тодорхой илэрхийлж, бүхэлд нь болон хэсэгчлэн татгалзах эрхтэй байна.

XVI. Томилгоо

1. Монголбанкны удирдлагыг 6 жилийн хугацаагаар томилох бөгөөд сунгаж болно. Монголбанкны удирдлагын бүрэн эрхийн нийт хугацаа 14 жилээс хэтрэхгүй байна.
2. Улсын Их Хурал нь Монголбанкны удирдлагыг-н санал болгосноор томилно.
3. Монголбанкны удирдлагын сонгон шалгаруулалт, нэр дэвшүүлэлт болон томилгоо нь ил тод бөгөөд энэ хуулийн-т заасан шалгуур үзүүлэлттэй нийцсэн байна. Мөнгөний бодлогын хороо, ХШХ, УЗ-ын бүрэлдэхүүн нь энэ хуульд заасан мэргэжилд тавих шалгуур үзүүлэлтийг хангасан байна.

XVII. Тавигдах шаардлага

1. Монголбанкны удирдлагад ажиллах хүн нь нэр хүндийн хувьд хүлээн зөвшөөрөгдсөн ба эдийн засаг, санхүү, банк, хууль зэрэг салбарын академик болон мэргэжлийн өндөр дадлага, туршлагатай, дээд боловсролын зэрэгтэй байна.

2. Монгол улсын иргэн байна.
3. Дараах этгээд томилогдох шалгуурыг хангахгүй.
 - a. Хорих ялаар шийтгүүлэх гэмт хэрэг үйлдсэн.
 - b. Дампуурал эсвэл төлбөрийн чадваргүйтэй холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаагаар өр төлбөртэй.
 - c. Хувийн зохисгүй үйлдлээс шалтгаалан эрх бүхий байгууллагаас мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхээ хасуулсан, түдгэлзүүлсэн эсвэл төрийн албанд болон хувийн байгууллагад ажиллах эрх нь хориглогдсон.
 - d. Шүүхээс хууль бус үйл ажиллагаа явуулсан эсвэл албан тушаалдаа ноцтой зөрчил, дутагдал, үйлдэл гаргасан гэдгийг тогтоосон.
4. УИХ, засгийн газар, яам, бусад төрийн байгууллагад ажил эрхлэдэггүй байх, Монгол улсад үйл ажиллагаа явуулж байгаа хянан шалгалтанд хамрагдах банкны ажилтан биш байх, банкны хувьцааны 5%-с дээш хувийг эзэмшдэггүй байх.

XVIII. Албан тушаалаас чөлөөлөх үндэслэл

1. Монголбанкны удирдлагыг УИХ-с Сангийн яам, удирдах зөвлөлийн олонхи гишүүдийн санаачлагаар албан тушаалаас чөлөөлнө: энэ хуулийн шалгуур 3, 4 дэх хэсгийг хангахгүй болсон.
2. Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Монголбанкны удирдлагын гишүүнийг хяналтын зөвлөлийн олонхийн саналаар дараах тохиолдолд чөлөөлнө.
 - a. 3 сар болон түүнээс дээш хугацаанд үргэлжилсэн бие махбодь болог оюун санааны эмгэгийн улмаас албан тушаалын чиг үүргээ гүйцэтгэх боломжгүй болсон.
 - b. Зөвлөлөөс зөвшөөрөл авалгүйгээр 3 болон түүнээс дээш дараалласан сарын хугацаанд ажил үүргээ гүйцэтгээгүй
3. Монголбанкны удирдлагыг чөлөөлөхдөө түүний мэдэгдлийг сонсоно. Албан тушаал чөлөөлсөн үндэслэлийг олон нийтэд мэдээллэх бөгөөд тэдгээр нь хуулийн дагуу чөлөөлөгдсөнөөс хойш 15 өдрийн дотор дээд шүүхэд гомдол гаргах эрхтэй.

XLX. Цалин, урамшуулал

1. Монголбанкны удирдлагын цалин, урамшуулал нь мэргэжлийн шаардлага хангасан хүнийг хөлслөхтэй ижил түвшинд байна.
2. Монголбанкны Ерөнхийлөгч, Тэргүүн дэд ерөнхийлөгч, Дэд ерөнхийлөгчийн албан тушаалын цалинг төрийн бусад өндөр албан тушаалтны цалин хангамжийн дунджийг харгалзан үзэж, томилох эрх бүхий этгээд тогтооно. Цалин хөлсний хэмжээг тэдгээрийг томилсон шийдвэр тусгаж, энэ хуулийн зүйлд заасан тайланд нийтлэнэ. Цалин, урамшуулал нь тэдгээрийг албан тушаалын хаших хугацаанд бууруулж болохгүй.
3. МБХ, ХШХ, УЗ-н бусад гишүүний цалин, урамшууллын банк, санхүүгийн байгууллагын удирдах албан тушаалын цалингийн дундаж хэмжээг харгалзан үзэж, томилох эрх бүхий этгээд тогтооно. Цалин хөлсний хэмжээг тэдгээрийг томилсон шийдвэр тусгаж, энэ хуулийн зүйлд заасан тайланд нийтлэнэ. Цалин, урамшуулал нь тэдгээрийг албан тушаалын хаших хугацаанд бууруулж болохгүй.
4. Энэ зүйлд заасан цалин, урамшуулал нь Монголбанкны ашиг, аливаа орлогод үндэслэж болохгүй.

XX. Шүүхийн хяналт

Монголбанканд чиг үүргээ гүйцэтгэсэн Монголбанкны удирдлага, мэргэжилтэн, албан хаагч, төлөөлөгчийн эсрэг үүссэн шүүх, арбитрын маргаан хянан шийдвэрлэх ажиллагаанд дараах нөхцөлийг шаардана.

- a) Шүүх болон арбитр шийдвэр гаргахдаа хариуцагч нь хууль бус үйлдэл гаргасан эсвэл холбогдох хууль, тогтоомж, бодит байдлаар тогтоогдсоноор Үйлдэл гаргасан нь тогтоогдсон.
- b) Монголбанкны удирдлага, ажилтан, төлөөлөгч, эсвэл ажиллаж байсан этгээд нь Монголбанкны нэрийн өмнөөс чиг үүргээ хэрэгжүүлснээс үүсэх хариуцлага, хохиролыг тухайн үйлдэл, эс үйлдэл нь зориуд санаатай эсвэл хайхрамжгүй, үл тоосон байдлаас болоогүй тохиолдолд хариуцахгүй.
- c) Энэ хуульд заасан эрхзүйн хамгаалалт нь хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааны бүх шатанд хамаарна.
- d) Шүүх болон арбитр нь шаардлагатай тохиолдолд зөвхөн хохиролыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлүүлэхээр шийдвэрлэх бөгөөд Монголбанкны хэрэгжүүлсэн үйл ажиллагааг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, зогсоох эрхзүйн үйлчлэлгүй байна.

XXI. Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны зардлаас чөлөөлөх

Тухайн этгээдийн үйл ажиллагаа нь гэмт хэрэг болох нь тогтоогдсоноор бусад тохиолдолд Монголбанкны удирдлага, ажилтан, төлөөлөгчөөс хөдөлмөрийн харилцааны хүрээнд эсвэл энэ хуулийн дагуу үүссэн харилцаатай холбоотойгоор хэрэгжүүлсэн үйл ажиллагаатай холбоотой хууль зүйн зардлыг хариуцна.

XXII. Данс

Монголбанк гадаад валют, алт, санхүүгийн хэрэгсэл бусад активын өөрийн позицоос үүсэх бодит бус ашгийг бүртгэх үүднээс бодит бус нөөцийн үнэлгээний дансыг үүсгэнэ.

XXIII. Өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх

Монголбанкны жилийн санхүүгийн тайлангаар пассив- өр төлбөр болон хувь нийлүүлсэн хөрөнгийн нийлбэр нь активаас хэтэрсэн тохиолдолд дараах арга хэмжээ авна:

- a. Монголбанкны хөндлөнгийн аудитын зөвлөгөөнд үндэслэн Удирдах зөвлөл нь 30 хоногийн дотор нөхцөл байдлыг үнэлж, уг зөрүүгийн хэмжээ, үүссэн шалтгааны талаар бэлтгэнэ. үүний шалтгаан, нөхцөл байдлын талаар тайлан гаргаж үнэлэх
- б. Удирдах зөвлөл уг тайланг баталсан бол Монголбанк нь хувь нийлүүлсэн хөрөнгийг хуульд заасан хэмжээнд хүргэх зорилгоор Төрөөс өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх хүсэлтийг Сангийн яаманд явуулна.
- в. Хүсэлтийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрөөс шаардлагатай хэмжээгээр мөнгөн хөрөнгөөр эсвэл тухайн үеийн зах зээлийн хүүгээр тооцсон тодорхой хугацаатай өрийн хэрэгсэлийг Монголбанкинд шилжүүлнэ.

XXIV. Хөндлөнгийн аудит

1. Монголбанкны данс бүртгэл, санхүүгийн тайлан, жилд нэгээс доошгүй удаа олон улсын аудитын стандартын дагуу хөндлөнгийн нэр хүндтэй олон улсын туршлагатай томоохон санхүүгийн байгууллагаар хийлгэнэ.
2. Удирдах зөвлөл нь хөндлөнгийн аудитыг томилно. Хөндлөнгийн аудит нь нийтдээ 5 жилээс дээшгүй хугацаанд дарааллан томилогдож болохгүй.
3. Санхүүгийн тайлагналын журамтай холбоотой дотоод хяналтын материаллаг сул тал зэргээс үүдэлтэй асуудлаар хөндлөнгийн аудитр нь аудитын хороонд мэдэгдэнэ.
4. Хөндлөнгийн аудит нь Монголбанкны бүх данс, бүртгэлийг шалгах, гүйлгээний талаар мэдээлэл авах бүрэн эрхтэй байна.

XXV. Ашиг, алдагдал, орлогын хуваарилат

1. Монголбанкны нийт ашиг, алдагдлыг олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандартад нийцүүлэн тодорхойлно.
2. Цэвэр ашгийг хуваарилах талаар зохицуулсан энэ хуулийн ... -д заасны дагуу хуваарилагдах орлогыг дараах байдлаар тодорхойлно.
 - a. Цэвэр ашгаас дахин үнэлгээний бодит бус орлогын нийт дүнг хасч, харгалзах дахин үнэлгээний бодит бус нөөцийн дансанд уг хассан дүнг хуваарилснаар.
 - b. Тухайн санхүүгийн жилийн туршид бодит болсон ба өмнөх жилүүдийн нийт ашгаас хассан аливаа бодит бус ашгийн дүнг энэ хэсгийн а-д тодорхойлсон хуваарилах орлого дээр нэмж, зохистой дахин үнэлгээний бодит бус нөөцийн данснаас хассанаар.
3. Алдагдалыг тухайн жилийн ашгаар, ерөнхий нөөцийн данс, зөвшөөрөгдсөн өөрийн хөрөнгийн данс гэсэн дарааллаар нөхсний дараа дахин үнэлгээний бодит бус нөөцийн данс үлдэгдэлгүй болох хүртэл дахин үнэлгээний бодис бус алдагдалыг харгалзах дахин үнэлгээний бодит бус нөөцийн данс руу шилжүүлнэ.

XXVI. Жилийн санхүүгийн тайлан, мэдээ

1. Жил бүрийн санхүүгийн жил дуусгавар болсноос хойш 3 сарын дотор Монголбанк нь удирдах зөвлөлөөс баталж, Монголбанкны Ерөнхийлөгчийн баталгаажуулсан санхүүгийн тайлан болон хөндлөнгийн аудитын дүгнэлтийг Сангийн яам, Улсын Их Хуралд илгээнэ.
2. Бэлэн болсон санхүүгийн тайлан болон аудитын дүгнэлтийг Монголбанк нийтэлнэ.
3. Монголбанк нь товч санхүүгийн тайланг бэлтгэж, улирал тутам нийтэлнэ.
4. Монголбанк дараах сарын эхний ажлын 10 өдрийн дотор өмнөх сарын байдлаар тогтсон хэлбэрээр гаргасан санхүүгийн тайланг бэлтгэж, нийтэлнэ. Уг санхүүгийн тайлангийн хувийг Сангийн яаманд хүргүүлж байна.

XXVII. Хариуцлагатай байдал-Accountability

1. Монголбанк нь жилд хоёроос доошгүй болон шаардлагатай тохиолдолд түүнээс дээш удаа УИХ болон олон нийтэд мөнгөний бодлогын талаарх үйл ажиллагаа, зорилтыг хэрхэн хангасан талаар мэдээлнэ.

2. Монголбанкны Ерөнхийлөгч нь өөрийн санаачилгаар болон УИХ, түүний хорооны шаардснаар мөнгөний бодлого, ханшийн дэглэм, санхүүгийн тогтолцоо болон улсын эдийн засгийн байдлын талаар давтамжтай мэдээлэл хийж байна.

3. Тухайн санхүүгийн жил дуусгавар болсноос хойш 4 сарын дотор, Монголбанк нь өмнөх санхүүгийн жилийн эдийн засгийн байдал, бодлогын зорилт болон санхүүгийн тогтолцооны нөхцөл байдлыг онцолсон тухайн жилийн эдийн засгийн төсөөллийн талаар тайланг Удирдлах зөвлөлийн баталснаар нийтэлж, УИХ, СЯ-д хүргүүлж байна. Тайлан нь Монголбанкаас өмнөх жил баримталсан бодлогын талаарх үнэлгээ, тухайн жилд баримтлах бодлогын тодруулга, тайлбар зэргийг багтаасан агуулгатай байна.

4. Монголбанк нь улирал тутам тухайн жилийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг тусгасан мөнгөний бодлого болон санхүүгийн тогтвортой байдлын тайланг нийтэлнэ.

ТАНИЛЦУУЛГА

Хуулийн зарим зүйлд өөрчлөлт оруулах тухай

Нэг. Өнөөгийн эрх зүй, ажил хэргийн байдал

Монголбанкны Хяналтын зөвлөлийн эрхлэх ажлыг Төв банк(Монголбанк)-ны тухай хуулийн 27¹ дүгээр зүйл, УИХ-ын 2003 оны 39 дүгээр тогтоолоор батлагдсан” Монголбанкны Хяналтын зөвлөлийн ажиллах журам”-д дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:Хяналтын зөвлөл нь . Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын санал, зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын багц болон Монголбанкнаас санхүүгийн тайлан, мэдээллийн байдал, Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавьж ажиллана. Энэхүү үйл ажиллагааг эрхлэхийн тулд Хяналтын зөвлөлд доорх бүрэн эрхийг олгосон байна. Үүнд;

- 1.Хяналтын зөвлөл нь зөвлөлийн хурлаар хэлэлцсэн асуудлын талаар Улсын Их Хуралд мэдээлэл өгнө.
- 2.Монголбанкны удирдлагад тодорхой асуудлын биелэлтийг хангахыг зөвлөсөн шийдвэр гаргана. Хяналтын зөвлөлийн шийдвэрийн хэлбэр нь тогтоол байна.
3. Хяналтын зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилт, тайлбарыг Монголбанкны удирдлага Хяналтын зөвлөлийн хуралд танилцуулна.
4. Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааг тогтоосон журмын дагуу авч хэлэлцэж, дүгнэлт гаргах;
- 5.Монголбанкны дотоод аудитын газрын хянан шалгагч болон тус банкны санхүүгийн тайланд аудит хийсэн байгууллагын аудитортой харилцаж, санал солилцох;
- 6.Монголбанкны дотоод аудитын газрын үйл ажиллагааны тайлан болон Монголбанкны санхүүгийн тайлан, түүнтэй холбоотой бусад мэдээллийг Монголбанкнаас гаргуулан авах;
- 7.Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлаар Монголбанкинд өгсөн санал, зөвлөмжийн хэрэгжилтийн талаар зохих албан тушаалтны илтгэл, сонсголыг Хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцэх;
8. Хөндлөнгийн аудиторын Монголбанкны үйл ажиллагааны талаарх дүгнэлт, зөвлөмжийн талаар тайлбар, саналыг сонсох;
- 9..Монголбанкны дотоод аудитын газрын хянан шалгагчтай харилцаж, дотоод хяналттай холбогдсон асуудлаар санал солилцох;
- 10.Шаардлагатай гэж үзвэл Монголбанкны үйл ажиллагаа, менежментийн аливаа асуудал, тодорхой гүйлгээнд шалгалт, аудит хийлгэх санал гаргах;
10. Өөрийн бүрэн эрхэд хамаарах асуудлын талаар Улсын Их Хуралд мэдээлэх;
- 11.Хяналтын зөвлөлийн хурлаар хэлэлцсэн аливаа асуудлын биелэлтийг хангаж ажиллахыг Монголбанкны удирдлагад зөвлөх;
12. Монголбанкны дотоод хяналт, санхүүгийн тайлан гаргах эрх зүйн орчныг боловсронгуй болгох талаар санал гаргах;

ХЗ-ийн гишүүдийн бүрэх эрхээс дурдвал:

- 1.Хяналтын зөвлөлийн шийдвэрийн биелэлтэд хуваарийн дагуу хяналт тавих,
2. Хяналтын зөвлөлийн хуралд асуудал оруулж хэлэлцүүлэх;
3. Хяналтын зөвлөлийн чиг үүрэгт хамаарах тодорхой асуудлыг хариуцан ажиллаж, гүйцэтгэл, үр дүнгийн талаар Хяналтын зөвлөлийн хуралд мэдээлэх;
4. Хяналтын зөвлөлийн шийдвэрийн дагуу Монголбанкны Зөвлөлийн болон Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаатай танилцах;

5. Хяналтын зөвлөлийн шийдвэрийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг Хяналтын зөвлөлийн хуралд мэдээлэх;

6. Хяналтын зөвлөлийн чиг үүрэгт холбогдох асуудлаар Монголбанкнаас баримт материал гаргуулан авах.

Хяналтын зөвлөл нь дээр дурдсан ажил үүргийг голчлон гүйцэтгэж байгаа бөгөөд тус зөвлөл нь Монголбанкны холбогдох газар хэлтсүүдийн талаарх мэдээлэл авч түүнд нь хөндлөнгийн дүгнэлт өгөх, цаашид анхаарах зүйлүүдийг авч хэлэлцдэх зэргээр явагдаж байна. Чингэхдээ дотоод аудитын үйл ажиллагаа, санхүүгийн тайлагнал, хөндлөнгийн аудитын дүгнэлт, гадаад валютын болон бусад нөөцийн удирдлага, засаглалын болон үйл ажиллагааны эрсдэл зэрэгт илүүтэй анхаарч байна.

Хоёр. Зарим сорил, шийдлийн хувилбар

Өнөөгийн хууль тогтоомжоор зарим зүйл зохицуулагдаагүй байгаа юм. Монголбанк өөрөө арилжааны банкуудтай хэрхэн ажиллаж тэнд хийгдэж буй ажил нь орчин цагийн шаардлага, зохих журмын дагуу явагдаж буй эсэх хийгээд Монголбанкны дэргэд шинээр байгуулагдсан Хяналт шалгалтын хорооны үйл ажиллагааны үр дүнг авч хэлэлцэх зэрэг эрх хэмжээ Хяналтын Зөвлөлд өгөгдөөгүй байгаа юм. Монголын улсын санхүүгийн тогтолцооны үндсэн цөм, хадгаламж эзэмшигчид, аж ахуй эрхлэгчдийн итгэл найдвар болсон арилжааны байкуудыг Монголбанк зөв удирдах нь нийгмийн шаардлага, хүлээлт билээ. Тиймээс Хяналтын зөвлөл нь Монголбанкны үйл ажиллагаа, түүний дотор арилжааны банкуудыг удирдах чадварт хөндлөнгийн дүгнэлт өгч байх чухал юм.

- Монголбанкны хуульд Хяналтын зөвлөл нь Монголбанкны захирлуудын зөвлөлийн үйл ажиллагааны ажлын үр дүнд санал дүгнэлт өгнө гэж байгаа боловч түүгээр дамжуулан Хяналт шалгалтын хорооны ажил хэр зэрэг явагдаж байна гэдэгт дүгнэлт өгөх боломжгүй нь Хяналтын Зөвлөлийн ажлын явцаас харагдаж байна. Учир нь хууль зүйн талаасаа уг асуудал шийдэгдээгүй байна. Монголбанкны хараанд байдаг Хяналтын хороо нь Монголбанкны зүгээс зөвшөөрөл авч ажилладаг арилжааны банк болон бусад санхүүгийн системд дүгнэлт өгдөг нь тодорхой хэмжээний болгоомжлол төрүүлж байдаг байна. Иймээс зохих эрхийг Хяналтын зөвлөлд хуулиар олгох нь зүйтэй гэж үзэж, Монголбанкны тухай хуульд “Зөвлөлийн ажиллагааны үр дүнд хяналт хийж, үнэлгээ өгнө” гэдгийг Хяналт шалгалтын Хороонд хамруулах хуулийн заалт нэмэхээр хуулийн төсөлд тусгав
- Мөнгөний бодлогын хэрэгжилтийн асуудал байна. Энд мөнгөний бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэх асуудалд Хяналтын зөвлөл оролцдоггүй, үүнийг олон улсын практик, манай хууль баталж байгаа. Гагцхүү мөнгөний бодлогын хэрэгжилтийг хангадаг хэрэгслүүдийн ашиглалт, түүний үр дүнг зохих ёсоор авч үзэх ёстой. Өдгөө бид Монголбанкны удирдлага, зохих газар хэлтсүүдтэй тохиролцсоны дагуу мөнгөний бодлогыг голчлон хэрэгжүүлж байгаа газар хэлтсүүдийн үйл ажиллагааны үр дүнд дүгнэлт өгч байгаа. Тодруулбал, хуулиар олгогдсон хөрөнгө оруулалтын багцийг хянах эрхийн хүрээнд Монголбанкны нийт хөрөнгө, нөөц, эх үүсвэрийн ашиглалт, удирдлагын талаар мэдээлэл сонсгол авч, зөвлөмж чиглэл өгөх ажиллаж байгаа. Гэхдээ үүнийг эрх зүйн хувьд нь шийдэх шаардлагатай. Ийм учраас зөвхөн Хяналт шалгалтын хороо гэлтгүй Мөнгөний бодлогын хорооны үйл ажиллагааны үр дүн, шийдвэрийн хэрэгжилтийн байдалд санал дүгнэлт өгч байх нь зүйтэй болов уу гэж бодож байна. Мөн Хяналтын Зөвлөлийн эрхлэх ажлын хүрээнд Монголбанкны хөрөнгийн удирдлага, ашиглалтад хяналт тавих гэдгийг хуульчлахаар санал боловсруулав.
- Хяналтын зөвлөлийн эрх хэмжээнд хуулиар олгогдоогүй, гэхдээ нийгэм, олон нийтээс, УИХ зэрэг удирдах байгууллагын хүрээнд асуугдаж яригддаг зүйл бол мөнгө угаах,

терроризмтай тэмцэх талаар хийж буй ажилд хөндлөнгийн хяналт, дүн шинжилгээ өгөх явдал байгаа юм. Энэ ажиллагааны үр дүнг авч үзэх гэж бид хэд хэдэн удаа оролдсон боловч эрх хэмжээ хүрэлцэхгүй байгаа учраас үүнийг цаашид яах вэ гэдэг асуудал тулгараад байгаа юм. Тэгэхээр нэгэнт Монголбанкны дэргэд Санхүүгийн мэдээллийн алба ажиллаж байгаа учраас энэ албаны ажлын үр дүнг ямар байгаад санал дүгнэлт өгдөг, тэдний мэдээллийг сонсдог болох нь зүйтэй байгаа юм. Ийм чиглэлээр хуулийн төсөлд санал оруулж байгаа.

- Олон улсын байгууллагууд, ОУВС болон бусад гадаадын байгууллага, судлаачдын өгсөн санал зөвлөмжийн дагуу зарим зүйлд онцгойлон анхаарах шаардлагатай гэж үзэж байгаа. Монголбанкны Хяналтын Зөвлөлийн дарга, гишүүдтэй ОУВС-ын холбогдох ажлын хэсэг, олон улсын зөвлөх судлаачид уулзаж, өгсөн зөвлөлгөөн өгдөг. Эдгээрээс үзэхэд төв банкны засаглал, эрх үүргийн нэгдлийг хэрхэн хангах, хяналт шалгалт, дотоод аудит, эрсдэл, хуулийн нийцэл, Хяналтын Зөвлөлийн эрх хэмжээ, түүний шийдвэрийг хэрэгжүүлэх арга зам, ямар асуудлаар Хяналтын зөвлөл давуу эрхтэй байх зэрэг олон асуудлуудыг харж болно. Тэхдээ Монголынхоо нөхцөлд тохирсон цөөхөн асуудлыг шийдэх санал оруулж байгаа болно. , ,
- Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагааг илүүтэй Хяналтын зөвлөлийн эрхлэх ажиллагааны хүрээтэй хамтад нь хийх. Тухайлбал Хяналтын зөвлөл нь Дотоод аудитын газрын захирлыг нь томилж бас халах эрхтэй. Ерөнхийлөгч бол санал оруулах эрхтэй. Мөн дотоод аудитын үйл ажиллагааны төлөвлөгөө батлах, хийх ажлын жагсаалтыг Хяналтын зөвлөл гаргаж байх ёстой. Өөрөөр хэлбэл Дотоод аудит нь Хяналтын зөвлөлийн шууд удирдлагад ажиллах, гэхдээ орон тоо цалин, бусад асуудлыг Монголбанкны хүрээнд шийдвэрлэж явдаг байх. Төв банкны хууль, Хяналтын зөвлөлийн ажиллах журамд дээр дурдсан санааг тусган, ХЗ-ийн эрх хэмжээг сайжруулах боломж бий гэж үзэж байна.
- Хяналтын зөвлөлөөс хийх шалгалт, Дотоод аудитын газраар дамжуулж хийх шалгалтын нэр төрлийг урьдчилан баталж гаргаж байвал ийм шалгалт хийгдэх нь байна гэдэг зүйлийг Монголбанкны дээд удирдлага, газар хэлтсүүд мэдэж байх нь хөндлөнгийн хяналтын нэгэн хэлбэр юм. Тийм учраас хийх ажлын жагсаалтыг зайлшгүй гаргаж байх нь зүйтэй юм.
- Өөр нэг яригддаг зүйл бол Монголбанкны гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, шийдвэрт хөндлөнгийн хяналт тавих, Монголбанкны нийт ажиллагааг бүх төрлийн эрсдлээс урьдчилан сэргийлэх ажлын байдалд бие даасан дүгнэлт гаргах явдал байгаа юм. Үүнийг Монголбанкны дотоод хяналтын нэгжийн бие даасан байдлыг хангах, чадавхийг бэхжүүлэх замаар шийдэж болох гэсэн үндэслэлээр Монголбанкны тухай хууль, УИХ-аас баталсан Хяналтын зөвлөлийн ажиллах журамд зарим санааг оруулсан.
- Хууль, журмыг өөрчлөн шинэчлэх хуулийн төслийн гол үзэл баримтлал бол Монголбанкны бүх үйл ажиллагаа нийтдээ нэг цогц бөгөөд түүнд тавих хөндлөгийн хяналт зайлшгүй шаардлагатай нөхцөлд эрсдэлд орж болох аливаа зүйлээс сэргийлэхэд туслах ёстой гэж үзэж байна. Үүний цаана Монголбанкны захирлуудын зөвлөл, гүйцэтгэх удирдлага нь Хяналт шалгалтын хороо зэрэг хамтын удирдлагын бие даасан нэгж нэгж байгуулагдсан гэдгээр аливаа харнуцлагыг сулруулж болохгүй гэдгийг тэмдэглэж байна. Мөн аливаа улс орны төв банкны гүйцэтгэх удирдлага зарим асуудлаар мэргэжлийн түвшинд бие даасан шийдвэрийг түргэн шуурхай гаргаж байх ёстой.
- Монголбанкны Ерөнхийлөгч болон гүйцэтгэх удирдлагаас улс орны санхүү, эдийн засаг, Монголбанкны өөрийнх нь үйл ажиллагаанд нөлөө үзүүлж болох аливаа шийдвэр, түүний дотор нууцлалтай шийдвэрийг Монголбанкны хяналтын Зөвлөл,

- түүний даргад ажлын өдөрт нь багтаан хүргүүлж байна гэсэн санааг УИХ-аас баталдаг ХЗ-ийн ажиллах журамд тодотгон оруулж болох юм.

Эхний ээлжинд Монголбанкны хуулийн холбогдох заалтыг хэрхэн өөрчлөх санал оруулж байгааг доор харьцуулан үзүүлье.

Өнөөдөгийн хуулийн заалт	Хуульд оруулах нэмэлт өөрчлөлт	Товч тайлбар
27 1 дүгээр зүйл. Монголбанкны Хяналтын зөвлөл 1. Монголбанкны дотоод хяналтын үйл ажиллагаа, хөндлөнгийн аудитын санал, зөвлөмжийн хэрэгжилт, хөрөнгө оруулалтын багц болон Монголбанкнаас санхүүгийн тайлангаа Улсын Их Хурал, олон нийтэд тайлагнаж, мэдээлж байгаа байдал, Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааны үр дүнд хяналт тавих эрх бүхий орон тооны бус Хяналтын зөвлөл ажиллана. Хяналтын зөвлөлийн ажиллах журмыг Улсын Их Хурал тогтооно. 2. Хяналтын зөвлөл нь төрийн мөнгөний бодлоготой холбоотой	“Хөрөнгө оруулалтын багц” гэсний өмнө “хөрөнгө,” “Монголбанкны ” гэсний дараа буюу “Зөвлөлийн” гэсний өмнө “Мөнгөний бодлогын хороо, Банкны хяналт шалгалтын хорооны болон” гэж нэмсүгэй.	Хяналтын зөвлөлийн үндсэн үйл ажиллагааны хүрээнд Монголбанкны хөрөнгийн удирдлага, ашиглалт хийгээд Монголбанкны тухай хуульд 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар байгуулагдсан Мөнгөний бодлогын хороо, Банкны хяналт шалгалтын хорооны үйл ажиллагааны үр дүнд хяналт эрх зүйн үндэс тавигдаж байгаа юм. .
9. Хяналтын зөвлөл нь энэ хуулийн 271 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийг дараахь хүрээнд хэрэгжүүлнэ: 1/ Монголбанкны Зөвлөлийн үйл ажиллагааг тогтоосон журмын дагуу авч хэлэлцэх; 2/ Монголбанкны дотоод аудитын газрын хянан шалгагч болон тус банкны санхүүгийн тайланд аудит хийсэн байгууллагын аудитортой харилцаж, санал солилцох; 3/ шаардлагатай гэж үзвэл Монголбанкны үйл ажиллагаа, менежментийн	1/ “Монголбанкны Мөнгөний бодлогын хороо, Банкны хяналт шалгалтын хороо болон Зөвлөлийн үйл ажиллагааг тогтоосон журмын дагуу авч хэлэлцэх” гэж өөрчилсүгэй. 2/ Монголбанкны дотоод аудитын газрын дүрэм, ажлын төлөвлөгөө, төсөвтэй танилцаж, эцэслэн батламжлах, тус газрын дарга, хянан шалгагч болон тус банкны санхүүгийн тайланд аудит хийсэн байгууллагын аудитортой тус, тус харилцаж, аудитын	Энэхүү хоёр хорооны үйл ажиллагааны үр дүнг УИХ-ын 2003 оны 39 дүгээр тогтоолоор баталсан Монголбанкны Хяналтын Зөвлөлийн ажиллах журмын дагуу авч хэлэлцэж байх юм. Уг журамд орох нэмэлт өөрчлөлтийн төслийг хамт танилцуулж байгаа болно. 3 дахь заалтын хувьд Монголбанкны дэргэдэх, харьяалах байгууллагын тоонд Монгол Улсын мөнгө угаах, терроризмтэй тэмцэх

аливаа асуудал, тодорхой гүйлгээнд шалгалт, аудит хийлгэх санал гаргах;	материал, тайлан авч санал солилцох, чиглэл өгөх 3/ шаардлагатай гэж үзвэл Монголбанкны болон түүний дэргэдэх, харьяалах байгууллагын үйл ажиллагаа, менежментийн аливаа асуудал, тодорхой гүйлгээнд шалгалт, аудит, хөндлөнгийн дүгнэлт хийлгэх санал гаргах, мэдээлэл лавлагаа авах	хуульд заасан Монголбанкны дэргэдэх Санхүүгийн мэдээллийн алба, харьяалах гэдгийн хувьд дампуурсан банканд томилогдсон Монголбанкны бүрэн эрх төлөөлөгчийн үйл ажиллагааны талаар мэдээ, лавлагаа авах, шаардлагатай гэж үзвэл шалгалт оруулах санал тавих боломжийг Хяналтын Зөвлөлд нээж буй хэрэг юм.
---	--	--

Монголбанкны хуулийн Хяналтын зөвлөлтэй холбоотой хэсэгт оруулах өөрчлөлтийн тухай хуулийн төслийг боловсруулж хавсаргав. Нэмэлтийг улаан өнгөөр тодотгов.

Хяналтын Зөвлөл 2021 оны 10 сар

Монголбанкны Хяналтын зөвлөл хуралдлаа

Огноо: 2022/04/21

2022 оны 4 сарын 06

Монголбанкны Хяналтын зөвлөл (МБХЗ)-ийн ээлжит хурал 2022 оны 4 дүгээр сарын 6-ны өдөр цахимаар боллоо. Хурлаар Монголбанкны Дотоод аудитын газрын 2021 оны тайлан, Удирдлага төлөвлөлтийн газрын Хэвлэл мэдээллийн албанаас төв банкны олон нийттэй харилцах харилцааны талаарх мэдээлэл, “Төв банкны Засаглалын өнөөгийн байдал ба олон улсын туршлага” сэдэвт судалгааны ажил, Унгар улсын төв банкны зарим туршлагын тухай болон МБХЗ-ийн 2021 оны тайлан зэргийг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргав.

Монголбанкны Дотоод аудитын газар (ДАГ) 2021 онд Монголбанкны төв болон орон нутгийн бүтцийн нэгжүүдэд бүрэн аудит шалгалт 10, хэсэгчилсэн шалгалт 7-г хийж, тодорхой асуудлуудаар 10 удаа ажлын хэсэгт орж ажиллажээ. Монголбанканд дээр ажилласан хөндлөнгийн аудитын байгууллага, гадаадын зөвлөхтэй ДАГ хамтран ажиллаж, Монголбанкны 2020 оны санхүүгийн тайланг баталгаажуулах, эрсдэлд суурилсан шалгалт шинжилгээг явуулах, өөрийн үйл ажиллагааг олон улсын аудитын стандартын дагуу үнэлүүлэх зэрэг ажлыг зохион байгуулжээ. МБХЗ-өөс цаашид Монголбанкны алдагдлыг багасгах, эрсдэлтэй актив, үнэт цаасыг Монголбанк худалдан авахаас сэргийлэх зэрэг ажилд онцгой анхаарч ажиллахыг ДАГ-т зөвлөв. Мөн Хяналтын зөвлөлөөс дотоод аудитын чиглэлээр өмнө гаргасан шийдвэрийн биелэлт, гадаадын зөвлөхийн өгсөн санал, зөвлөмжийн хэрэгжилтийн байдлыг энэ оны 3 дугаар улиралд МБХЗ-ийн хурлаар дахин хэлэлцэх, чингэхдээ дотоод аудитын бие даан ажиллах эрх зүйн орчин, боловсон хүчний чадавхийг бэхжүүлэх зэрэг ажлын бодит үр дүнд илүү ач холбогдол өгч бэлтгэл хангахыг онцлон тэмдэглэв.

Монголбанкны тухай хуулийн 34 дүгээр зүйл (Монголбанкны мэдээлэл)-ийн үзэл санааг үндэс болгон Монголбанкны олон нийттэй харилцааг олон улсын сайн жишигт хүргэх үүднээс Монголбанк удирдлага, төлөвлөлтийн газар дотроо Хэвлэл мэдээллийн албыг 2021 онд байгуулсан байна. Төв банкны олон нийттэй харилцах харилцааг олон улсын сайн жишигт нийцүүлж, эдийн засагт оролцогчид, нийгэмд төв банкны бодлого, үйл ажиллагааны талаар бодит мэдээллийг түгээн, ил тод байдлыг хангах замаар төв банканд итгэх итгэл, бодлогын үр нөлөөг дээшлүүлж зөв дохио өгнө гэдэгт найдаж буйгаа МБХЗ-ийн гишүүд тодотгон ярилаа. Зах зээлд оролцогчдын итгэл үнэмшил, хүлээлт нь үнэ, валютын ханшид чухал нөлөөтэй тул удирдах ажилтнууд, төрийн түшээд нийгэмд цочрол үүсэх мэдэгдэл мэдээлэл өгөхгүй байх тухай Базель дахь төв банкуудын холбооны шийдвэр, зөвлөмжийг Монголбанк хэрхэн мөрдүүлж буй хийгээд манай хууль тогтоомжид энэ талаар ямар заалт байдгийг тодруулж, танилцуулахыг Монголбанкны холбогдох ажилтнуудад хүсэлт болгов.

“Төв банкны засаглалын өнөөгийн байдал, олон улсын туршлага” судалгааны ажил дуусч буйтай холбогдуулан Хяналтын зөвлөлөөс зарим саналыг танилцуулж, судалгааны эцсийн дүгнэлтийг ойрын хугацаанд эцэслэн дуусгахыг судлаач Д.Ганбаярт даалгав.

Эцэст нь Хяналтын зөвлөлийн үйл ажиллагааны 2021 оны тайлангийн төслийг хэлэлцэн ХЗ-ийн гишүүдийн гаргасан зарим саналыг тусган албажуулаад УИХ-ын Эдийн засгийн Байнгын хороонд хүргэх нь зүйтэй гэж тогтов.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

Монголбанкны хяналтын зөвлөлийн мэдээлэл

Огноо: 2022/09/21

Монголбанкны Хяналтын зөвлөл (МБХЗ)-ийн ээлжит хурал 2022 оны 9 сарын 16, 21-ний өдрүүдэд боллоо. Хурлаар Монголбанкны Эрсдэлийн удирдлагын албаны ажлын тайлан, эрсдэлийн удирдлагын хэрэгжилт, гадаад валютын улсын нөөцийн удирдлага, төгрөг юанийн своп хэлцэл болон Монголбанкны дунд, урт хугацааны зээллэгийн үр дүнгийн байдалд хийсэн хяналт, дүгнэлтийн талаарх мэдээллийг хэлэлцэв. Мөн ОУВС-ийн шинжээчидтэй Хяналтын зөвлөлийн хийсэн уулзалтын талаар мэдээлэл сонсож, харилцан санал солилцлоо.

Хяналтын зөвлөлөөс Монголбанкны Эрсдэлийн удирдлагын албаны үйл ажиллагааны хамрах хүрээ, чиг үүрэг, тус албанаас хүргүүлж буй зөвлөмжийн хэрэгжилт, Дотоод аудитын газар хоорондын ажлын уялдаа, дотоод аудит болон эрсдэлийн удирдлагын үйл ажиллагааны олон улсын сайн жишигтэй холбоотой зөвлөмжүүдийг өгөв. Мөн ГВУН-ийн бүтцийг тогтоох давтамж, нөөцийн эрсдэлийн удирдлага, үйл ажиллагааны эрсдэл, алтны арилжаа, алт цэвэршүүлэлтийн үр ашигтай холбоотой зөвлөмжүүдийг мөн өгч, санал солилцож цаашид хамтран ажиллахаар тохирлоо.

Түүнчлэн, гадаад валютын улсын нөөц, хөрөнгө оруулалтын багц, Монголбанкны дунд, урт хугацааны зээллэгийн үр дүн зэрэгтэй танилцав. Тус мэдээлэлтэй холбогдуулан валютын нөөцийн удирдлагыг цаашид сайжруулах арга замын талаар хэлэлцэж, зах зээл, хууль эрх зүй, эрсдэлд суурилсан зарчмууд, хөрөнгө оруулалтын багцын удирдлагын явцын хяналт, Монголбанкны активын үнэлгээ, актив удирдлагын шийдвэр гаргалтын талаар зөвлөмжүүдийг өглөө.

Монголбанкны Хяналтын зөвлөл нь ОУВС-ийн шинжээчидтэй 2022 оны 8 дугаар сард уулзалт зохион байгуулсан. Тус уулзалтын мэдээллийг сонсож, гишүүд харилцан санал солилцлоо. ОУВС-аас гишүүн орнуудын төв банкны хяналт болон засаглалын байдалд дүгнэлт өгдөг (ЕЛРИК/ELRIC) бөгөөд энэ дүгнэлтийг 2022 оны 8 дугаар сарын 22-оос 9 дүгээр сарын 1-ний өдрүүдэд хийсэн байна. Үүний хүрээнд хөндлөнгийн аудитын механизм, төв банкны хуулиар тогтоосон бүтэц ба бүрэн эрхт байдал, санхүүгийн тайлагналын хүрээ, дотоод аудитын механизм, дотоод хяналтын тогтолцоог хамруулан авч үздэг байна. Хяналтын зөвлөлийн гишүүд ОУВС-ийн зүгээс зарчмын шинжтэй үйл ажиллагаа, гол сорилтууд, тэдгээрийг засаж сайжруулах талаар өгсөн зөвлөмжүүдийн талаар санал солилцлоо.

ОУВС-аас Хяналтын зөвлөлтэй холбоотой дараах зөвлөмжийг өгсөн байна. Тухайлбал: *“Монголбанкны Хяналтын зөвлөл нь Монголбанкны гүйцэтгэх зөвлөл болон удирдлагаас хараат бусаар ажиллах чадвартай гишүүдээс бүрдсэн, банкны удирдлагын бүтэцтэй харьцах тодорхой суваг бүхий ажлын албатай, түүгээр дамжуулан бие даасан, дотоод аудит, дотоод хяналтыг хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, энэ үндсэнд Монголбанкны засаглалын тэнцвэрт байдал болон хараат бус байдлыг бэхжүүлэх”* шаардлагатай гэснийг Хяналтын зөвлөл анхааралдаа авч, Монголбанкнаас тэдгээрийг хэрэгжүүлэхэд нь өөрт хамааралтай асуудлаар хувь нэмрээ оруулж, хамтран ажиллах нь зүйтэй гэж үзэв.

МОНГОЛБАНКНЫ ХЯНАЛТЫН ЗӨВЛӨЛ

Огноо: 2022/12/02

Монголбанкны Хяналтын зөвлөл (МБХЗ)-ийн ээлжит хурал боллоо. Хурлаар Монголбанкны Дотоод аудитын газрын 3 улирлын тайлан, түүний үйл ажиллагааг боловсронгуй болгох олон улсын төсөл, Аудитын чанарын баталгаажуулалт сайжруулалтын хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах дунд хугацааны төлөвлөгөөний явцыг хэлэлцлээ. Мөн Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаар олон улсын байгууллагуудаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, Монголбанкны Хяналт шалгалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн үйл ажиллагаа, Монголбанкны активын бүтэц, түүний төрөл, актив хөрөнгийн талаар болон Монголбанкны Хяналтын зөвлөлөөс гаргасан санал зөвлөмжүүд, тэдгээрийн биелэлт, явцын талаарх мэдээлэл сонсож, харилцан санал солилцов.

Монголбанкны Дотоод аудитын газарт хэрэгжээд дуусаж буй олон улсын төслийн хүрээнд аудитын үйл ажиллагааг олон улсын хандлага, өнөөгийн шаардлагад нийцүүлэх талаар хэд хэдэн чухал алхмууд хийгдсэнийг МБХЗ анхааралдаа авч тэдгээрийн хэрэгжилтийг хангахад анхаарч ажиллахаар тохиров. Эрсдэлийг урьдчилан тооцох, үнэлэх, улмаар түүнд суурилж аудит явуулах, мэдээллийн технологийн аудитыг нэвтрүүлэх, зөрчил дутагдалд шинжилгээ хийж, арилгах арга замыг тогтоож байх, Монголбанкнаас аливаа хууль, эрх зүйн ажилд оролцохоос эхлээд нийт ажлын дотоод үйл явцын мөрдөлтийн байдлыг тогтоох тухай ОУВС-ийн шаардлага, тайлан мэдээллийг агуулга талаас нь боловсруулах шинэ загвар, дотоод аудитын шинэчилсэн дүрэм, гадаадын зөвлөхийн санал зөвлөмж зэрэг ажлын сайн эхлэлүүдийг ажил хэрэг болгох зорилт тулгарч байна. Эдгээр ажлын үр дүн эцсийн дүндээ Дотоод аудитын газрын хараат бус, бие даасан байдал, ажлын чанараас хамаарах болно гэдгийг МБХЗ цохон тэмдэглэв.

Монголбанкны Хяналт шалгалтын газрын Мөнгө угаахтай тэмцэх хэлтсийн ажлын мэдээллийг сонсож, олон улсын ээдрээтэй нөхцөл байдалд нийцүүлэн олон улсын төлбөр тооцоог саадгүй, эрх зүй, олон улсын хэм хэмжээнд явуулахад онцгой анхаарч, арилжааны банкуудаас шинэ зах зээл, найдвартай харилцагчдыг олж хамтран ажиллахад нь дэмжлэг үзүүлж байхыг МБХЗ-ийн гишүүд зөвлөв.

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх ажлын хувьд энэ ажлын чиглэл, зөвлөмжийг олон улсын хэмжээнд гаргадаг ФАТФ-аас авсан нааштай үнэлгээг ахиулах, Монголбанкны Санхүүгийн мэдээллийн алба бие даасан, орон тооны мэргэжлийн байгууллагын хувьд салбар, байгууллага хоорондын уялдааг хангах, ажлын явцыг Үндэсний зөвлөл, түүний бүрэлдэхүүн байгууллагуудад тогтмол мэдээлж, тэдний дэмжлэгийг авах, эрх зүйн болон бодлогын зарим баримт бичгийг эцэслэн батлуулах ажлыг түргэтгэх, олон улсын шинэ нөхцөлд үүсч болох эрсдэлийг урьдчилан тодорхойлох зэрэг ажлууд хийгдэж байгааг анхааралдаа авлаа.

Монголбанкны активын хөрөнгийн зарцуулалт, байршлын талаарх мэдээлэлтэй МБХЗ-ийн гишүүд танилцаад, актив хөрөнгө, зээлийн ашиглалт, үр өгөөжийг дээшлүүлж ажиллах зөвлөмж өглөө. Ялангуяа дотоодын үнэт цаасаарх хөрөнгө оруулалт, зарим авлагуудын эргэн төлөлтөд илүүтэй анхаарахыг сануулав.

Мөн Монголбанкны Дотоод аудитын газраас Монголбанкны Хяналтын зөвлөлөөс гаргасан санал зөвлөмжүүд, тэдгээрийн биелэлт, явцын талаарх мэдээллийг нэгтгэн танилцуулсан. Монголбанкны Хяналтын зөвлөл нь 2017-2022 оны хооронд Монголбанкны удирдлага болон холбогдох газар, нэгжүүдийн удирдлагуудад 10 удаагийн тогтоолоор нийт 31 санал, зөвлөмж, 6 удаагийн хурлын тэмдэглэл, мэдээгээр нийт 13 санал, зөвлөмж, 3 удаагийн албан бичгээр нийт 6 санал, зөвлөмжийг нийт 50 заалт бүхий санал, зөвлөмжийг хүргүүлсэн байна. Хэрэгжилтийн түвшин өндөр гарсан хэдий ч хэрэгжилт дутуу зарим зөвлөмжийг МБХЗ дахин авч үзэхээр шийдвэрлэв.

Огноо: 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдөр

Хуудасны тоо: 4

1. Баримт бичгийн төрөл: Зөвлөмжийн хэрэгжилт

2. Товч утга: Хяналтын зөвлөлөөс Монголбанкны 2017-2021 оны аудитлагдсан санхүүгийн тайланд өгсөн зөвлөмжийн биелэлт

3. Хянасан:

ДАГ-ын захирлын үүрэг гүйцэтгэгч

А.Шижирмаа

ДАГ-ын ДХХ-ийн захирал

Г.Ганбаяр

4. Боловсруулсан:

ДХХ-ийн хянан шалгагч

П.Оюунбилэг

**Хяналтын зөвлөлөөс Монголбанкны 2017-2021 оны аудитлагдсан
санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн хэрэгжилт**

Хяналтын зөвлөлөөс Монголбанкны 2017-2021 оны аудитлагдсан санхүүгийн тайлантай холбоотойгоор давхардсан тоогоор 14, нийт 9 зөвлөмж өгсөн байна. Зөвлөмжийн биелэлтийг доорх хүснэгтэд дэлгэрэнгүй харуулав. Үүнд:

№	Зөвлөмж	Биелэлт
2017 оны санхүүгийн тайланд өгсөн зөвлөмж		
1.	Банкны санхүүгийн байдлыг тогтворжуулах, ялангуяа зээлийн хүүгийн зардлыг багасгах, дүрмийн сан, өөрийн хөрөнгийн дутагдлыг нөхөх, өр төлбөрийг барагдуулах, хуримтлагдсан алдагдлыг нөхөх болон хүний нөөц, мэдээллийн технологи бусад бүх асуудлыг багтаасан дунд болон урт хугацааны хөтөлбөрийг боловсруулж хэрэгжүүлэх нь зүйтэй. (2018 онд дахин өгөгдсөн)	Биелсэн. Монголбанк нь тус зөвлөмжийн хүрээнд 2017 оноос хойш дараах дунд болон урт хугацааны хөтөлбөрүүдийг боловсруулан батлуулж, хэрэгжүүлж ажилласан. Үүнд: - “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг холбогдох байгууллагуудтай хамтран боловсруулж, Санхүүгийн тогтвортой байдлын зөвлөлөөр хэлэлцүүлэн, Засгийн газрын 2017 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн 299 дүгээр тогтоолоор батлуулсан. - Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2018 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн А-58/51/134 дүгээр хамтарсан тушаалаар “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2018 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, хэрэгжүүлж ажилласан. - Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны дарга, Сангийн сайд, Хадгаламжийн даатгалын корпорацийн гүйцэтгэх захирлын 2019 оны 04 дүгээр сарын 19-ний өдрийн А-107/290/88/14 дүгээр хамтарсан тушаалаар “Монгол Улсын санхүүгийн зах зээлийг 2025 он хүртэл хөгжүүлэх үндэсний хөтөлбөрийн 2019-2020 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-г батлан, хэрэгжүүлж ажилласан. - Монголбанк, Сангийн яам, Санхүүгийн зохицуулах хороо, Хадгаламжийн даатгалын корпораци хамтран “Зээлийн хүүг бууруулах стратеги 2018-2023”-г батлан хэрэгжүүлж ажилласан. “Зээлийн хүүг бууруулах стратеги батлах тухай” 21 дүгээр тогтоолоор зээлийн хүүг 2019 оны суурь

		түвшнээс дөрвөн нэгж хувиар бууруулж, 2023 оны эцэст сарын нэг хувьд хүргэх зорилтыг тавьсан. - Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн А-10 дугаар тушаалаар Монголбанкны үйл ажиллагааны шинэчлэлийн дунд хугацааны /2017-2019/ хөтөлбөрийг баталсан. Тус хөтөлбөр нь стратегийн хувьд (i) хууль, эрх зүйн орчинг сайжруулах, (ii) засаглал, бүтэц зохион байгуулалтыг шинэчлэх, (iii) хүний нөөцийн удирдлага, хөгжлийг боловсронгуй болгох, (iv) дэвшилтэт технологи, арга ажиллагааг нэвтрүүлэх, (v) хамтын ажиллагааг бэхжүүлэх гэсэн үндсэн 5 чиглэлд тулгуурлан чиглэл тус бүрээр хэрэгжүүлэх үйл ажиллагааг баталж, амжилттай хэрэгжүүлсэн.
2.	Төв банкны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4-т “Актив, пассивыг дахин үнэлэхэд гарсан үнэлгээний цэвэр зөрүүг Монголбанкны цэвэр орлогын тооцоонд хамааруулахгүй” гэсэн заалт байгаа. Энэ заалтыг Монголбанкны тайлан бүртгэлийн газраас “...энэ заалт нь санхүүгийн тайлан гаргахад мөрдөгдөхгүй, Монголбанкны цэвэр орлогын хувиарлалтад мөрдөгднө” гэж тайлбарлаж байна. Энэ талаар холбогдох эрх бүхий байгууллагын албан ёсны тайлбар гаргуулах нь зүйтэй.	Биелсэн. Монголбанк нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу Санхүүгийн тайлагналын Олон Улсын стандартад нийцүүлэн бэлтгэдэг тул тус стандартын дагуу цэвэр орлогыг тодорхойлж, тайланд тусгадаг. Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.4 дэх хэсэг нь тус хуулийн 38 дугаар зүйлд заасан Монголбанкны цэвэр орлогыг хуваарилах дүнг тодорхойлоход мөрдөгддөг. Төв банк (Монголбанк)-ны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай 2018 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн хуулиар “37.1.4/гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө, өр төлбөрийн ханшийн зөрүүнээс үүссэн цэвэр ашгийг холбогдох санд хуваарилах” гэсэн заалтыг нэмсэн.
2018 оны санхүүгийн тайланд өгсөн зөвлөмж		
3.	Эрдэнэсийн санд хөрөнгөөр бүртгэлтэй байгаа 1925 оны мөнгөн зоосыг Эрдэнэсийн сангийн хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгэсэн үйл ажиллагааг холбогдох хууль, тогтоомж болон СТОУС-д нийцүүлэх арга хэмжээ авах. (2019, 2020, 2021 онуудад дахин өгөгдсөн)	Хийгдэж байгаа. Эрдэнэсийн сан дахь 1925 оны мөнгөн зоосыг Эрдэнэсийн сангийн тухай хуулийн дагуу ангилж бүртгэсэн бөгөөд 2017 онд Олон Улсын хөндлөнгийн үнэлгээний MAD байгууллагаар үнэлүүлсэн. Тус байгууллагын үнэлгээний аргачлалын дагуу эдгээр зоосны зах зээлийн үнийн судалгааг (self assessment) НУСЗЗГ-аас жил бүр хийж байна. Эрдэнэсийн сангийн тухай хуулийн дагуу Банк нь эрдэнэсийн санд багтах хөрөнгийг орлогодох эрхтэй ба Банкны дотоод бодлого, журмын дараах шаардлагыг хангасан тохиолдолд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар баталж, Эрдэнэсийн сангийн хөрөнгө гэж үздэг. Үүнд: • Тухайн үнэт зүйлийн ач холбогдлын зэргээс хамаарч Соёлын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх Түүх, соёлын дурсгалт зүйлийн зэрэглэл, үнэлгээ тогтоох мэргэжлийн зөвлөлийн тодорхойлолттой байх, • Үнэт зүйл нь эрдэнийн чулуу болон үнэт металаар хийгдсэн бол итгэмжлэгдэж, хүлээн зөвшөөрөгдсөн лабораторийн сорилтын дүгнэлттэй байх, • Үнэт зүйлийн түүх, соёлын өндөр ач холбогдолтой болохыг батлах Эрдэнэсийн сангийн мэргэжлийн зөвлөлийн санал, дүгнэлт гэх мэт тухайн чиглэлийн мэргэжилтний тодорхойлолт, судалгааны болон бусад баримттай байх. Эрдэнэсийн санд 2,053,613 ширхэг зоосон мөнгөн тэмдэгт байгаагаас 2018-2021 оны хугацаанд Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар ажлын хэсэг байгуулан 1925 оны 1 төгрөг, 50, 15, 10-тын зоосон мөнгөн тэмдэгтийг түүвэрчлэн тоолох ажлыг гүйцэтгэсэн бөгөөд тоо ширхэг бүрэн таарч дутагдалгүй байна.
4.	Банкны хөрөнгийн эх үүсвэр нэмэгдэж байгаа нөхцөлд хүүгийн орлого жил бүр буурсан мөн	Биелсэн. НУСЗЗГ, МБГ, СБГ-аас хүүний зарлага өсч буй шалтгааныг судлан удирдлагуудад тухай бүр танилцуулж ажилласан. Танилцуулга, судалгааны гол үр дүнгээс үзэхэд банкны хүүгийн зарлага өсч

	хүүгийн зарлага өсч байгаагийн шалтгааныг судалж, холбогдох арга хэмжээ авах нь зүйтэй.	буй шалтгаан нь Сангийн яамнаас 2017 оны хоёрдугаар хагасаас эхлэн Засгийн газрын үнэт цаас гаргааа зогсоосон. Улмаар банкууд зохистой харьцааны шалгуур үзүүлэлтээ хангах, хөрөнгийн багцын удирдлагад шаардагдах эрсдэлгүй үнэт цаасыг Төв банкны үнэт цаасаар бүрдүүлэхээс өөр сонголтгүй болсон тул Төв банкны үнэт цаасны үлдэгдэл өссөн бөгөөд хүүгийн зарлага өсөхөд нөлөөлсөн.
<i>2019 оны санхүүгийн тайланд өгсөн зөвлөмж</i>		
5.	Банкны активын эрсдэлийг үнэлэх, хүлээж болох алдагдлын тооцоог хийх аргачлалын асуудлаар жил бүр хараат бус аудитын байгууллагаас өгч байгаа зөвлөмж давтагдаж байгааг анхаарч, аргачлал, журмыг шинэчлэх нь зүйтэй байна.	Бнелсэн. Тус зөвлөмжийн хүрээнд “Санхүүгийн хөрөнгийн эрсдэлийн үнэлгээний заавар”-ыг шинэчлэн боловсруулж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн А-340 дүгээр тушаалаар батлуулан, үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж байна.
<i>2020 оны санхүүгийн тайланд өгсөн зөвлөмж</i>		
6.	Банкны алдагдал жилээс жилд өссөөр 2020 оны эцэст 4.3 их наяд төгрөгт хүрээд байгаад Банкны удирдлага дүгнэлт хийж, 2021 оноос Алдагдлыг бууруулах дунд хугацааны хөтөлбөртэй ажиллаж /арилжааны банкны дампуурлаас үүсэх эрсдэл, хүүгийн орлого, зардлын зөрүүгийн алдагдал, улс төрний хүчин зүйлээс үүсэх эрсдэлийг бууруулах улмаар арилгах зэргээр/, цаашид ашигтай ажиллах боломжийг бүрдүүлэх нь зүйтэй. <i>/2021 онд өгөгдсөн зөвлөмж /</i>	Бнелсэн. Монголбанкны зүгээс банкуудтай байгуулж буй хэлцэл, олгож буй санхүүжилтийг бодлогын хүүнээс багагүй байх зарчмыг баримтлан ажиллаж байна. Тухайлбал, • Санхүүжилтийн хүү нь бодлогын хүүнээс багаар олгогддог ипотекийн зээлийн хөтөлбөрийг Монголбанкаас Засгийн газарт шилжүүлэхээр холбогдох бэлтгэл ажлыг хангаад байсан боловч Цар тахлын тухай хууль батлагдсанаар Монголбанк хөтөлбөрийг үргэлжлүүлэхээр болсон. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлд хөтөлбөрийг Засгийн газарт шилжүүлэхээр тусгаж, холбогдох бэлтгэлийг хангаж байна. • Монголбанк репо нөхцөлөөр зээл худалдан авах хэлцлийг Монгол Улсын хөгжлийн банкттай /МУХБ/ байгуулсан тохиолдолд үүсч болзошгүй эрсдэлийг тодорхойлж, МУХБ-тай репо нөхцөлөөр зээл худалдан авах хэлцлийг байгуулаагүй, • Монголбанкны эзэмшиж буй Шунхлай Групп ХХК-ийн гаргасан өрийн бичгийн хугацааг сунгах /эргэн төлөлтийн эрсдэл/ хүсэлтийн хүрээнд өрийн бичгийн хугацааг сунгахаас татгалзах, эсвэл өрийн бичгийн хүүг нэмэгдүүлэх, зах зээлийн хүүтэй уях түүнчлэн өрийн бичгийн хугацааг сунгасан тохиолдолд Монголбанкны тайлан тэнцэлд нэмж бүртгэх эрсдэлийн сангийн хэмжээг тооцож, Шунхлай групп ХХК-ийн өрийн бичгийн эргэн төлөлтийн хуваарьт өөрчлөлт оруулж, үлдэгдэл төлбөрийг 2025 оны 11 дүгээр сарыг хүртэлх хугацаанд хагас жил тутамд 8 удаа тэнцүү хуваан төлөх тухай хүсэлт ирүүлснийг Монголбанкны зүгээс хүлээн авч, хүүг 9.16% болгон гэрээнд нэмэлт өөрчлөлтийг оруулсан, • Монголбанкны эзэмшиж буй ХХБ-ны гаргасан өрийн бичгийн үндсэн болон хүүгийн төлбөрт 166,382,465,753.42 төгрөгийн вексель бичүүлэн авсан, • Алт-2 хөтөлбөрийн хүрээнд олгосон санхүүжилтийн барьцаа хөрөнгийн хугацаа нь санхүүжилтийн хугацаанаас өмнө дуусч, тодорхой хугацаанд Монголбанкны олгосон санхүүжилт барьцаагаар хангагдахгүй байх нөхцөл үүссэн тул барьцаанд авч буй үнэт цаасны эргэн төлөгдөх хугацааг олгосон санхүүжилтийн хугацаанаас урт байхад анхаарч арилжааны банкуудтай байгуулсан санхүүжилтийн гэрээнд өөрчлөлт оруулан богино хугацаат барьцаат хөрөнгийн хүсэлт болон бүртгэх үйл ажиллагааг цахимжуулсан.